

10.26사태, 10.26사건: 10 дугаар сарын 26-ний хэрэг нь 1979 оноос хойш ардчиллыг шаардах ард түмний дуу хоолой өндөрсөж эхэлжээ. Юшинь тогтолцоо (유신체제)-нд дургүйцсэн эсэргүүцэл нь Ким Йөн сам (김영삼) гишүүнийг хөөгдсөн үйл явдалтай зэрэгцэн Пүсань, Масань хотод гарч эхэлжээ. Юшинь-ийн засгийн газар онц байдал зарлаж, цэрэг армийг бэлэн байдалд байлган Пүсань, Масань хотын ардчиллын шаардлагыг цэргийн хүчээр дарах гэж оролдсон боловч эцэст нь 10 дугаар сарын 26-ний хэрэг явдал болж, Юшинь-ийн дэглэмийг зогсоожээ. Пак Жөн хый ерөнхийлөгч болон Мэдээллийн Төв Штабын дарга Ким Жай гю (김재규) нар Пүсань, Масань-ийн бослогыг дарах талаар санал зөрөлдөж, энэ үеэр ерөнхийлөгчийн томилсон Мэдээллийн Төв Штабын дарга ерөнхийлөгчийг гар буугаар хөнөөсөн хэрэг гарчээ.

3.1 운동,三一運動, March 1st Movement: 3 дугаар сарын 1-ний хөдөлгөөн: 1918

оны сүүлээс Чхөндо-гийн шашин (천도교), христ, бүддийн шашины номлогчид, мөн хэвлэл мэдээллийн болон боловсролын салбарын үндэсний төлөөлөгчид тусгаар тогтнолын тунхаглалын талаар зөвлөлдөн хэлэлцжээ. 1919 оны 1 дүгээр сарын орчимд тусгаар тогтнолын тунхаглалыг өрнүүлж байсан үндэсний болон оюутны төлөөлөгчид уулзаж, 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Тхабгол (탑골) нэртэй цэцэрлэгт хүрээлэнд “Тусгаар тогтнолыг тунхаглах ёслол” хийхээр тохиролцжээ. Харин үндэсний төлөөлөгчид маргааш оюутан, иргэд олноор цугларвал тэнд цугларсан хүмүүсийн сэтгэл хөдлөлийг дагаж олныг хамарсан үймээн самуун гарч болзошгүй гэсэн шалтгаанаар тусгаар тогтнолыг зарлах ёслолыг тусад нь хийхээр болжээ. Үндэсний төлөөлөгчид 3 дугаар сарын 1-нд Жонро (종로) гудамжин дахь Тхай хва гуань (태화관) нэртэй хоолны газар цугларч, тусгаар тогтнолоо зарлах ёслол хийсний дараа Японы эрх баригчдад бууж өгч, баривчлагджээ. Үндэсний төлөөлөгчид төлөвлөгөөгөө өөрчилсөн хэдий ч Тхабгол цэцэрлэгт хүрээлэнгийн жагсаал товлосон ёсоороо өрнөжээ. Оюутнууд болон иргэд төрийн далбаагаа мандуулж, “Солонгос улсын тусгаар тогтнол мандтугай” хэмээн дуу хадааж байжээ. Тусгаар тогтнолын хөдөлгөөнд оролцогчдын тоо маш хурдацтай нэмэгджээ. Энэ өдөр Сөүлийн жагсаалтай хамт Пхйөнян (평양),

Ыйжү (의주), Сөньцөнъ (선천), Вөнъсанъ (원산) зэрэг хотуудад мөн адил тусгаар тогтнолын хөдөлгөөн өрнөж байжээ. 1919 оны 3 дугаар сарын 1-нд Тхабгол цэцэрлэгт хүрээлэнд цуурайтаж байсан үндэсний тусгаар тогтнолын төлөөх дуу Сөүл зэрэг томоохон хотуудаас эхлээд жижиг хотууд, цаашлаад хөдөө орон нутгийн зах хүртэл өргөн тархацтай үргэлжилж байжээ. Тусгаар тогтнолын хөдөлгөөнийг 3 дугаар сарын эхээр нийслэл хот Сөүл болон Кйөнги муж (경기도), Хванхэ муж (황해도), Пхйөннанам (평안남) муж зэрэг шашины байгууллагын үндэс суурь болсон газруудад шашины удирдагчид болон оюутнууд, мөн жижиг дунд үйлдвэрийн худалдаачид удирдан явуулж байжээ. 3 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн тус хөдөлгөөн аажмаар мужийн хэмжээнд тархах болжээ. Харин 3 дугаар сарын сүүлчээс 4 дүгээр сарын эхэн хүртэл орон даяар нэлээд далайцтай өрнөж, эсэргүүцлийн жагсаал дээд цэгтээ хүрчээ. Уг хөдөлгөөнд оролцсон тариачид болон ажилчид хөдөлгөөнийг аажимдаа удирдаж эхэлсэн бөгөөд, эсэргүүцлийн байдал даамжирч хүчирхийлэлгүй байх хүрээг нэгэнт давахаас өөр аргагүй байдалд хүрч байжээ. Японы эзэнт гүрэн бүхий л аргаа хэрэглэн энэхүү эсэргүүцлийн жагсаалыг даржээ. Солонгосын хойгт байрлаж байсан хоёр ч дивизийн цэрэг болон олон тооны цэрэг цагдаа нараас гадна Японоос хүртэл цэргийн хүч татаж эсэргүүцлийн жагсаалыг даржээ. Тухайн үед Японы империалистууд хаа сайгүй аллага үйлдэж, яргалал явуулж байжээ. Зөвхөн нэг жишээг дурдахад, Кйөнги мужийн Хвасөн (화성) хотын аллага бөгөөд, тосгоны оршин суугчдыг христийн цуглаанд бөөнд нь түгжээд бүгдийг нь буудаж алсан аллага юм. 3 дугаар сарын 1-ний хөдөлгөөн түймэр мэт дүрэлзэж байсан хэдий ч Японы империалистуудын харгис яргалалаас болж 4 дүгээр сарын сүүлчээр аажимдаа намжих болжээ. 3 дугаар сарын 1-ний хөдөлгөөн бол Дэлхийн 1-р дайн болон ЗХУ-ын хувьсгалын дараахан өрнөсөн учир "Дэлхийн өөрчлөлт шинэчлэлтийн уур амьсгал"-ын сурталчилгаа болсон ч нөгөө талаараа Япон болон Чосөнъ үндэстний хоорондох үндэсний зөрчилдөөн гүнзгийрэх болсон хамгийн том шалтгаан болжээ. Тийм ч учраас 3 дугаар сарын 1-ний хөдөлгөөн бол олон тооны хүмүүс оролцсон Японы эсрэг хөдөлгөөн болон өргөжиж чаджээ. Тус хөдөлгөөнөөр тусгаар тогтнолоо олж чадаагүй хэдий ч Чосөнъ

үндэстний хувьд тусгаар тогтнолын төлөөх хүсэл зоригоо дэлхий нийтэд ил болгосон үйл явдал ажээ. Түүнчлэн тусгаар тогтнолын хөдөлгөөнд оролцсон тариачид, ажилчдын ухамсар өмнөхөөсөө өөрчлөгдсөнөөр 1920-иод онд ард түмний хөдөлгөөн өрнөх учир шалтгаан болж байжээ. 3 дугаар сарын 1-ний хөдөлгөөн нь Бүгд Найрамдах Солонгос Улсын Түр Засгийн газрыг байгуулах үр дүнд хүрсэн бөгөөд, мөн дэлхийн 1-р дайны дараа дайнд ялалт байгуулсан хэд хэдэн орнуудад өрнөсөн империализмын эсрэг хөдөлгөөнд ихээхэн нөлөө үзүүлжээ. Өөрөөр хэлбэл, дэлхийн 1-р дайны дараа хамгийн анх Хятад улсад Хятад улсын империализмын эсрэг үндэстний хөдөлгөөн 5 дугаар сарын 4-нд өрнөсөн бол Энэтхэг улсад Английг эсэргүүцэх хөдөлгөөн өрнөжээ. Эдгээр хөдөлгөөнүүдэд 3 дугаар сарын 1-ний хөдөлгөөн ихээхэн нөлөөлсөн гэдэг ажээ.

3.15 부정 선거, March 1960 South Korean presidential election, 3 дугаар сарын 15-ны шударга бус сонгууль бол 1960 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Эрх чөлөөний нам төрийн эрх барьж байгаадаа тулгуурлан сонгуулийн их луйвар хийсэн 4 дэх ерөнхийлөгчийн сонгууль, 5 дахь дэд ерөнхийлөгчийн сонгууль юм. 1959 онд И Сын мань нэр дэвшихгүй гэсэн мэдэгдлээ цуцалж, дөрөв дэх удаагаа нэр дэвшинэ гэдгээ зарлахад Эрх чөлөөний намын засгийн газар нам дээр төвлөрсөн төв болон орон нутгийн засаг захиргаа, залуучуудын байгууллага болон бусад гадны байгууллагыг хяналтандаа авч шударга бус сонгуульдаа нарийн бэлдэж байжээ. Ардчилсан намаас нэр дэвшигч Жо Бйөн ог (조병옥) гэнэт өөд болж И Сын мань сонгогдох нь гарцаагүй болсон хэдий ч дэд ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч И Ги бүн-ийг сонгуульд ялуулахын тулд урьдчилсан санал хураалт, нээлттэй санал хураалт, санал хураалтын дүнг хуурамчаар үйлдэх гэх мэт урьдчилан бэлдсэн зүйл бүрийн аргыг хэрэглэснээр шударга бус луйврын сонгууль ямар ч эргэлзээгүйгээр явагджээ. Илэрхий байсан шударга бус байдлыг эсэргүүцсэн үндэсний эсэргүүцэл эхэлж, улмаар 4 дүгээр сарын 19-ний хувьсгалд хүргэжээ.

38:삼팔선, 三八線, 38th parallel north, 38 өргөрөг, хойд параллель бол Дэлхийн 2-р дайн дууссаны дараа АНУ болон ЗХУ, Солонгосын хойгийг хуваан эзлэхийн

тулд тогтоосон цэргийн хилийн шугам ажээ.

3선 개헌 三選改憲, гурав дахь удаагаа ерөнхийлөгчөөр сонгогдох боломжийг нээсэн үндсэн хуулийн өөрчлөлт гэдэг нь 1969 онд Пак Жөн хый-гийн дэглэм төрийн эрх барих хугацаагаа сунгахын тулд ерөнхийлөгч гурав дахь удаагаа сонгогдох боломжтой болгох үүднээс үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан БНСУ-ын үндсэн хуульд оруулсан зургаа дахь өөрчлөлт аж. Ерөнхийлөгчийг гурав дахь удаагаа улируулан сонгох боломжтой үндсэн хуулийн өөрчлөлтийг 9 дүгээр сарын 14-нд Үндэсний Ассамблей баталж, 10 дугаар сарын 17-нд ард түмний санал асуулгаар баталгаажуулжээ. Үүний үр дүнд Пак Жөн хый 1971 оны 7 дахь ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж, дахин сонгогдсоноор Юшинь тогтолцоо болон урт хугацааны засаглал үргэлжлэх боломжтой болжээ.

4.19 혁명, 四·一九运动, April Revolution, April 19 Revolution, **4 дүгээр сарын 19-ний хувьсгал** БНСУ-ын ард иргэд 1960 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр хувьсгал хийжээ. 3 дугаар сарын 15-ны өдрийн шударга бус сонгуулийг эсэргүүцсэн жагсаалаас эхлэлтэй тус хувьсгал нь Масань (마산) хотод жагсаалд оролцож байсан Ким Жү йөл (김주열) оюутан нулимс асгаруулагчийн суманд оногдож нас барсан байсныг олж илрүүлсэн нь орон даяар цацагдсанаар хувьсгал хийхэд хүргэжээ. 4 дүгээр сарын 19-ний өдөр эхэлсэн жагсаал 4 дүгээр сарын 26-ны өдөр И Сын мань (이승만) ерөнхийлөгч огцорч Хавай (하와이) руу дүрвэсэнээр өндөрлөжээ. 4 дүгээр сарын 19-ний хувьсгал бол Солонгос улсын түүхэнд анх удаа ард түмний хүчээр төрийн эрхийг өөрчилж Ардчилсан үзлийг бий болгосон түүхэн үйл явдал ажээ. Ард түмэн өөрсдийн гараар улс төрийг өөрчилж түүхийг бүтээж чадсандаа бахархалтай байжээ. 4 дүгээр сарын 19-ний хувьсгалаар шилжилтийн үеийн түр засгийн газар байгуулагдаж 7 дугаар сарын 29-ний өдөр бүх нийтийн сонгууль болж сөрөг нам болох Ардчилсан нам засгийн эрхийг авчээ. Үндсэн хуулиндаа өөрчлөлт оруулж ерөнхийлөгчийн засаглалтай засаглалын хэлбэрийг парламентийн засаглал

болгон өөрчилжээ. Ерөнхийлөгчөөр Юнь Бо сөнъ (윤보선) сонгогдож ерөнхий сайдаар Жан мйөнъ (장면) томилогджээ.

4.3 사건, 濟州四·三事件, Jeju April 3 incident, Jeju uprising: **Чэжү-гийн 4 дүгээр**

сарын 3-ны хэрэг гэдэг нь 1947 оны 3 дугаар сарын 1-ний өдөр эхэлж 1948 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр болсон үймээн самуун бөгөөд 1954 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл Чэжү аралд өрнөсөн зэвсэгт мөргөлдөөн ажээ. Чэжү хотын оршин суугчид энэ мөргөлдөөнд маш их золиослогдсон учир ийнхүү нэрлэжээ. Чэжү-гийн 4 дүгээр сарын 3-ны хэргийн бодит байдлыг тодорхойлох, хохирогчдын нэр алдрыг сэргээх хорооноос гаргасан баримтанд тулгуурлавал тус зэвсэгт мөргөлдөөнд хохирсон энгийн иргэдийн тоо 14.442 бөгөөд, үүнээс босогчид нь 7.624, зэвсэгт хүчнийхэн 1.528 хүн байжээ. Түүнчлэн энгийн иргэдээс 25.000-30.000 хүн, дарангуйлагчдаас 1.091 хүн амь үрэгдсэн гэх тоо баримт байдаг ажээ.

5.16 군사 정변, 五一六軍事政變, May 16 military coup d'état, **5 дугаар сарын 16-ны**

цэргийн эргэлт, цэргийн засаглал: Хошууч генерал Паг Жөн хый (박정희) болон Офицериин сургуулийн 5, 8-р төгсөлтийн залуу офицерууд 1961 оны 5 дугаар сарын 16-ны өдөр төрийн эргэлт хийжээ. 4 дүгээр сарын 19-ний хувьсгалаас өмнө төрийн эргэлт хийхээр төлөвлөж байсан эдгээр цэргүүд төрийн эргэлт хийж, засгийн газар болон их хурлыг тарааж, цэргийн засаглалаа тогтоожээ. НҮБ-ын командлагч ардчиллын чухал ач холбогдлыг онцолж, тэднийг цэрэгт буцаж ирэхийг шаардсан хэдий ч ерөнхий сайд Жан мйөнъ (장면)-той зөрчилдөж байсан Юнь Бо сөнъ(윤보선) ерөнхийлөгч төрийн эргэлт хийсэн цэргийн хүчийг эргүүлэн татахаас илүүтэй эдгээр цэргүүд бол дэглэмийн өөрчлөлтийг бодитоор хийсэн гэж хүлээн зөвшөөрсөн тул тэд 1963 он хүртэл 2 жил хагасын хугацаанд засгийн газрыг удирджээ. Цэргийн засгийн газар нь эхэндээ хөдөө тосгодын өндөр хүүтэй өрийг цэгцлэх, хээл хахуульд автагдсан бизнесменүүд болон улс төрчдийг баривчлах зэрэг нийгмийн шударга бус байдлыг арилгахын тулд бодлого явуулж байсан боловч цаг хугацаа өнгөрөх тусам эрх ашиг, ашиг сонирхолдоо хөтлөгдөн эрх мэдэлтнүүдтэй гар нийлэх болжээ. Баривчлагдсан бизнесмэнүүдийн ихэнх нь

суллагдсан бөгөөд, нийгмийн шинэчлэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө бүтэлгүйтэж, иргэний засаглалд шилжүүлэх хугацааг сунгах гэж байгаад АНУ-тай зөрчилдөхөд хүрчээ. Эцэст нь цэргийн засгийн газар АНУ-ын дарамт шахалтаас болж 1963 оны сүүлээр төрийн эрхийг иргэний засаглалд шилжүүлэх сонгууль явуулжээ. Энэ сонгуульд цэргийн дүрэмт хувцсаа тайлсан цэргийн засгийн газрын голлох хүмүүс цөөнгүй сонгогджээ. Цэргийн эргэлтийг удирдсан Паг Жөн хый сонгуульд ялалт байгуулж ерөнхийлөгч болсноор И Сын мань-ын засгийн газартай адил дарангуй засаглал тогтох болжээ.

5.18 민주화 운동, 光州民主化運動, Gwangju Uprising: 5 дугаар сарын 18-ны

Кванжү (광주)-гийн ардчиллын хөдөлгөөн нь Кванжү хотын иргэд болон өвөр Чолла муж (전라남도)-ийн иргэд 1980 оны 5 дугаар сарын 18-ны өдрөөс 5 дугаар сарын 27-ны өдөр хүртэл өрнүүлсэн ардчиллын төлөөх хөдөлгөөн бөгөөд, ардчилсан засгийн газрыг хурдан байгуулах, аюулгүй байдлын командлагч Чөнъ Дү хванъ (전두환) болон шинэ цэргийн бүлгэмийг огцруулах, онцгой байдал зарлах зарлигийг цуцлах зэрэг шаардлага тавьж жагссан БНСУ-ын ардчилсан хөдөлгөөн ажээ. 1979 онд Пүсанъ (부산) болон Масанъ (마산) хотод эхлэлээ тавьсан бөгөөд, 1980 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Кванжү хотод ардчилалын төлөөх томоохон хөдөлгөөн өрнүүлжээ. Хотын иргэд болон оюутнууд ардчилалыг шаардаж хүчирхийлэл хэрэглэлгүйгээр жагсаалыг эхлүүлсэн хэдий ч жагсаалыг дарахаар дайчлагдсан цэргүүд жагсагчид рүү гал нээснээс болж хүний амь эрсдэж хүнд хэцүү байдал үргэлжилжээ. Кванжү хотын иргэд өөрсдийн амь насыг хамгаалахын тулд буу барихад хүрсэн бөгөөд, Кванжү хотоос цэргийн армийг хөөн гаргажээ. Энэхүү нөхцөл байдлыг хараад Чөнъ Дү хванъ-ы засгийн газар хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээ, мэдээллийг хатуу хянахын зэрэгцээ Кванжү хотыг тусгаарлажээ. Мөн хөдөлгөөнд оролцсон хүмүүсийг цэргийн хүчээр дарсан бөгөөд, энэ үеэр 200 гаруй хүн амь үрэгджээ.

6.15 남북 공동선언, 南北共同宣言, June 15th North–South Joint Declaration, 6 дугаар сарын 15-ны Өмнөд, Умард Солонгосын хамтарсан тунхаглал гэдэг нь

Өмнөд Солонгосын ерөнхийлөгч Ким Дай жүн (김대중) болон Умард Солонгосын Улсыг Батлан Хамгаалах Хорооны дарга Ким Жөн ил (김정일) нарын албан ёсны уулзалтын үр дүнд гаргасан тунхаглал ажээ. Энэхүү тунхаглалд:

1. Нэг үндэстэн болох Өмнөд, Умард хоёр улсын ард иргэд хүчээ нэгтгэн хоёр улсаа нэгтгэх асуудлыг бие даан шийдвэрлэхээр тохиролцжээ.
2. Өмнөд, Умард хоёр улсын талаас улс орноо нэгтгэх тухай саналд нийтлэг зүйл байгааг аль аль нь хүлээн зөвшөөрч, цаашид энэ чиглэлд нэгдэж ажиллахаар тохиролцжээ.
3. Энэ жил 8 дугаар сарын 15-ны өдөр дайнаас болж салж хагацсан гэр бүл, төрөл төрөгсдийг харилцан солилцож хооронд нь уулзуулснаар урт хугацааны турш өөрчлөгдөөгүй асуудлыг шийдвэрлэх зэрэг хүмүүнлэгийн асуудлаа аль болох хурдан шийдвэрлэхээр тохиролцжээ.
4. Өмнөд болон Умард хоёр улс эдийн засгийн хамтын ажиллагаагаар үндэсний эдийн засгаа тэнцвэртэй хөгжүүлж, нийгэм, соёл, спорт, эрүүл мэнд, байгаль орчин зэрэг олон салбарын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлж, харилцан итгэлцлээ бэхжүүлэхээр тохиролцжээ.
5. Өмнөд, Умард хоёр улс эдгээр хэлэлцээрүүдийг богино хугацаанд ажил хэрэг болгох үүднээс хоёр улсын яриа хэлэлцээрийг аль болох хурдан явуулахаар тохиролцжээ.
6. Ерөнхийлөгч Ким Дай жүн Улсыг батлан хамгаалах хорооны дарга Ким Жөн ил-ийг Сөүлд айлчлахыг эелдэгээр урьсан бөгөөд, Ким Жөн ил дарга цаг хугацааны хувьд тохиромжтой үеийг сонгон Сөүлд айлчлахаар тохиролцжээ.

6.29 민주화 선언, 六二九宣言, June 29 Declaration, 6 дугаар сарын 29-ний Ардчиллын тунхаг гэдэг нь 1987 оны 6 дугаар сарын 29-нд шинэ цэргийн эрхтнүүд ардчиллыг тунхагласан явдал ажээ. Өнгөрсөн хугацаанд улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглож байсан сөрөг хүчний улстөрчдийн улс төрийн үйл ажиллагааг баталсан бөгөөд, энэ өдөр ерөнхийлөгчийг шууд сонгох сонгуулийн тогтолцоонд шилжих үндсэн хуулийн өөрчлөлтийг зарлажээ. 6 дугаар сарын 29-ний тунхаг нь хэдийгээр ардчиллыг бүрэн гүйцэд явуулна гэсэн үг биш байсан хэдий ч ардчилсан тогтолцоог бий болгох,

хөгжүүлэхэд чухал учир шалтгаан болж байжээ. Энэ тунхаг нь 1961 оны 5.16-ны төрийн эргэлтээс хойш 27 жилийн хугацаанд анх удаагаа ард түмний хүчээр бүтсэн түүхэн мөч байжээ.

6 월 민주 항쟁, 六月民主抗爭, June Democratic Uprising, 6 дугаар сарын Ардчиллын хөдөлгөөн гэдэг нь 1987 оны 6 дугаар сард Чөнь Дү хвань (전두환) ерөнхийлөгчийн төрийн бодлогын эсрэг улс даяар өрнөсөн ардчиллын хөдөлгөөн ажээ. 1987 оны 4 дүгээр сард, Чөнь Дү хвань ерөнхийлөгч бүрэн эрхийн хугацаа нь нэг жил ч болоогүй байх үедээ үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах боломжгүй учир одоогийн мөрдөж буй тавдахь Бүгд Найрамдах улсын Үндсэн хуулийн дагуу дараагийн ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулж, эрх мэдлийг шилжүүлэх тухай тусгай мэдэгдэл хийж, улмаар ерөнхийлөгчийн шууд бус сонгуулийн тухай заалтыг хамгаалах байр суурьтай байгаагаа илэрхийлсэн нь ерөнхийлөгчийн шууд сонгуулиар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтэй хүмүүсийн эсэргүүцэлтэй тулгарчээ. Тухайн үед ихэнх хүмүүс ерөнхийлөгчийн шууд сонгуулийг сэргээх нь ардчилсан улс төрийн тогтолцооны бэлгэдэл гэж үздэг байжээ. Энэхүү тунхаглалаар далимдуулж институциональ сөрөг хүчин, ард түмний дундах ардчиллын хүчнүүд нэгдсэн фронт байгуулж, шууд сонгуулийн тогтолцооны тухай үндсэн хуульд өөрчлөлт оруулахаар Үндэсний хөдөлгөөний төв штаб байгуулжээ. Ингэснээр 1979 оны 12 дугаар сарын 12-ны цэргийн бослогоор эхэлсэн эзэрхэг үзлийн цэргийн дэглэм хар бараан түүх болон үлдэж, оронд нь барууны хэв маяг бүхий либерал ардчилал ялжээ. Энэхүү 6 дугаар сарын хөдөлгөөн нь ерөнхийлөгчийн шууд сонгуулийг хийхэд хүргэсэн төдийгүй үндсэн хууль болон засгийн газрын шинэчлэлд нөлөөлсөн үйл явдал байсан бөгөөд, түүнээс хойш Солонгосын нийгэмд ардчилал, эрх чөлөөний давалгаа эрчимтэй өрнөжээ. Энэ үйл явдалд тулгуурлан БНСУ-ын Үндсэн хуульд 9-р нэмэлт өөрчлөлт оруулсан нь өнөөг хүртэл Солонгосын улс төр, хууль эрхзүйн үйл ажиллагааны үндэс суурь болсоор байгаа ажээ. Түүнчлэн энэ хөдөлгөөн бусад ардчилсан хувьсгалаас ялгаатай нь харьцангуй тайван замаар цэргийн дарангуйллын засаглалыг түлхэн унагаж чадсанаараа дэлхий дахинд өндрөөр

үнэлэгдсэн иргэний бослого гэж хэлж болно. Иргэний бослого өрнөхөд ихэвчлэн төрийн эрх мэдлээ урвуулан ашигласан дотоодын самуун, цэргийн эргэлт, үймээн зэрэг цуст үйл явдлуудад хүргэдэг нь олонтаа байдаг ч 6 дугаар сарын хөдөлгөөний үеэр цагдаа болон жагсагчдын хооронд мөргөлдөөн гарсан хэдий ч аль аль нь аюулгүй байдлаа сайн хангасан байжээ. Тухайн үед энэ тухай сурвалжилахаар ирсэн гадаадын сэтгүүлчид хүртэл магтсан гэдэг. Тийм болохоор дэлхийн ардчилалын түүхэнд “Ардчилалыг авчирсан” гэдэг утгаараа 6 дугаар сарын хөдөлгөөнийг 4.19 өдрийн хувьсгал, 5.18 өдрийн ардчилалын хөдөлгөөнтэй адил ард түмний хүчээр бий болсон “Ардчилалын гурав дахь давалгаа” гэж нэрлэдэг ажээ.

7.4 남북 공동 성명, 南北共同声明, July 4 South–North Joint Statement, 7 дугаар

сарын 4-ний Өмнөд, Умард Солонгосын хамтарсан мэдэгдэл гэдэг нь 1972 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Өмнөд болон Умард хоёр улс Солонгосын хойгийн газар нутгийг хувааснаас хойш анх удаа улсыг нэгтгэх талаар харилцан тохиролцож зарласан мэдэгдэл ажээ. 1972 онд ерөнхийлөгч Пак Жөн хый-гийн удирдлагаар Тагнуулын төв газрын дарга И Хү раг (이후락) Умард Солонгос руу томилогдож Ким Ил сөн (김일성)-тэй уулзаж тусгаар тогтнол, энх тайван, үндэсний их эв нэгдэл гэсэн гурван зарчмын дагуу хууль тогтоожээ. Энэхүү хууль нь олон улсын хурцадмал байдлыг бууруулах, Америкын цэргүүдийг Солонгосоос гаргах тухай тунхаглах, мөн зэвсгийн өрсөлдөөнийг багасгах зорилготой байсан бөгөөд, түүнээс хойш Өмнөд, Умард хоёр улс нэгдлийн талаар яриа хэлэлцээр хийж улсынхаа эрх мэдлийн хүчийг бэхжүүлэхэд ашиглаж байжээ.

LG, 엘지, ЭЛЖИ (LG) групп-ыг үүсгэн байгуулсан хүн бол Кү Инъ хой юм. Кү Инъ хой эцгээсээ 2000 вон авч, 1931 онд Кйөнсаннам мужийн Чинъжү хотод дүү Чөл Хойгийнхоо хамтаар Кү Инъ хой гэдэг бөс барааны дэлгүүр нээжээ. 1940 оны 6 дугаар сард дэлгүүрээ хувьцаат компани болгон өргөжүүлж, загас, шинэ ургацын ногоо ч бас худалдаалдаг болжээ. 1945 онд Японы колониос чөлөөлөгдөхөд Кү Инъ хой дэлгүүрээ хааж, тэр оныхоо 11 дүгээр сард Пүсанъ хотын Нампо-донгийн ойролцоо шинэ компани байгуулжээ. Тэрээр 1947 онд

Кйёнсаннам мужийн Пүсань хотод “Lucky” нэртэй химийн үйлдвэрлэл (одоогийн LG химийн үйлдвэр) явуулдаг компани байгуулсан бөгөөд, "Lucky cream" гэх нэрээрээ алдартай "Дондон гүримү" хэмээх гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэн худалдаалж байжээ. Мөн БНСУ-ын анхны тосон түрхлэгт шүдний оо болох “Lucky” нэртэй шүдний оо үйлдвэрлэж байжээ. 1953 онд Сөүл хотод ажлын өрөөтэй болж, “Lucky” нэртэй компани байгуулан худалдааны бизнес эрхэлж эхэлсэн бөгөөд, улмаар 1958 онд “Goldstar” компани байгуулж дотооддоо радиог анх удаа үйлдвэрлэжээ. Түүнчлэн 1966 онд анхны хар цагаан зурагт үйлдвэрлэж эхэлжээ. 1969 онд компанийнхаа төв байрыг Сөүл хотын Жонно дүүргийн Кваньчөл гэх газар руу нүүлгэжээ. Тэр жилдээ Кү Инъ хой захирал өөд болж, 1970 онд түүний ууган хүү болох Санг Нам Кү Жа гйөн гэр бүлийн бизнесээ өвлөн авч, олон улсын үнэт цаасны компани байгуулан санхүүгийн салбарт ч хүч үзэх болсон бөгөөд, 1983 онд 'Lucky групп' нэртэй байсан компанийн нэрээ 'Lucky Goldstar групп' болгон өөрчилжээ. 1984 онд анх 'LG' гэх нэрийг хэрэглэж эхэлсэн бөгөөд 1980-аад оны сүүлээс эхлэн LG карт, LG twins зэрэг “LG” гэх нэр групп дотроо аажмаар өргөжиж эхэлжээ. 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн группын нэрээ “LG” болгон өөрчилснийхөө дараа “Lucky, Goldstar, Lucky Goldstar, Heesung, Bando, LG” зэрэг холимог нэртэй байсан салбар компани бүрийн нэрийг “LG” болгон нэгтгэжээ. 1998 онд хариуцлагатай удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, 2001, 2002 онд хуучин байсан “LG химийн үйлдвэр” болон “LG Electronics” компаниудаа “LGCI” болон “LGEI” нэртэй холдинг компани болгосны дараа 2003 онд хоёр компанийг нэгтгэж, “LG” гэх нэртэй нэгдсэн холдинг компани үүсгэн байгуулагджээ. 2004 онд Хө овогтны гэр бүлийн хүрээнд “GS Holdings” байгуулагдсан бөгөөд, 2005 онд 57 жил үргэлжилсэн хамтын бизнесийн харилцаагаа дуусгаж, Кү болон Хө овгийн гэр бүлүүд “LG групп”-ыг хувааснаар Хө овогтны гэр бүл “GS групп”-ыг удирдах болжээ. Үүнээс гадна хуваагдсан олон компани байгаа бөгөөд, эдгээр компаниудыг нэгтгэж нэрлэдэг нэр нь “LG групп” юм.

가묘, 家廟, (a family shrine) гэр бүлийн онгон гэдэг нь Чосөнъ улсын үеийн язгууртнуудын өвөг дээдсийнхээ сүнсийг залж, тахил өргөдөг өргөө ажээ.

가쓰라-태프트밀약, (The Katsura-Taft Agreement) **Кацура Тафтын гэрээ** гэдэг нь 1905 онд Филиппин улсыг АНУ, БНСУ-ыг Япон улс захирахыг зөвшөөрсөн агуулга бүхий Япон болон АНУ-ын хооронд нууцаар байгуулсан гэрээ юм. Өөрөөр 가쓰라 태프트 협정 гэж нэрийддэг ажээ.

간도 참변, 間島慘變, Gando massacre: **Каньдо-гийн аллага** гэдэг нь 1920 онд Японы цэргүүд Манж руу довтолж Каньдо нутагт амьдарч байсан солонгос хүмүүсийг олноор нь хөнөөсөн хэрэг ажээ. Өөрчлөлт шинэчлэлтийн аллага гэж мөн нэрлэдэг. 1920 онд Японы эзэнт гүрэн Чосөн-д байрлаж байсан Япон цэргүүдийг хүртэл Манжуур дахь Квантуны арми (관동군)-д нэгтгэн олон тооны албан ёсны цэргийн армийг Каньдо нутаг руу явуулж тусгаар тогтнолын армийг эрхшээлдээ оруулах нэрийдлээр тус нутагт амьдарч байсан гэм зэмгүй солонгосчуудыг хоморголон устгажээ.

간도 협약, 間島協約, Gando Convention: **Каньдо-гийн гэрээ** (конвенц) гэдэг нь Солонгос-Япон улсын хоёрдугаар хэлэлцээрийн дагуу Японы эзэнт гүрэн Их Хань эзэнт улсын дипломат эрхийг хууль бусаар булаан авсан үедээ хийсэн гэрээ бөгөөд, өөрөөр хэлбэл Японы эзэнт гүрэн 1909 оны 9 дугаар сарын 4-ний өдөр Чин улстай байгуулсан гэрээ ажээ. Энэхүү гэрээ нь Түмэн голыг Хань, Чин улсын хил болгон тогтоох, мөн Каньдо-гийн нутгийг Чин улсын газар нутаг гэж хүлээн зөвшөөрөх агуулгатай байжээ. Чин улс Каньдо нутгийн газар нутгийг манай улсын газар нутаг хэмээгээд, нэвтрэх хориотой болгон зарлаж, улмаар тэнд суурьшихыг хоригложээ. Тэр үеэс хойш Каньдо-гийн газар нутаг үржил шимгүй цөл болон хувирч, хилийн зааг тодорхой бус болсноор гадаад харилцаанд олон асуудал үүсч байжээ. Иймд Чосөн, Чин улсууд 1712 онд хилийн заагийн асуудлыг тодорхой болгох үүднээс Пэгдү уулын оройд чулуун хаалга босгосон боловч "Зүүн талаараа Түмэн голтой хиллэдэг" гэсэн тайлбарыг өөр өөр тайлбарласнаас болж маргаан үүсэхэд хүрчээ. Каньдо-гийн гэрээнд гарын үсэг зурсан тэр өдөр Японы эзэнт гүрэн Солонгосын хойгоос Өмнөд Манжуурын чиглэл рүү төмөр зам барих эрхийг Чин улсаас олж авах агуулга багтсан Манжийн 5 хэлэлцэх асуудлын гэрээг хийжээ. 1907 оны 8 дугаар сарын 23-ний өдөр Японы эзэнт гүрэн Каньдо нутаг руу цэрэг, цагдаа явуулж Йонжөн (용정(龍井) хотод Хянан захирах яам,

Каньдо-гийн цагдаагийн хэсгийг байгуулжээ. Харин энэхүү Каньдо-гийн гэрээгээр Японы эзэнт гүрэн Каньдо нутгийн газар нутгийг Чин улс захирахыг хүлээн зөвшөөрч Хянан захирах яам болон цагдаагийн хэсгээ татан буулгажээ. Энэ үеэс Каньдо нутагт амьдардаг Их Хань эзэнт улсын иргэдийг Чосөнх үндэстэн гэж нэрлэх болжээ.

간도, 間島, Jiāndǎo, Gando: **Каньдо** гэдэг нь Түмэн гол (두만강)-ын хойд хэсэгт орших Хойд Каньдо (북간도) болон Зүүн Каньдо (동간도) юм. Каньдогийн сав газар нь цаг хугацааны явцад хэсэг бүлэг хүмүүсийн ашиг сонирхлоос хамаарч бага багаар өргөжиж байжээ. Ялу мөрний (압록강) эх болон Түмэн голын хойд хэсгийг Чосөнх хүмүүсийн амьдарч байсан газар нутаг гэдэг бөгөөд Каньдогийн газар нутгийн талаар санал зөрөлдөөн их байдаг байжээ. Каньдо гэдэг нь одоогийн Янбиан (연변) нэртэй солонгос үндэстний өөртөө засах муж ажээ. Түмэн голоос хойшхи Янбиан мужийн нутгийг Зүүн Каньдо, түүнээс баруун зүгт байрлах Ялу мөрний хойд хэсгийг Баруун Каньдо гэж нэрлэдэг байжээ. Хятадын зүүн хойд нутагт байрлах Мудан хот (무단장)-ын Мудан гол (시무단강)-ын ойр орчмын Каньдогийн газар нутгийг Хойд Каньдо гэж нэрлэж байжээ. 19-р зууны сүүл үед, Чосөнх улс болон Чин улс (청나라) Пэгдү уул (백두산)-ын орой дээр хилийн зурвасын тэмдэг болох чулуун хаалга хийсэн бөгөөд, тэрхүү хаалган дээр бичсэн "토문(土門)" гэх чулуун хаалга гэсэн утгатай бичгийг хоёр улс тус бүртээ өөр өөр тайлбарласан нь энэ нутаг, өөрөөр хэлбэл Зүүн Каньдо-д харьяалагдах газар нутгийн талаарх асуудал үүсчээ. Тэр үед Чосөнх улс уулын орой дээрх "토문(土門)" гэх бичиг бол Түмэн гол (두만강)-оос тусдаа гол” хэмээх утгатай гэсэн байр суурийг илэрхийлж байсан бөгөөд, 1903 онд И Бөм йүнх (이범윤)-ийг Каньдогийн захирагч болгосноор Каньдо нутгийг ноёрхох оролдлого нь ил болж байжээ. 1905 онд Япон улс Их Хань эзэнт улсын дипломат эрхийг булаан авах зорилготой албадан гэрээ хийсэн бөгөөд, тэр гэрээгээр Их Хань эзэнт улсын дипломат эрхийг булаан авсан Японы империализм 1909 онд Чин улстай Каньдо-гийн гэрээ хэлэлцээр хийж Өмнөд Манжуур (남만주)-т төмөр зам барих эрх, Фүшүнх (푸순)-ийн нүүрсний уурхайн олборлолт явуулах эрхийг авахын тулд Каньдо-гийн нутгийг Чин улсын мэдэлд шилжүүлэн өгч байжээ.

간 의, 簡儀, **каньый хэмээх од судлах багаж** нь тэнгэрийн байдлыг ажиглах багаж бөгөөд өнөөдөр бидний хэрэглэж буй өнцөг хэмжих шугамтай адил бүтэцтэй ажээ. Чосөнъ улсыг байгуулсан эрх баригчид ард түмний ахуй амьдралыг тогтвортой байлгах үүднээс үйлдвэрлэлийг дэмжиж байсан ба үүний тулд шинжлэх ухааны салбарт тулгуурлах ёстой гэж үзэж байсан төдийгүй одон орон судлал нь төрийг захирах үндсэн ухаан гэж үздэг байжээ. Когүрйө улсын үеийн одон орны зурагт тулгуурлан, чулуун дээр сийлж зурсан зураг нь тухайн үеийн одон орон судлалын хөгжлийг харуулсан онцгой бүтээл бөгөөд, тэр үед тэнгэрийг ажиглах багаж, одны байрлал тогтоогч хоньый (혼 의), од судлах багаж каньый зэргийг бүтээжээ.

갑 과, 甲科 **тэргүүн түшмэлийн зэрэг** гэдэг нь Чосөнъ-ий үеийн түшмэл сонгох шалгуурын дүнгээс хамааран олгодог байсан дөрвөн зэргийн хамгийн дээд зэрэг ажээ.

갑 신 일 록, 甲申日錄, **Кабшинъ иллог (Хөх бичин жилийн өдрийн тэмдэглэл)**-ийг бичсэн Ким Ог гюнъ -ий шинэчлэлтийн чиг шугам нь нийт арван дөрвөн зүйлтэй бөгөөд, тэдгээрээс гол зүйлийг нь сийрүүлбэл:

- Тайвөнъгүнъ-ийг нэн даруй залж ирэх
- Нийгмийн гарлаар ангилах ёс, язгуур угсааг халж хүн бүрт эрх тэгш ёсыг тогтоох
- Найшибү (내 시 부), Хааны номын хөмрөг (규장각) мэт ванд шууд үйлчлэх яам, тамгын газрыг татан буулгах
- Өрх явдлын яаманд санхүүгийн аливаа хэргийг нэгтгэн хариуцуулж, санхүүгийн хэрэг хариуцсан бусад албан[¹서] газрыг татан буулгах
- Газрын татварын журмыг шинэчлэх
- Цэргийн зохион байгуулалтыг өөрчилж, шинэ цагийн цэрэг цагдааг бэхжүүлэх
- Улс орныг доройтуулагч харгис шунахай явдалтныг хатуу цээрлүүлэх
- Сайд түшмэд нар өдөр бүр Төрийн зөвлөлд цуглан хуралдаж, төрийн хэргийг хэлэлцэж шийдвэр гаргаж байх гэх мэт.

갑신정변, 甲申政變, **Хөх бичин жилийн төрийн эргэлт** бол Кожон вангийн 21-р он, өөрөөр хэлбэл 1884 оны 12 дугаар сарын 4-нд эхэлсэн бөгөөд, Соён гэгээрүүлэх бүлэг (개화당)-ийн гишүүд болох Ким Ог гюнь, Паг Йөн хё, Хон Йөн шиг, Сө Гуан бөм нарын тусгаар тогтносон Засгийн газрыг байгуулах зорилгоор өрнүүлэх гэж оролдсон төрийн эргэлт ажээ. Энэ оролдлого нь хоёр хоногийн дараа Мин овогтны бүлэг болон Чин улсын цэргийн хүчинд дарагдан бүтэлгүйтжээ. Чин улс цэрэг хөдөлгөн ирээд Цандөг ордон (창덕궁)-г бүслэн байлдаж, Японы элчин төлөөлөгчийн газрыг довтлох үед Хон Йөн шиг, Паг Йөн хё нар алагджээ. Харин Ким Ог гюнь, Сө Гуан бөм нар Япон руу зугтан гарчээ. Төрийн эргэлт хийх оролдлого бүтэлгүйтсэний дараа гадаад байдал улам ээдрээтэй болжээ.

갑오개혁, 甲午改革, **Хөх морин жилийн шинэчлэлт** бол Кожон вангийн 31-р онд, өөрөөр хэлбэл 1894 оны 7 дугаар сараас эхлэн 1896 оны 2 дугаар сарын эхэн үе хүртэл 19 сарын туршид гурван үе шаттай явагдсан хувьсгал ажээ. Энэ шинэчлэлтээр боолын тогтолцоог халжээ. Япон улс Чосөн-ий засгийн газраас дотоодын шинэчлэлт хийхийг шаардаж ирсэн бөгөөд, үнэн хэрэгтээ Японы эдийн засгийн өсөлттэй холбоотой зүйл байсан учир Чосөн-ий засгийн газрыг дуулгавартай хүмүүсээр бүрдүүлэх хэрэгтэй байжээ. Тиймээс Кйёнбог ордонг эзлээд, Тайвоньгүн-ээр төр бариулж, Ким Хон жиб-ийг дараагийн тушаалд томилжээ. Ийнхүү Японы талыг баримтлагчид, төвийг сахигчдаас бүрдсэн засгийн газрыг бүрдүүлсэн бөгөөд, энэхүү шинэ засгийн газар Хөх морин жилийн шинэчлэлтийг явуулжээ.

강화도, 江華島, (Ganghwa-do) **Канхва арал** - Инъчөн хотын Канхва гүн (мужийн дараагийн нэгж)-д хамаарагдах энэхүү арлын нийт талбайн хэмжээ 305,65 km² ба төвд нь Канхва тосгон байрладаг ажээ. Тус арал тэгш тал бага ч газар тариалан, давсны үйлдвэрлэл хөгжсөн, цэцгэн хээний хатгамал оруулан оёсон дэвсгэр, хүн орхоодой, илжгин чих жимс, Мани уулын оргил дахь Таньгүн-ий Ариун газар, Чөнъдын хийдээрээ алдартай ажээ.

개국공신, 開國功臣, (a meritorious reainer at the founding of a dynasty) 1. **төрд гавьяа байгуулсан түшмэл** 2. **төр төвхнүүлэхэд гавьяа байгуулсан түшмэл.**

개화당, 開化黨, **Соён гэгээрүүлэх бүлэг** гэдэг нь Хөх бичин жилийн төрийн эргэлт гаргасан бүлэг бөгөөд, Ким Ог гюнь (김옥균), Паг Йөн хё (박영효), Хон Йөн шиг (홍영식), Сө Гуан бөм (서광범) нарын залуу хүмүүс манлайлан, улс орноо гэгээрүүлж эрс шийдвэртэй өөрчлөх арга замыг сонгосон шинэ хүчин байжээ. Эд бүгд тухайн үеийнхээ гэгээрүүлэх үзэл (개화사상) -ийн шилдэг төлөөлөгч болох Ю Хон ги (유홍기)-ийн нөлөөн дор байсан ба Ю Хон ги нь буддын шашин шүтдэг, оточ хүн байжээ. Тэд нийгмийг ялгаварлах үзлийг устгах, Японы Мэижигийн шинэчлэлтийг дуурайн, улс төрийг өөрчлөн шинэчлэх, эх орноо Чин улсын нөлөөнөөс ангижруулж жинхэнэ бие даасан улс болгохыг хүсч, энэ зорилгоо хэрэгжүүлэх хамгийн дөт арга бол Япон улсын тусламжийг авах явдал гэж үзжээ. Хэдийгээр хязгаарлагдмал цөөн тоотой хүмүүсийн нууц цуглаан байсан боловч тухайн үеийн улс төрийн ертөнцөд тодорхой байр суурь эзэлж байсан тул түүхчид тэднийг “Гэгээрүүлэх нам (개화당)” эсвэл “Тусгаар тогтнолын нам (독립당)” гэж нэрлэдэг байжээ.

개화사상, 開化思想, (the Enlightenment Thought) **соён гэгээрүүлэх үзэл** - феодалын үзэл суртал, дэг жаягийг халж, орчин үеийг эрэлхийлсэн үзэл.

개화정책, 開化政策, **соён гэгээрүүлэх бодлого** – Чосөнь-ий үеийн хөх морин жилийн шинэчлэлтээр улс төрийн тогтолцоог өөрчлөх гэсэн бодлого.

개화파, 開化派, **гэгээрүүлэх урсгал** – Чосөнь-ий феодалын үзэл суртал, дэг жаягийг халж, улс орноо гадаадад нээлттэй болгохыг хүсч байсан бүлэг бөгөөд, гэгээрүүлэх урсгалууд Өрнөдийн соёлыг нэвтрүүлэн Чосөнь улсаа баян тарган, хүчтэй цэргийн армитай болгохыг оролдож байжээ.

객주, 客主, **зууч худалдаачин** гэдэг нь худалдаачны бараа бүтээгдэхүүнийг хүсэлтийнх нь дагуу борлуулж өгөх, худалдааг зуучлах, тэднийг хоноглуулах гэх мэт олон янзын туслах үүргийг гүйцэтгэдэг худалдаачин ажээ.

거북선, 龜船, Turtle ship, **яст мэлхийн хөлөг онгоц буюу байлдааны сэлүүрт мэлхий онгоц** нь Японы довтолгооны үеэр далайд хэрэглэж байсан яст мэлхийн хэлбэртэй байлдааны усан онгоц ажээ. Албан ёсны нэр нь Квүйсөнъ (хуягт усан онгоц) (귀선(龜船)). Яст мэлхийн хөлөг онгоц бол Чосөнь улсын

тэнгисийн цэргийн хүчний байлдааны гол хүч болох банзаар дээвэрлэсэн Пханог (판옥) байлдааны хөлөг онгоцны дээд хэсгийг сайжруулж битүү хучсан бүтэцтэй ажээ. Пханог байлдааны хөлөг онгоцны бүтэц нь 1 давхар нь сэлүүрдэх талбай, харин 2 давхар нь байлдааны талбар байсан бөгөөд, 2 давхартаа бүрээс хийж хутга, шөвөг зоох боломжтой болгож сайжруулснаар Японы тэнгисийн цэргийн эсрэг тулалдааны тактикт бэлтгэж хийсэн довтолгооны зориулалттай байлдааны хөлөг онгоц байжээ. “Тхэжон (태종) вангийн тэмдэглэл”-д хуягт усан онгоцны талаар ч бас дурдсан байдаг бөгөөд, энэхүү хөлөг онгоцыг өмнө нь бидний маш сайн хөгжүүлж, боловсруулж ирсэн усан онгоцны технологид тулгуурлан хийсэн гэдэг. Хар луу жилийн Японы довтолгооноор гаргасан Солонгосчуудын амжилтыг Япон улсын тэмдэглэлд ч дурдсан байдаг.

건국동맹, 建國同盟, **Улсаа төвхнүүлэх холбоо** бол дундыг баримтлагч барууныхан, аядуу үзэлт зүүнтнүүдтэй хамтран Йө Үнь хйөн (여운형) -ийн удирдлагаар байгуулсан холбоо бөгөөд энэ холбоо нь солонгосчуудын хамгийн их найдвар тавьсан улс төрийн дотоодын байгууллага байжээ. 8 дугаар сарын 14-ний өдөр Япон улс бууж өгөхөөр болж, Солонгос талд Засгийн эрхийг шилжүүлэх үед Йө Үнь хйөн тэргүүтэй Улсаа төвхнүүлэх бэлтгэл хороо нь Чосөнх улсыг улс төр, эдийн засгийн хараат байдлаас чөлөөлөх, улс төрийн аюулгүй байдлыг хадгалах, Кйөнсөн хотод гурван сарын хүнсний нөөц нийлүүлэх, бүтээн байгуулалтын ажилд оролцохгүй байх зэрэг нөхцлийг Японы талд тулгаж байжээ. Улсаа төвхнүүлэх холбоо 1945 оны 8 дугаар сарын 15-ны чөлөөлөлтийн дараа Чосөнх улсаа төвхнүүлэх бэлтгэл хороо (건국준비위원회)-г байгуулж, улмаар улс оронд амар амгалан байдал тогтоохын тулд Аюулгүй байдлыг сахиулах хороо байгуулсан ба тэр даруй улс даяар 145 салбар хороод бий болжээ. Гэвч зүүнтнүүд, үндэсний үзэлтэй баруунтнуудыг хорооны бүрэлдэхүүнээс шахан гаргаад, 1945 оны 9 дүгээр сарын 6-нд Улсаа төвхнүүлэх бэлтгэл хорооноос Бүгд Найрамдах Чосөнх Ард улс (조선인민공화국)-ыг зарлан тунхаглажээ.

경국대전, 經國大典, Gyeongguk Daejeon: **Кйонгүгдэжонь** гэдэг нь “Төр жолоодох их цааз” бөгөөд, Чосонь улсын хуулийн эмхэтгэл юм. Чосонь улсын Сэжо (세조) вангийн үед эмхэтгэж эхэлсэн бөгөөд Сөнжон (성종) вангийн үед бүрэн дуусгаж олонд түгээн дэлгэрүүлжээ. “Төр жолоодох их цааз” хуулийн эмхэтгэл бол улс төр, эдийн засаг, нийгмийг хамарсан цогц хууль бөгөөд, захиргааны хууль, цэргийн хууль, иргэний болон гэр бүлийн хууль, эрүүгийн хууль гээд бүгд багтсан хууль юм. “Төр жолоодох их цааз”-ын ялангуяа захиргааны хууль нь их чанга хууль бөгөөд, түшмэл, өрх, ёслол, цэрэг, шүүх, үйлдэх хууль гэсэн 6 хэсгээс бүрдэж байжээ. “Төр жолоодох их цааз” хуулийн эмхэтгэлийн ихэнх хувийг төрийн зохион байгуулалт болон боловсон хүчний дүрэм журмыг тогтоосон захиргааны хууль болох төрийн хууль эзэлдэг. Мөн нийгмийн гарлаар нь ангилах хуулийн хэрэгжилт чанга байсан ба нийгмийн гарлынх нь дагуу оноодог ял шийтгэлтэй байжээ. Энэ нь боол, тариачин зэргийн бусдад дарангуйлагддаг давхаргын хүмүүст таатай бус байжээ. “Төр жолоодох их цааз” хуулийн эмхэтгэл бол ёслолын хуулийг нэгтгэсэн бичмэл хууль юм. Энэ хуулийн дүрэм журмыг хамгийн анх эмхэтгэх явцад болон дараагийн шатны эмхэтгэх явцад ч мөн адил улсын ванд өргөн барьж соёрхуулаад дараа нь вангийн зарлигын дагуу хэрэгжсэн зарлигуудыг цуглуулж эмхэтгэж байжээ.

경복궁, 景福宮, Gyeongbok Palace: **Кйөнбог ордон** бол Чосонь улсын үед барьсан ордны нэг бөгөөд Чосонь улсын хуулийн ордон юм. Тхайжо (태조) ван Чосонь улсыг байгуулаад Хань-йан (한양) руу нийслэлийг нүүлгэн шилжүүлэх үед энэ ордныг барьсан ба Чосонь улсын хамгийн анхны ордон юм. 1592 онд Хар луу жилийн Японы довтолгооны үеэр галд шатсанаас хойш 275 жил тус ордон тэр хэвээр байсныг 19-р зууны үед Чосонь улсын сүүлчийн вангийн удам угсааны улс төрч, Кожон вангийн эцэг Хынсөн Тайвоньгүнъ (흥선대원군)-ийн удирдлагаар сэргээн босгожээ.

경부선, 京釜線, (Gyeongbu[Seoul-Busan] (Railroad) Line) **Сөүл Пүсань-ыг холбосон төмөр зам** - 1905 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ганц замтай тээвэрлэлтийг эхэлсэн ба 1939 оноос хойш олон замтай болсон. Нийт замын уртын хэмжээ 441,7км.

경연, 經筵, jìngyuán, **Кйөн-йөнъ** гэдэг нь хаанд хүнзийн сургаалийн судар, түүхийн номуудын талаар заан сургаж, саналаа солилцон хэлэлцдэг сургалт, судалгааны тогтолцоо юм. Энэ тогтолцоог Хятадын Хань улсын үед эзэн хаанд хүнзийн судрыг заан сургадаг заншилаас үүдэлтэй гэж таамагладаг. Корйё улсын Мүнъжон (문종) вангийн үед анх нэвтрүүлсэн бөгөөд, Чосөнъ улсад тогтолцоог нь засаж өөрчлөөд, чиг үүргийг нь хүчирхэгжүүлснээр уг нэрнээсээ өөрөөр “Кйөн-йөнъ улс төр” гэж хөгжих болжээ. Хүнзийн суртал нь улс төр, сургаал хоёр нэг байсан учир судар, түүхийн номуудад нь улс төртэй холбоотой шашины үндсэн зарчим агуулагдсан байдаг ажээ. Иймэрхүү зарчмыг ил тод байлгаж, улс төрийг бодитой хэрэгжүүлэх зорилготой байсан зүйл нь Кйөн-йөнъ юм. Сүн (송나라) улсын Тхайжон (태종) вангийн үед “Кйөн-йөнъ” гэх нэр томъёог анх хэрэглэх болжээ.

경재소, 京在所, **нийслэл дэх мужийн суурин жасаа** – Чосөнъ-ий үед орон нутгийн захиргааг төвийн удирдлагатай холбох үүргийг гүйцэтгэн, төвийн удирдах эрхийг чангатгахын тулд нийслэл хотноо байгуулсан удирдах газрыг хэлдэг ажээ. Тэжон вангийн үед анх санаачлан 1435 оноос тогтолцоонд нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаад 1603 онд татан буулгажээ.

경제 개발 5개년 계획, 韩国经济开发五年计划, Five-Year Plans of South Korea, **Солонгосын эдийн засгийн хөгжлийн таван жилийн төлөвлөгөө**-г 1953 оны 6 дугаар сарын 25-ны Солонгосын дайн дууссаны дараа Солонгосын эдийн засаг үйлдвэрлэлийн байгууламжийн ихэнх нь сүйрсэн балгас, нурангийн нөхцөл байдлаас дахин эхлэх хэрэгтэй болжээ. 1950-аад оны үед АНУ-ын тусламж дэмжлэгээр амь зууж байсан боловч АНУ ч гэсэн төлбөрийн тэнцэл болон санхүүгийн алдагдал нь өссөнтэй холбоотой хөгжил буурай орнуудад үзүүлдэг тусламжаа багасгахаас өөр аргагүйд хүрсэн бөгөөд, 1961 онд тусламж, дэмжлэг бууруулах төлөвлөгөөгөө зарлажээ. Энэхүү нөхцөл байдалд 1961 онд төрийн эргэлт хийж засгийн эрхийг булаан авсан ерөнхийлөгч Пак Жөн хый цэргийн дэглэмийнхээ зүй зохистой байдлыг баттай байлгах үүднээс эдийн засгийн хөгжлийг нэн тэргүүний ажил болгох зорилт тавьж, эдийн засгийг үр ашигтай хөгжүүлэх зорилгоор эдийн засгийг

хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөг тууштай хэрэгжүүлж эхэлжээ. Үүний үр дүнд Солонгосын тав, таван жилийн эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө нь маш сайн амжилтанд хүрчээ. Нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн (GNP) 1961 онд 100 долларт ч хүрэхгүй байсан бол 1995 онд 10,000 гаруй долларт хүрчээ. Мөн энэ үед боловсруулах үйлдвэрийн эзлэх хувь 15%-иас 30% болон өсч, экспортын эзлэх хувь 1%-иас (41 сая доллар) 28% (125 тэрбум доллар) болж өссөн байна. Дэлхийн 2-р дайны дараа олон улс орнууд дайны дараах эдийн засгаа сэргээх юмуу эсвэл колончлолын болон хөгжил буурай байдлаас ангижрахын тулд эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлж байсан боловч Солонгос шиг гайхмаар амжилтад хүрсэн улс бараг байдаггүй ажээ.

Эдийн засгийг хөгжүүлэх 1-р 5 жилийн төлөвлөгөөний (1962-1966) гол ажил нь цахилгаан, нүүрс зэрэг эрчим хүчний эх үүсвэр болон суурь аж үйлдвэрлэлийг өргөтгөх, нийгмийн дагалдах хөрөнгийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн хөгжлийн үндэс суурийг бүрдүүлсэн бол улсынхаа олон тооны ажиллах хүчийг ашиглан хөнгөн үйлдвэрийг голчлон хөгжүүлжээ. Түүнчлэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн хөдөө аж ахуйн орлогыг өсгөх, экспортыг нэмэгдүүлэх замаар төлбөрийн тэнцлийг тэнцвэржүүлэх, технологийг дэмжих зэрэг ажлууд энэ төлөвлөгөөнд багтсан байжээ. Мөн Вьетнамын дайнд цэргээ илгээхээс гадна Солонгосоос Германд ажиллах ажилчдын хөдөлмөрийн гэрээ байгуулснаар уурхайчин, сувилагчаар ханган ажиллаж тэдний цалингаар дэнчин тавин гадаад валют олох боломжтой болж байжээ. Энэ төлөвлөгөөний хугацаанд эдийн засгийн өсөлт зорилтот хувь болох 7.8%-иас давсан бөгөөд, нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн 83 ам.доллараас 126 ам.доллар болж өссөн байна.

Эдийн засгийг хөгжүүлэх 2-р 5 жилийн төлөвлөгөө нь (1967-1971) хүнсний хэрэгцээгээ дотооддоо хангах, ой модыг нөхөн сэргээх, химийн болон ган төмөр, машин механизмын үйлдвэрүүдийг барьж байгуулах замаар аж үйлдвэрийг хөгжүүлэх, экспортыг 1 тэрбум долларт хүргэх (1970), хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, үндэсний орлогыг огцом өсгөх, шинжлэх ухаан, технологийг дэмжих, технологийн түвшин, үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулах зорилготой байжээ. Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхэд

шаардлагатай хөрөнгө нь 980 тэрбум вон байсан бөгөөд, үүнээс дотоодын хөрөнгө нь 602,9 тэрбум вон, гадаадын хөрөнгө нь 1,421 тэрбум вон болсон байна. Мөн энэ төлөвлөгөөний хугацаанд Кйөнбү хурдны зам (Сөүл Пүсанийг холбосон зам) баригджээ.

Эдийн засгийг хөгжүүлэх 3-р 5 жилийн төлөвлөгөө нь (1972-1976) хүнд болон химийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, тогтвортой тэнцвэрт байдалд хүрэх зорилготой байжээ. Энэхүү төлөвлөгөөний хугацаанд төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхлэхийн өмнөхөн буюу 1971 оны 8 дугаар сард "Никсоны шок"-оос болж олон улсын эдийн засгийн дэг журам алдагдаж эмх замбараагүй болсон бөгөөд, улмаар 1973 оны 10 дугаар сард болсон нефтийн хямрал зэрэг эдийн засгийн хүнд хэцүү саад бэрхшээлийг даван туулсан төдийгүй гадаадын хөрөнгийн урсгалаа нэмэгдүүлэх, экспортыг дэмжих бодлого явуулснаар Ойрхи Дорнодын барилгын салбараас үүдэлтэй хямралыг даван туулж, жилийн дундаж өсөлтөө 9.7%-даа хадгалж байжээ.

Эдийн засгийг хөгжүүлэх 4-р 5 жилийн төлөвлөгөө (1977-1981) нь өсөлт, тэнцвэрт байдал, үр ашиг гэсэн гурван үндсэн зүйлд өөрийн хүчээр хөгжих бүтцийг бий болгох, мөн нийгмийн хөгжлийг дэмжих замаар тэнцвэрт байдлыг сайжруулах, технологийг шинэчлэх, үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой байжээ. 1977 онд экспорт нь 10 тэрбум долларт хүрч нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн (GNP) 1000 долларт хүрсэн боловч, 1978 онд үнийн өсөлт, үл хөдлөх хөрөнгийн ашиг хонжоо, ахуйн хэрэглээний барааны хомсдол, олон төрлийн бүтээгдэхүүний үнэ, тоо ширхэг зэргээс үүдэлтэй маш олон асуудлууд гарч ирчээ. 1979 оны хоёр дахь нефтийн хямралаас болж Солонгосын эдийн засаг бүр ч хүнд үетэй нүүр тулж байсны дээр 1980 онд Кванжү хотод болсон 5 дугаар сарын 18-ны ардчиллын хөдөлгөөнөөс үүдэж улс төрийн эмх замбараагүй байдал болон нийгмийн үймээн самуун, бас ургац муу жил хүртэл давхцаж эдийн засгийн байдал алдагдалд орсон хэдий ч азаар 1981 онд эдийн засаг дахин сэргэж эхэлжээ. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 5-р 5 жилийн төлөвлөгөө (1982-1986 он) нь дээрх 4 төлөвлөгөөний үндэс болж байсан "өсөлт" гэх агуулгыг хасч, тогтвортой байдал, үр ашиг, жигд тэнцвэрт байдалд тулгуурлаж үнийг тогтворжуулах, нээлттэй байлгах, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх,

орон нутаг болон орхигдсон салбарыг хөгжүүлэхэд гол бодлогоо чиглүүлж байжээ. Энэ төлөвлөгөөний хамгийн том ололт нь Солонгосын эдийн засагт ужгирхсан асуудал болоод байсан барааны үнийг эрс тогтворжуулж, үүний үндсэн дээр 1986 оноос хойш гурван зүйлийн нөлөөгөөр олон улсын байгаль орчны таатай өөрчлөлттэй уялдан тогтмол орлого зарлагын тэнцлээс ашиг хүртэж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн хувьд бие даах чадвартай болсноор эдийн засгийн чанарын бүтэц бэхжсэн. 1986 оноос хойш гурван таатай өөрчлөлт гарсан үед урсгал дансыг ашигтай болгож, хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бие даан хангадаг болсноор эдийн засгийн чанарын бүтцээ бэхжүүлжээ.

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 6-р 5 жилийн төлөвлөгөө (1987-1991 он) нь "үр ашиг, тэнцвэрт байдалд суурилж эдийн засгийг илүү хөгжүүлэх, "Үндэсний сайн сайхныг дэмжих" зорилтыг үндсэн зорилгоо болгосон бөгөөд, энэ нь 21-р зууны хөгжингүй нийгэмд орох эхний шатны үйл ажиллагааны төлөвлөгөө байжээ. Ялангуяа, илүүдэл ашиг руу шилжсэнээр хөгжингүй орнуудын протекционист шахалт болон дотоодын орхигдсон салбаруудын орлогын нөхөн олговор авах хүсэл нэмэгдэх болж, үүнд хариу арга хэмжээ авах бодлого баримталж бие даасан байдал, өрсөлдөөн, нээлттэй байдалд суурилсан зах зээлийн эдийн засгийн дэг журмыг бий болгож, орлогын хуваарилалтыг сайжруулж, нийгмийн хөгжлийг тэлэх, өндөр технологийн салбарт төвлөрсөн аж үйлдвэрийн бүтцийг өөрчлөн зохион байгуулах зэрэг зорилтын хүрээнд төлөвлөжээ. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлт зорилтот хувь болох 7.5%-иас давж 10%-д хүрсэн бөгөөд, ажилгүйдлийн түвшин 2.4%-д хүрсэн нь хөдөлмөр эрхлэлт тогтвортой болж, улмаар хуримтлалыг нэмэгдүүлэхэд чиглэж ажилласны үр дүнд дотоодын хуримтлалын түвшин анх тооцоолж байснаас өндөр буюу 36.1%-д хүрч байжээ.

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 7-р 5 жилийн төлөвлөгөө (1992-1996) нь бие даасан байдал, өрсөлдөөнд тулгуурлаж удирдлагын шинэчлэл, хөдөлмөрлөх ухаан, иргэний ёс зүйг төлөвшүүлэх замаар 21-р зуунд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, үндэсний нэгдлийг дэмжих гэсэн үндсэн зорилгын хүрээнд аж ахуйн нэгжийн өрсөлдөх чадвар болон нийгмийн тэнцвэрт байдлыг

нэмэгдүүлэх, хөгжлийг тэнцвэртэй болгох, нээлттэй байдал болон олон улсын байдлыг дэмжих, нэгдэх үндэс суурийг бүрдүүлэх гэсэн гурван том бодлого төлөвлөжээ. Энэ хугацаанд эдийн засгийн бодит өсөлтийг жилд дунджаар 7.5%-д хүргэхийн тулд аж ахуйн нэгжийн өмчлөлийн төвлөрлийг тараасан бөгөөд, аж үйлдвэрийн бүтцийг хялбар зохицуулж, технологийн хөгжил, мэдээлэлээр хангах байдлыг бүрдүүлж, нийгмийн шууд бус хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалтыг өргөжүүлжээ.

경제육전, 經濟六典, “**Төр удирдах 6 ёс цааз**” – Чосөн-ий үе 1397 онд Чон Дожонь, Чо Жунь нарын эмхэтгэн гаргасан зургаан боть бүхий улсын үндсэн хууль цаазын бичиг ажээ. Өнөө цаг хүртэл хадгалагдан үлдээгүй юмсанжээ.

경주, 慶州, (the Gyeongju) **Кйонжу хот** бол Эртний Силла улсын нийслэл хот байжээ. Одоогийн умард Кйонсан мужийн зүүн өмнөд хэсэгт Хйонсань голын эх сав газрын өргөн тал газар байрлаж, эргэн тойрон уул нуруудаар хүрээлэгдсэн, эртний Силлагийн соёлын дурсгалт зүйл их байдаг хот тул аялал жуулчлалын салбар их хөгжжээ.

경회루, 慶會樓, **Кйонхой хүндэтгэлийн асар** – Кйонбог ордны баруун хойд талын цөөрмийн голд байрлах тус асарт улс оронд баярт үйл явдал тохиох юмуу өөр улс гүрний элч ирэх үед үдэшлэг зохион байгуулдаг байжээ. Чосөн-ий Тайжон-ы 12-р /1412/ онд цөөрмийг томсгох үеэр асрыг мөн томсгож, хар луу жилийн Японы довтолгооны үеэр шатахад Чосөн-ий 4-р /1867/ онд дахин сэргээн барьжээ. 224 дэх үндэсний үнэт зүйлээр бүртгэгдсэн газар ажээ.

戒嚴령, 戒嚴令, **түгшүүр зарлах тухай зарлиг** гэдэг нь улсад онцгой нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй тайван байдал, эмх замбарааг хадгалахын тулд тухайн бүс нутгийн хууль, засаг захиргааны бүрэн болон зарим эрхийг ерөнхий командлагч гартаа авахыг тушаасан ерөнхийлөгчийн зарлигийг хэлдэг ажээ.

고종, 高宗, Gojong, **Кожон ван** (1863-1907) бол Чосөн улсын 26 дахь хаан бөгөөд, Их Хань эзэнт улсын анхны эзэн хаан ажээ. Тэрээр 1863 оноос 1907 он хүртэл хаан ширээнд суусан бөгөөд, Йенжо (영조) вангийн гуч хүү Хынсөн-гүн И

Ха ын (흥선군 이하응)-ын хоёр дахь хүү ажээ. Кожон ван Хынсөнъгүнъ, Игжон (익종)-ын хатан Чо Дайби (조대비) хоёрын чимээгүй тушаалаар өв залгамжлагчгүй байсан Чөлжон (철종) вангийн дараа хаан ширээнд суужээ. Түрэмгийлэх үзэлтэй гадны хүчирхэг улс гүрнүүдийн дээрэм тонуул, шунал тачаал ид байх үетэй зэрэгцэн дотоодод Хынсөнъ Тайвөнъгүнъ, Мйөнсөн хатан хоёрын зөрчилдөөн, мөн соён гэгээрүүлэх бүлэглэл болон үндсэрхэг үзэлтний бүлэглэлийн хоорондох зөрчил хурцадсанаар хүнд хэцүү үеийг туулж гарах хэрэгтэй болжээ. Хүчирхэг гүрнүүдийн дунд гадаад харилцаандаа хүчин чармайлт гаргаж байсан төдийгүй Их Ханъ эзэнт гүрэн байгуулагдсаныг тунхагласан зэргээр бүрэн эрхт байдлаа хамгаалахыг хичээж байсан хэдий ч 1905 онд Япон-Солонгосын гэрээ байгуулсны дараа Япон улсын албадлагаар хаан ширээнээсээ буусан бөгөөд, 1919 онд таалал төгсжээ.

고창읍성, 高敞邑城, **Кочан-ы хэрэм** нь Чосөнъ улсын эхэн үед баруун далайн эргийг хамгаалах зорилгоор барьсан 1684 метрийн урттай чулуун хэрэм ажээ. Кочан-ы хэрэм нь гадна талдаа хэрмийг хамгаалах дугариг хэлбэрийн цайзтай, мөн дайснууд авирахаас сэргийлж хэрмийг тойруулж ухсан цөөрөм байдаг нь тус хэрмийн онцлог ажээ. Кочан-ы хэрэмний дотор хэсэгт айл байдаггүй, төрийн хэргийг хэрэгжүүлэгч төрийн байгууллага зөвхөн байрладаг байжээ. Энэхүү хэрэм одоогийн умард Челла мужийн Кочан (전라북도 고창) гэх газарт байдаг бөгөөд, 1965 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр түүхийн дурсгалт газраар бүртгэгджээ.

공명첩, 空名帖, **гавъяаны бичиг** гэдэг нь бодитоор албан тушаалд томилолгүй, албан тушаалынх нь байр суурийг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ажээ. Чосөнъ улсын сүүл үед нийгмийн гарал угсаа дахь эмх журам алдагдаж, улс төрийн нам, бүлгийн зөрчил хурцдаснаар засаглалын эрх мэдлээс зарим янбанъ шахагдан гадуурхагдаж, нэг хэсэг нь эдийн засгийн хувьд хохирчээ. Хоёр удаагийн дайны дараа төр засаг, санхүүгээ бэхжүүлэхийн тулд мөнгө төлсөн хүний анги давхаргыг ахиулж байсан бөгөөд, дайны үеэр гавъяаны бичиг ч ихээр олгож байжээ. Ингэснээр нийгмийн угсаа гаралд өөрчлөлт нилээд орж, янбанъчуудын тоо нэмэгдэн эсрэгээрээ энгийн иргэд, боол

багассан ажээ. Нийгмийн зиндаагаа дээшлүүлж янбань болох гэж энгийн иргэд болон дунд хүмүүс уг бичгийг хуурамчаар үйлдэж байсан удаатай ажээ.

관상감, 觀象監, **Зурхай цаг уурын хүрээлэн** – Чосөн-ий үеийн одон орон судлал, газар зүй, зурхай, цаг уурын ажиглалт, хур тунадасны хэмжээг тогтоох зэрэг хэрэг эрхлэх байгууллага ажээ. → **운대**(雲臺), **운감**(雲監)

관영수공업, 官營手工業, **улсын үйлдвэрлэл** гэдэг нь Чосөн-ий үед төрөөс шууд удирдан явуулдаг байсан гар үйлдвэрлэлийн хэлбэрийг хэлдэг байжээ. Гар үйлдвэрийн урчууд үйлдвэртээ бүртгүүлэн тодорхой хугацаанд улсдаа биеэр алба барьдаг байснаа хожим мөнгөөр татвараа төлж, өөрсдөө бие даан үйл ажиллагаагаа явуулан хөрөнгө хуримтлуулах болжээ. Төр нь ч тэднийг хөлслөн шаардлагатай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх болжээ.

관찰사, 觀察使: **До-гийн хянагч сайд** нь Хятадын Тан улс **당대**(唐代)-ын үеэс эхлэлтэй бөгөөд хожим Солонгосын Чосөн улс болон Япон улсад ч мөн хэрэглэж байсан албан тушаал бөгөөд, орон нутгийн үйл ажиллагааг хянадаг мужийн захирагч ажээ. До-гийн хариуцагч, хянагч сайд нь байцаан шалгах, захирах, шүүх, цэрэг хөдөлгөх эрх бүхий чухал албан тушаал ажээ.

광대, 廣大, **хэрмэл жүжигчин** бол Пханьсори, багтай жүжиг, циркийн үзүүлбэр зэргийг мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх хүнийг нэрийддэг ажээ.

광무, 光武, **Кванмү он тоолол** нь Кожон (**고종**) вангийн үеийн он тоолол юм. Чосөн-ий улс төрийн дотоод хэрэгт бусад улс орнууд хөндлөнгөөс оролцох явдлыг таслан зогсоож, тусгаар тогтносон улсаа байгуулахын тулд Кожон ван хааны хэргэм зэргийг эзэн хаан (**황제**) болгох санал дэвшүүлж, он тооллыг Кванмү (**광무**) хэмээн нэрлэж, эзэн хааны ширээнд суух ёслол хийн улсын нэрийг Их Хань улс (**대한제국**) хэмээн зарлан тунхаглаж гадаад дотоодод тусгаар тогтносон улс гэдгээ 1897 онд зарлан тунхаглажээ.

광작, 廣作, **өргөн тариалангийн талбайг ажиллуулах** – Чосөн-ий сүүл үеэр тутрагыг үрсэлгээний аргаар тариалах болсноор ургацын хэмжээ нэмэгдэж,

хөдөлмөрийн хүчийг хэмнэх боломж бий болон улмаар нэг хүний тариалах тариалангийн газрын хэмжээ нэмэгджээ.

광주학생운동, 光州學生運動, **Кванжү-гийн сурагчдын хөдөлгөөн** гэдэг нь 1929 онд Өмнөд Чёлла мужийн Кванжү хотноо гарсан дунд сургуулийн сурагчдын Японыг эсэргүүцсэн хөдөлгөөн ажээ. Кванжү хотоос галт тэргээр сургуульдаа ирж очдог солонгос, японы дунд сургуулийн сурагчдын хооронд зодоон гарсныг далимдуулан хоёр мянга орчим солонгосын дунд сургуулийн сурагчид Японыг эсэргүүцсэн хөдөлгөөн өрнүүлсэн нь 3-р сарын 1-ний хөдөлгөөнөөс хойш гарсан хамгийн том ардчилсан тэмцэл байжээ.

광화문, 光化門, **Кванхва хаалга** – Кйёнбог ордны гол хаалга бөгөөд 1395 онд тус ордныг барих үед анх босгожээ.

교조신원운동, 敎祖伸冤運動, **Шашны үндэслэгчийг цагаатгах хөдөлгөөн** гэдэг нь 1864 онд Дорнын суртлыг үндэслэгч Чхой Жэү-г ард иргэдийн толгойг эргүүлсэн хэргээр цаазалсны дараа тус шашинд итгэгчид багшийнхаа хэргийг цагаатгуулж, шашны эрх чөлөө олж авахын тулд гаргасан хөдөлгөөн ажээ.

국가보안법, 國家保安法, **төрийн аюулгүй байдлын тухай хууль** гэдэг нь улс орны аюулгүй байдалд заналхийлэх орны үйл ажиллагааг хязгаарласнаар улс орны аюулгүй байдал, иргэдийн амь нас, эрх чөлөөг хамгаалах зорилго бүхий хууль юм.

국가보위에 관한 특별조치법, 國家保衛—特別措置法, **улсын аюулгүй байдлыг хангах онцгой арга хэмжээний хууль** – 1971 оны 12-р сард Паг Жөн хый-гийн засгийн газар онцгой байдал зарлаж “Улсын аюулгүй байдлыг хангах онцгой арга хэмжээний хууль” гаргасан нь хүний эрх чөлөөг хааж боосон хүчирхийллийн арга хэмжээ авах явдлыг хуульчилж өгсөн хэрэг байжээ. Учир нь Паг Жөн хый ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанд удаа дараалан ээдрээтэй хэрэг гарч байсан бөгөөд, тухайлбал, 1968 онд Умард Солонгосын зэвсэгт дайчид ерөнхийлөгчийн Хөх ордонг дайрсан, Америкийн усан онгоц Умард Солонгост барьцаалагдсан, Үлжинь (울진), Самцөг (삼척) зэрэг газар руу зэвсэглэсэн тусгай ангийг Умардаас илгээж өдөөн хатгасан зэрэг ажээ.

Паг Жөн хый ерөнхийлөгч гурав дахь удаагаа сонгогдож, 1969 оны 9 дүгээр сард шударга бусаар Үндсэн хуулинд өөрчлөлт оруулсан нь оюутнууд болон олон нийтийн хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч оюутны жагсаал цуглаан өргөжихөөс сэргийлж, сонгууль болсон жилийн намар нь Сөүл хотын гудамж талбайг цэргийн байнгын хамгаалалтанд байлгах ерөнхийлөгчийн тушаал гарчээ. Мөн энэ үед 1971 онд Хятад улс НҮБ-д гишүүнээр элсч, Америк, Хятад хоёрын харилцаа сайжирч эхэлсэн зэрэг гадаад улс төрийн нөхцөл байдал түгшүүртэй болж байжээ.

국채보상운동, 國債報償運動, **Төрийн өр дарах хөдөлгөөн** нь 1907 онд Солонгосын төр засаг Японд 13 сая вонь (원)-ийн өртэй байсан ба энэ нь засгийн газрын нэг жилийн төсөвтэй тэнцэх асар их хэмжээний мөнгө байжээ. Иймд 1907 онд Тайгү (대구)-ийн Ким Кванжэ (김광제), Сө Сандонь (서상돈) нар “Солонгос ахан дүүс бүгдээрээ хандив цуглуулан улсынхаа өрийг дарж, Японы шахалт дарамтыг үгүй хийцгээе.” гэсэн санал дэвшүүлжээ. Энэ санал нь “Их Хань-ы өдөр тутмын шинэ мэдээ (대한매일신보), “Эзэнт гүрний сонин (제국신문)-оор дамжин тархаж, Сөүлд ч гэсэн төрийн өрийг дарах хөдөлгөөний нийгэмлэг байгуулагджээ. Уг хөдөлгөөнд нийгмийн бүхий л давхаргын хүмүүс оролцож, нийт ард иргэдийн хандивын хөдөлгөөн болж хувирчээ. Ялангуяа эмэгтэйчүүд идэвхтэй оролцож, бөгж, үсний хавчаараа хандивлаж байсан бол Сөүлийн зарим газарт өдрийн хоолны мөнгөө хэмнэн байж мөнгө цуглуулан хандивлаж байжээ. Гэвч ийнхүү цуглуулсан хандивын мөнгийг захиран зарцуулах байгууллага, хэрхэн өр дарах арга, чиглэл нь тодорхой бус байжээ. Уг хөдөлгөөнийг дэмжсэн “Их Хань өдөр тутмын шинэ мэдээ” сонины эрхлэгч Ян Китхаг (양기탁)-ийг Японы империалистууд хандивын мөнгө шамшигдуулсан хэргээр барьж хорьсноор төрийн өрийг дарах хөдөлгөөн зорилгодоо хүрч чадаагүй ажээ.

군국기무처, 軍國機務處, **“Цэрэг, төрийн хэргийн газар”** гэдэг нь Японы талыг баримтлагчид болон төвийг сахигчдаас бүрдсэн шинэ засгийн газрын байгуулсан зөвлөлдөх байгууллага ажээ. “Цэрэг, төрийн хэргийн газар” нь арван долоон гишүүнтэй бөгөөд, Ю Гиль жүнь (유길준) тэргүүтэй аядуу

урсгалын гэгээрүүлэгч үзэлтнүүд голлосон байгууллага байжээ. Энэ байгууллага засгийн газраас үл хамаарах бие даасан байгууллага тул ван ба вангийн хатны санаа бодлыг үл харгалзан шийдвэр гаргаж байсан бөгөөд, вангийн оронд төрийн хэргийг удирдуулахаар тохоосон Тайвөнхгүн-ий хувьд ч байдал адилхан байжээ. “Цэрэг, төрийн хэргийн газар” гэх байгууллага нь вангийн эрхийг бууруулж, түүний оронд Хувийн сайдын яам (의정부) ба түүнд шууд захирагддаг найман яам (아문)-ны эрх үүргийг өргөжүүлэхээс гадна хуучин зургаан яам (육조) -н дээр гадаад хэрэг, тариалан худалдааны хоёр яамыг нэмсэн төдийгүй Дотоод хэргийн яамны удирдлага дор Цагдаагийн хэргийн газар (경무처) байгуулж, цэрэг, цагдаагийн хэргийг тусгаарлажээ. Мөн ордны хэрэг эрхлэх олон жижиг албадуудыг нэгтгэн Ордны дотоод захиргаа (궁내부)-нд захируулаад түүний эрх үүргийг багасгаж вангийн засаглалыг багасгасан зэрэг улс төр, эдийн засгийн шинэчлэлтүүдийг хийжээ.

군사혁명위원회, 軍事革命委員會, Цэргийн хувьсгалын хороо гэдэг нь цэргийн эргэлт хийгчид "Цэргийн хувьсгалын хороо"-г байгуулж, төрийн эрхийг атгасан бөгөөд "Хувьсгалын амлалт"-аа олон нийтэд зарлаж өөрчлөлт шинэчлэлт хийх зорилгоор тодорхойлжээ. Төрийн дээд байгууллага болох “Улсаа сэргээн босгох дээд хурал (국가재건최 고회의 1961.6)”, түүний шууд захиргаанд “Мэдээллийн төв штаб (중앙정보부)”-г байгуулж, цэргийн засаглалаа тогтоож байжээ. Улсаа сэргээн босгох дээд хурлын даргаар Паг Жөн хьи (박정 회), Мэдээллийн төв штабын даргаар Ким Жон пхил (김종필)-ийг сонгожээ. Тэд ард түмний аюулгүй байдлыг хангах, коммунизмын эсрэг авах арга хэмжээг чангатгахад гол анхаарлаа хандуулж, "Улсаа дахин төвхнүүлэх онцгой арга хэмжээний хууль (국가재건비상조치법)“, "Коммунизмын эсрэг хууль (반공법)“, "Жагсаал цуглааныг түр хориглох хууль (집 회에 관한 임시조치법)“, "Улс төрийн үйл ажиллагааг журамлах хууль (정치활동정 화법)" зэргийг шуурхайлан гаргаад улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын бүх салбарт хатуу чанд дэглэм тогтоож байжээ.

규장각, 奎章閣, **Кйүжан хааны номын хөмрөг** бол Чосөн-ий сүүлээр 1776 онд байгуулагдаж, хааны бичээс, бичвэр, эд зүйлсийг хадгалан хянаж байсан номын сан ажээ. Чосөн-ий хожуу үед шинжлэх ухаан, урлаг огцом хөгжихөд чухал үүрэг гүйцэтгэсэн ба 1894 оны Хөх морин жилийн шинэчлэлтийн үед устан алга болжээ.

균분상속제, 均分相續制, **өмч хөрөнгийг хувь тэнцүү өвлүүлэх тогтолцоо** гэдэг нь Чосөн улсын үед өмч хөрөнгөө өвлүүлэхдээ хүү, охиноо ялгаварлалгүйгээр адил тэнцүү хувааж өгдөг байсан өмч өвлүүлэх тогтолцоо ажээ. Энэ тогтолцоог Чосөн-ий хууль зүйлийн бичиг болох “Кйөнгүгдэжөн (경국대전)”-д тогтоож өгсөн байдаг бөгөөд, тухайн удам угсаанаас хамааран хэмжээ нь ялгаатай боловч, 17-р зууны дунд, сүүл хагас хүртэл үүнийг баримталж байжээ. Өмч хөрөнгийг хувь тэнцүү өвлүүлэх тогтолцооны үед охид ч гэсэн хөвгүүдтэй нэгэн адил хөрөнгө өвлөж авдаг байсан боловч, Чосөн-ий хожуу үед шинэ хүнзийн суртал дэлгэрснээр эцгийн талыг эрхэмлэх болж, хөвгүүдэд илүү хөрөнгө өвлүүлдэг болсон агаад, улмаар ахмад хөвгүүн ганцаар өмч хөрөнгөө өвлөж авах тогтолцоо бий болжээ. Энэ үеэс охидын хөрөнгө өвлөж авах эрх нь хасагдаж, нийгмийн байр суурь нь ч гэсэн доошилсон гэж үздэг ажээ.

균역법, 均役法, **алба тэгшитгэх хууль** – Чосөн-ий үеийн 1750 онд энгийн харц иргэдийн хаших цэргийн албыг хөнгөвчлөхийн тулд гаргасан татварын тогтолцоог хэлдэг ажээ. Бөс даавууны татварын хэмжээг хоёр дахин багасгасан ба дутуу төлсөн татварыг загас агнуур, давс боловсруулалт, завь үйлдвэр, газрын аж ахуйн татвар дээр нэмэн авч байжээ.

금양잡록, 衿陽雜錄, **Кымйан нутгийн газар тариалангийн тэмдэглэл** – Чосөн-ий эхэн үед Кан Хыйм Ен-ий зохиож модон бараар хэвлэсэн газар тариалангийн тухай нэг сэдэвт зохиол ажээ. Зохиогч нь Сөнжон вангийн үед албан тушаалаасаа чөлөөлөгдөж Кымйан-д байх зуураа өөрийн туршлагад тулгуурлан газар тариалан эрхлэх аргын талаар ийнхүү бичсэн ажээ.

기녀, 妓女, **дууч эм** бол Чосөн-ий үед улс оронд шаардлагатай ёслол хөгжим (예악)-ийг хариуцсан тусгай эмэгтэйчүүд ажээ. Чосөн-ий үеийн дууч эмсийг

ки (기), йё-ги (여기), чханнйё (창녀), кисэн (기생) гэх мэтээр маш олон янзаар нэрлэдэг бөгөөд, тэднийг харьяалагдах байгууллагаас нь хамаараад Чан-агвонь (장악원)-ий харъяат “нийслэлийн дууч эмс (경기)”, орон нутгийн захиргааны харъяат “албаны дууч эмс (관기)” хэмээн ангилдаг байжээ. Гэвч Инъжо (인조) вангийн үед “нийслэлийн дууч эмс”-ийг үгүй болгосноор улсаас шаардлагатай тохиолдолд орон нутгийн “албаны дууч эмс”-ийг сонгон авч, албанд хэрэглэдэг байжээ. Дууч эмсийн тоог гүйцээх олон янзын арга байсны дотор “албаны шивэгчид (관비)”-ийн дотроос царай зүс, урлагийн авъяасаар сонгож авах нь хамгийн түгээмэл байжээ. 16-50 насандаа алба хаах эдгээр дууч эмс нь Чосөн-ий урлагийнхны хамгийн дээд давхаргад багтдаг атлаа улсын алба үүрэгч хамгийн доод давхарга гэсэн хоёр шинжийг нэгэн зэрэг агуулсан онцгой давхарга байжээ. Тэд урлагт суралцаж, дуулж бүжиглэн бусдыг цэнгээх ажлыг хариуцдаг байсан агаад энд бэлгийн үйлчилгээ хүртэл багтаж байжээ.

기상, кисан гэдэг нь “тэмдэглэн өргөн барина” гэсэн утгатай бөгөөд, аливаа боол үр хүүхэдгүй нас барсан тохиолдолд түүний үлдээсэн эд хөрөнгийг тоолж тэмдэглэж, эзэнд нь өргөн барих гэдэг утгаар хэрэглэдэг байжээ. Өөрөөр хэлбэл, албаны боол (공노비)-ын өмч хөрөнгийг улсын байгууллагад нь, хувийн боол (사노비)-ын өмч хөрөнгийг янбань эзэнд нь шилжүүлэхийг хэлдэг ажээ.

기인, 其人, нийслэлд суух жасааны түшмэл гэдэг нь Чосөн-ий үед орон нутгийн удирдагчийг хэт толгой даахаас сэргийлэн барьцааны хүн маягаар нийслэлд суулгаж засаг захиргааны зөвлөхөөр ажиллуулж байсан тэдний хүүхдийг ийнхүү нэрийддэг ажээ. → **기인제도(其人制度)**

기호학파, 畿湖學派, Кихо нутгийн эрдэм судлалын бүлэг бол Чосөн-ий үед Сөнъжо вангаас хойш И-и үндэслэгчтэй гарч ирсэн Хүнзийн шинэ урсгал бөгөөд бодит улс төрийг голчилж үздэг байсан ажээ.

김구, 金九, Ким Гү (1876-1949) бол Солонгос улсын тусгаар тогтнолын хөдөлгөөнд оролцогч, улс төрч хүн юм. 18 настайдаа Дорнын суртал (동학) -д орж,

Пхалбон нутгийн Тонхаг сурталтны удирдагч болж, улмаар тариачны хөдөлгөөнийг толгойлж байгаад Японы цэрэгт хөөгдөн Манжуур луу зугтжээ. 1895 онд Мйөнсөн хатныг хорлож алсныг сонсоод дараа жил нь япон офицерыг цохиж алаад цаазлах ял авсан хэдий ч 1897 онд ялыг гүйцэтгэхээс өмнөхөн шоронгоос оргожээ. 3 дугаар сарын 1-ний хөдөлгөөний дараа Шанхай руу цагаачлан гарч Хятадын Шанхайн Түр Засгийн газрыг байгуулахад оролцож байжээ. 1928 онд Тусгаар тогтнолын намыг байгуулж, 1931 онд “Эх орончдын бүлгэм (애국단)”-ийг зохион байгуулж, 1939 онд Түр Засгийн газрын улсын дарга болж, дараа жил нь “Чөлөөлөх арми”-ийг байгуулж, 1941 онд Японы эсрэг байлдаанд Чөлөөлөх армийг удирдаж байжээ. 1944 онд Түр Засгийн газрын тэргүүнээр сонгогдож, Нэгдсэн Засгийн газрыг байгуулахыг хүсч байсан учир Дангаар захирах Засгийн газар байгуулахыг эсэргүүцэж Өмнөд, Умард хоёр Солонгосыг хэлэлцээр хийлгэхийн тулд хүчин зүтгэж байсан хүн ажээ.

김대중, 金大中, **Ким Дай жүн** бол БНСУ-ын 15 дахь ерөнхийлөгч юм. Тэрбээр 1925 оны 12 дугаар сарын 3ны өдөр Солонгосын хойгийн баруун өмнөд нутагт тариачны гэр бүлд төрсөн бөгөөд, дунд сургуулиа төгсөөд улмаар Могпо (목포) хотын Худалдааны сургууль, Кйөнхый дээд сургууль (경희대학교)-ийг дүүргэжээ. 1950 оны Солонгосын дайн дууссаны дараа Ким Дай жүн улс төр, нийгэмдээ хүч сорихоор шийдэж И Сын мань (이승만)-ы ганцаар дарангуйлах дэглэмийг эсэргүүцэн сөрөг хүчний сонины газарт анх ажиллажээ. 1961 оны 5 дугаар сарын 13-нд тэрээр Солонгосын парламентын гишүүнээр сонгогдсон хэдий ч хоёр хоногийн дараа цэргийн эргэлт гарч парламент тарснаар улс орныг цэргийн генерал Пак Жөн хый удирдах болж, өөрийн гол дайсан Ким Дай жүн-ийг хавчих болжээ. 1972 онд түүнийг Үндсэн хуулинд өөрчлөлт оруулах гэсэн гэх нэрийдлээр хавчин мөрдөж эхэлснээр гадаад руу дүрвэн гарсан хэдий ч “Өмнөд Солонгосын тагнуул” хэмээн мөрдөн мөшгиж ардчилсан хөдөлгөөний удирдагчийг хөнөөх гэсэн далд төлөвлөгөө боловсруулж байсны дээр цэргийн дарангуйлагч Пак Жөн хый, түүний залгамжлагч Чөнъ дү хван нар түүнийг “Засаг төрийн нэгдүгээр дайсан” хэмээн 6 жил шоронд хорьжээ. Дарангуйллын эсрэг түүний тэмцэл, гал цогтой

үгс өргөн олон түмэнд түгэн тархаж, дуу хоолой нь хүрснээр 1987 онд Сөүл хотод олон нийтийн сүрт жагсаал болж, улс төрийн эрх чөлөө, Үндсэн хуулинд өөрчлөлт оруулах, ерөнхийлөгчийг шууд сонгох, цэргийн дэглэмийг эцэс болгох тухай хэд хэдэн шаардлага хүргүүлэхэд түүний үүрэг, оролцоо их байжээ. Түүнийг Өмнөд Солонгост ардчиллыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн хэмээн үнэлдэг ажээ. Ким Дай жүн 1998 онд ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулж тус оны 2 дугаар сарын 25-нд тангараг өргөх ёслолоо хийжээ. Ким Дай жүн-ий засгийн газар нь ардчилал, зах зээлийн эдийн засгийг зэрэг хөгжүүлэх явдлыг зорилгоо гэж тодорхойлсон боловч түүнийг засгийн эрхэнд гарах үед улс орных нь эдийн засаг гүнзгий хямралд орсон байсан учир нэн тэргүүнд эдийн засгийн хямралыг давах хэрэгтэй болжээ. Тэрбээр гадаадын хөрөнгө оруулалтыг татан оруулахад их хүчин чармайлт тавьж байсан бөгөөд, энэ үед иргэдийн дунд алт цуглуулах хөдөлгөөн өрнөж бүх ард түмний дэмжлэгийг олж асар богино хугацаанд их хэмжээний алт цуглуулж 1999 оны 1 дүгээр сар гэхэд гадаад валютын нөөц 50 тэрбум доллараас давж, гадаадын хөрөнгө оруулагчдын тоо ч эрс нэмэгдсэнээр 1999 онд гадаад валютын хямралыг гэтлэн давж эдийн засгаа дахин сэргээж чаджээ. Мөн түүний байгуулсан бас нэг гавъяа нь 2000 оны 6 дугаар сарын 13-нд Умард Солонгосын урилгаар Пхёнъян хотод очиж Умард Солонгосын Батлах хамгаалах хорооны дарга Ким Жөн ил (김정일)-тэй уулзан эвлэрэл, эдийн засгийн хамтын ажиллагааны хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурж таван зүйлээр тохиролцсон явдал ажээ. Ким Дай жүн-ий засгийн газрыг “Ард түмний засгийн газар” (1998.02.25-2003.02.24) гэж нэрийддэг бөгөөд, тэрбээр Монгол улсад 1999 онд айлчлан ирж байжээ. Ким Дай жүн ерөнхийлөгч бүс нутгийн болоод тив дэлхийн даяарчлалыг яаж ойлгох, түүнийг хэрхэн удирдан зохицуулах талаар өөрийн олон гаргалгааг дэвшүүлэн тавьсан том эрдэмтэн бөгөөд, түүний амьдралын зорилго, үзэл санаа нь ардчилал байжээ. Тэрбээр 2009 оны 8 дугаар сарын 18-нд 85 насандаа өвчний улмаас таалал төгсчээ.

김영삼, 金泳三, **Ким Йон сам** бол БНСУ-ын 14 дэх ерөнхийлөгч юм. Тэрбээр 1927 оны 12 дугаар сарын 20-ны өдөр мэндэлсэн бөгөөд, Сөүлийн үндэсний их

сургуулийн гүн ухааны ангийг төгсөж Солонгосын дайны үед Өмнөд Солонгосын армид алба хаажээ. 1954 онд Үндэсний Ассамблейн гишүүнээр сонгогдон ажиллаж байсан бөгөөд, ардчиллын төлөө идэвхтэй тэмцэн дарангуйлагч дэглэмийн эсрэг Ким Дай жүн-ий хамтаар дуу хоолойгоо өргөдөг байжээ. 1983 оны 5 дугаар сард Ким Йөн сам Үндэсний Нэгдэл-Ардчиллын Нам (통일민주당)-ын дарга байхдаа гэрийн хорионд хоригдож, улмаар гэртээ өлсгөлөн зарлаж засгийн газрын эсрэг тэмцэж байжээ. 1990 оны 1 дүгээр сард Но Тхай ү (노태우) ерөнхийлөгч Ким Йөн сам, Ким Жон пхил нартай эвсэн 3 нам нэгдэн, Ардчилал-Эрх чөлөөний Нам (민주자유당)-ыг байгуулжээ. Ким Дай жүн-ий Энхтайван-Ардчиллын Нам (평화민주당) бусад сөрөг хүчинтэй нэгдэн Ардчилал-Эрх чөлөөний Намыг татан буулгахыг шаардан шинэ зөрчил үүсгэж байжээ. Хожим эрх баригч нэгдсэн намыг төлөөлөх Дээд зөвлөлийн даргаар Ким Йөн сам томилогдсон бөгөөд, тэрбээр 1992 оны 12 дугаар сард болсон ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулж 14 дэх удаагийн ерөнхийлөгчөөр сонгогджээ. Ким Йөн сам 1960 оны 5 дугаар сарын 16-наас хойш 33 жилийн дараа анх удаа Иргэний засгийн газрыг бүрдүүлжээ. Тэрээр хууль тогтоох засаглалыг чөлөөт, шүүх засаглалыг хараат бус, гүйцэтгэх засаглалыг хариуцлагатай байлгахыг хичээн ажиллаж байжээ. Эд бараа, мөнгө санхүү, бүх салбарын үүд хаалгыг гадаад орнуудад нээж өгчээ. Умард Солонгостой харилцах харилцаанд нааштай алхам хийж 1994 оны 6 дугаар сарын 28-нд дээд хэмжээний уулзалтын бэлтгэл болгож яриа хэлцэл хийсэн бөгөөд, 1995 онд Умард Солонгост үер усны гамшиг болж хүнс хоол хомсдоход хүмүүнлэгийн тусламж үзүүлж хэдэн түмэн тонн тутарга нийлүүлж байжээ. 1997 оноос түүний нэр хүнд нэлээд унаж, улс төрийн хувьд хүнд байдалд оржээ. Ким Йөн сам ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанд галт тэрэг онхолдсон, зорчигч тээврийн усан онгоц живсэн, Сөнсү хэмээх том гүүр нурсан, метроны барилгын газарт хотын хийн хоолой дэлбэрсэн, Сампүм их дэлгүүрийн барилга гэнэт нурсан гэх мэт улс, нийгмийг бүхэлд нь донслуулсан том хэмжээний осол аюул гарч олон хүн амь насаа алдсан нь олон түмнийг түгшүүлж байжээ. Ийм аймшигтай аюул осол гарах болсон гол шалтгаан нь ардчилал ялах явцад алив хориг цээр тавигдаж, нийгмийн дэг

журам суларсантай холбон үзэж улс орны хүчин чадлыг сулруулж байна хэмээн шүүмжилж байжээ. Ким Йөн сам ерөнхийлөгч 2015 оны 11 дүгээр сард 87 насандаа таалал төгсчээ.

김일성, 金日成, **Ким Ил сөн** бол Пхйөнъян хотод төрсөн бөгөөд, тэрбээр 1919 онд найман настайдаа эцгийгээ дагаж Манжуурт очоод Пхалдогү хэмээх бага сургуульд оржээ. 1923 онд өвөг эцэг Кан Донъ ү-гийн байгуулсан Пхйөнъян-ы Цандөг сургуульд, 1925-1927 онуудад Манжуурт Мүсөн, Хуасөн Ыисүг хэмээх сургуулиудад сурч, коммунист үзлээр хүмүүжжээ. 1931 онд хорин настайдаа Хятадын коммунист намд элсэн орж, 1935 онд Хятадын Японы эсрэг зүүн хойт нутгийн холбоотны цэрэгт нэгдэж 1-р девизийн 6-р ротын даргын үүрэг гүйцэтгэж байжээ. 1936 онд Эх орноо чөлөөлөх чуулганы үйл ажиллагаанд оролцож, дараа жилээс нь олон байлдаан, тулаанд ялалт байгуулан алдаршиж эхлэжээ. Ким Ил сөнийг арван таван нас хүрсэн 1926 онд Умард Солонгост "Империализмын эсрэг хороо" байгуулагдснаар коммунист үзэл суртлын үндэс суурь тавигдсан гэж сурталчилдаг бөгөөд 1926 онд нэн шинэ түүх эхлэсэн гэж үздэг ажээ. Ким Ил сөн-ийн засаглал асар богино хугацаанд бэхжиж, энэ нь Сөүлийн баруунтнуудыг яаруулжээ. Умард нутгийг Ким Ил сөн атгандаа оруулж, өмнөд хэсэгт бие даасан засгийн газар байгуулах тэмцэл эхлэхэд эх орноо хуваагдахаас эмээсэн алсын хараатай улс төрийн зүтгэлтнүүд баруун зүүний хүчнийг нэгтгэж нэгдсэн засгийн газар байгуулах тэмцлээ эхлэжээ. Ким Ил сөний эцэг Ким Хйөн жиг 1917 онд "Чосөнъ иргэдийн чуулган" байгуулан 3-р сарын 1-ний хөдөлгөөнийг удирдсан, элэнц өвөг Ким Ын ү (김응우) 1866 онд генерал Шерманы усан онгоцыг дайрах үед манлайлах үүрэг гүйцэтгэсэн мэтээр сурталчилдаг ажээ.

남인, 南人, **өмнөдийхөн** гэдэг нь Чосөнъ-ий үед зүүнийхнээс тасран гарсан урсгалын нэг юм.

남조선노동당, 南朝鮮勞動黨, **Өмнөд Чосөнъ-ий Хөдөлмөрийн Нам** – 1946 онд Паг Хөнъ-йөн-ий удирдлагын дор Солонгосын коммунист нам болон Солонгосын Ардын нам, Өмнөд Солонгосын Шинэ Ардын намууд нэгдэн Өмнөд

Солонгост зүүнийг сахигч намуудын хүчийг сэлбэх зорилготой байгуулагдсан нам ажээ. →남로당(南勞黨)

남한산성, 南漢山城, (Namhansanseong) **Намханъ уулын цайз** бол Кйёнги мужийн Кванжү хотын Намханъ ууланд байрлах цайз бөгөөд, Чосөнъ-ий 1595 онд барьж эхлэн 1624 онд дуусгасан ажээ. Улаан хулгана жилийн самууны үеэр Инъжо хаан тус цайзыг хамгаалж байгаад 45 хоногийн дараа ичгүүртэйгээр бууж өгсөн газар гэдгээрээ алдартай ажээ.

내선일체, 內鮮一體, **“Япон Солонгос хоёр бол нэг улс мөн.”** гэсэн бодлого - 1937 онд Япон улс Солонгос улсыг дайнд татан оруулах гэсэн бодлогын хүрээнд ингэж нэрийдэж байснаа хожим Солонгос улсыг өөрийн колони улс гэдгээ ийнхүү илэрхийлэх болжээ.

노론, 老論, **норонъ ахмадын бүлэг** гэдэг нь Чосөнъ-ий үед барууныхнаас салан гарч ирсэн олон намын нэг нь ажээ. Нэг хэсэг норонъ ахмадын бүлэг Чосөнъ улсын төрийн эрхийг барьж байжээ.

노비, 奴婢, **боол** гэх үг нь эрэгтэй “доорд хүн”-ийг “но (노)” буюу боол, эмэгтэй “доорд хүн”-ийг “би (비)” буюу шивэгчин хэмээсэн үг бөгөөд, үүнийг нийлүүлээд ноби (노비) буюу боол гэдэг байжээ. Энэ нь Хятадын “сайн хүн (양인), доорд хүн (천인)” хэмээн ард иргэдийг гарал угсаагаар нь ангилдаг тогтолцооноос үүсэлтэй ажээ. “Сайн хүн” нь түшмэлийн албан тушаал буюу цэргийн алба гэх мэт улсын үйлчилгээ, татвар, улсад алба өргөдөг байсан бол “боол” нь улсын байгууллага болон хувь хүнд бие махбодоороо харъяалагдаж, тэрхүү газартаа хөдөлмөрийн хүч буюу эд зүйлсийг “биеийн алба” болгон өргөн барьдаг байжээ. Хувь хүнд харъяалагддаг боолыг эд юмс мэт өвлөх буюу худалдаж ч болдог байсан агаад тэдний үр хүүхэд ч гэсэн эцэг эхийнхээ эзэнд харъяалагддаг байжээ. Чосөнъ улсын үе болж ирэхэд “сайн, доорд гарал угсааны тогтолцоо”-г дахин нэвтрүүлж, хууль зүйн хувьд тогтоожээ. Мэдээж хэрэг тэднээс биеийн алба хураах, мөн тэднийг өвлүүлэх, худалдах ч боломжтой байжээ. Гэвч Чосөнъ-ий түрүү үед боол байх нь “сайн хүн” болж улсын алба хүлээхээс дарамт багатай байсан тул “сайн хүмүүс” сайн дураараа

эрх мэдэлтний боол болох явдал нэмэгджээ. Улмаар ийм байдлын эсрэг, улсын албатны дутууг нөхөхийн тулд боолуудад ч гэсэн цэргийн алба ноогдуулах зэргээр “сайн, доорд гарал угсааны тогтолцоо” нь бодит байдал дээр хэрэгжихгүй болох нь тодорхой болмогц эрс багасчээ. Чосөнъ улсын үеийн боол хэмээх ойлголт нь Хятадын эртний нийгмийн боолоос өөр бөгөөд, үнэндээ жирийн иргэнээс ялгахад бэрх хүмүүс байсан гэж үздэг ажээ.

노비종모법, 奴婢從母法, **боолуудын удам угсааг тодорхойлох хууль** гэдэг нь Чосөнъ гүрний үед боолуудын нийгмийн гарал, үүрэг, эзнийг тодорхойлоход эхийнх нь удам угсааг нарийн судалдаг байсан бөгөөд, өөрөөр хэлбэл эх нь боол бол хүүхэд нь ч боол болно гэж заасан хууль юм. Боол, янинь (양인) буюу сайн хүмүүсийн гэрлэлт ихсэх тусам боолуудын тоо цөөрчээ. Янинь нь Чосөнъ гүрний үед улс төрийн эрх мэдэлд захирагдаж, нийгмийн байдлын хувьд язгууртан ангид захирагддаг хүмүүс ажээ. Үүнээс улбаалж энгийн иргэдийн тоо цөөрсөнтэй холбоотой цэргийн алба хаах хүн хомсдож, улмаар санхүүгийн хувьд хэцүү болсон учир үүнийг нөхөх зорилгоор улсаас боолуудыг үе шаттайгаар суллах бодлого явуулж байжээ. 17-р зуунаас хойш боолын гарал угсаа ч гэсэн эхийнхээ гарал угсаанаас хамааран шийдвэрлэгддэг энэхүү “эхийгээ дагах хууль (종모법)” нь Йёнжо вангийн үед хэрэгжиж, 19-р зууны эхэн үе болох Сунжо вангийн үед 66 мянган нийтийн боолыг чөлөөлсөн байна.

녹봉제, 祿俸制, **фүнлүүний тогтолцоо** гэдэг нь Чосөнъ улсын Мйёнжон вангийн 11-р он (1556)-оос хойш улсаас түшмэд, албан тушаалтанд олгодог байсан фүнлүүг нэрлэдэг байжээ. Төрийн албан хаагчдыг ичгүүр сонжууртай байж, шударга бус зүйлд хутгалдахгүй, албан тушаалд нь үнэнчээр зүтгүүлэхийн тулд улсаас гувчуур хурааж олсон тутарга гэх мэтийг бүтээгдэхүүний хэлбэрээр олгохыг фүнлүү гэдэг байжээ. Чосөнъ-ий үеийн албан тушаалтны хариуцаж буй “бодит албан тушаал (실직)-ыг 18 зэрэглэлд хуваан, жилд 4 удаа, өөрөөр хэлбэл хавар, зун, намар, өвөл фүнлүүг олгодог байжээ. Харин Хйёнжон вангийн 12-р он (1671)-оос эхлэн түшмэдэд цалин хөлсийг нь сар бүр олгох “сарын цалин (월봉)”-гийн тогтолцоонд шилжжээ.

농사직설 農事直說, Nongsa jikseol: **газар тариалангийн өгүүлэл** нь газар

тариалангийн ажлыг товчлон тайлбарласан олон тооны номноос одоог хүртэл хадгалагдаж байгаа хамгийн олон жил болсон ном ажээ. Чосөн улсын эхэн үеийн төлөөлсөн болсон газар тариалангийн ном бөгөөд газар тариалан эрхлэхэд заавар зөвлөгөө өгөх үүрэг гүйцэтгэдэг ном юм. Чосөн улсын Сэжон ван (세종) Жөн Чо 정초(鄭招), Бйөн Хю мүнь 변효문(卞孝文)нарт тушааж 1429 он (Сэжон вангийн 11 жил)-д энэхүү номыг хэвлэжээ. Урьд өмнө нь Хятад улсын газар тариалангийн номыг зөвхөн ашиглаж ирсэн бөгөөд цаг уур, орчин нөхцлөөс шалтгаалсан газар тариалан эрхлэх ялгааг харгалзан үзэж аймаг тус бүрийн тариаланчдын туршлага дээр үндэслэн Чосөн улсын цаг агаар, орчин нөхцөл болон тус улсын бодот байдалд тохирсон тариалан эрхлэх аргыг бичиж тэмдэглэх болжээ. Номны агуулгыг харвал, хамгийн эхэнд энгийн түгээмэл зүйл болох тариалан тарихад үр болон хөрсийг шийдэх аргыг тайлбарлаад, дараа нь тусгайлан анхааруулах үүднээс ямар ургамал тарихаас шалтгаалсан газар тариалан эрхлэх аргыг дэлгэрэнгүй тэмдэглэсэн байжээ. Энэ номонд тухайн үеийн өмнөд бүс нутгийн зарим нэг нутагт хийж гүйцэтгэж байсан цагаан будаа суулгах аргыг анх дурдаж байжээ. Энэхүү ном нь агуулгын хувьд, үр тарианы төрөлд хязгаар тавьсан болон тодорхой бус зүйлүүд байсан хэдий ч (газар тариалан болон тариалангийн тосгонд хэрэгтэй бүх зүйлийг хамруулсан тариалангийн амьдралын толь бичиг биш байсан) газар тариалангийн анхны ном бөгөөд, Солонгос улсын хэв маягыг тусгасан газар тариалан эрхлэх аргыг дэлгэсэн бие даасан зохиолын хувьд газар тариалан эрхлэх аргын өөрчлөлтийг ажиглахад тус дэм болохуйц сайн бүтээл болжээ.

당, 黨, нам – Улс төрийн тухай ижил үзэл бодол, бодлого өвөрлөж буй хүмүүс түүнийхээ төлөө эвлэлдэн нэгдэх байгууллага юм. →정당(政黨)

대가, 代加, тайга шилжүүлэн олгох тогтолцоо гэдэг нь Чосөн-ий үед бичгийн болон цэргийн түшмэл чагунээс дээгүүр албан тушаал эрхэлж буй тохиолдолд өөрт нь өгсөн цолыг хүү, хүргэн, дүү, үеэл гэх мэт хамаатны нэг хүнд өгөх ёсыг хэлдэг ажээ.

대동강 (大同江) **Тайдон гол** – Тонбайг, Собайг уулсаас эх авч Шар тэнгист урсан орох гол бөгөөд, тус гол нь 439 км-ын урттай.

대동미, 大同米, **татварт өгөх тутрага** – Чосөн-ий дунд үеэс хойш Тайдон хуулийн дагуу алба гувчуурт хурааж байсан тутрага ажээ. Эхэндээ тогтоосон хэмжээний л тутрагыг алба гувчуурт хураана гэж байснаа цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хэмжээ нь улам бүр нэмэгдэх болжээ.

대동법, 大同法, **тайдон хууль буюу татварыг тутрагаар төлөх хууль** нь Чосөн-ий дунд үеэс хойш олон янзын газар тариалангийн бүтээгдэхүүнийг алба гувчуурт авдаг байсныг тутрага болгон өөрчлөх тухай хууль ажээ. Бүс нутгаас хамааран тутраганы оронд бөс даавуу хурааж байсан ба жишээ нь, 1894 онд тутраганы оронд мөнгө хураан авчээ. Тариачид Тайдон хууль хэрэгжсэнээс хойш урьдын адил хаан болон хааны ордонд олон янзын тариалангийн бүтээгдэхүүнээр алба гувчуур төлөх ёстой байжээ.

대동여지도, 大東輿地圖, Daedongyeojido, The Great Map of the East Land, **Тайдунйөжиду буюу Зүүн гүрний нэгдсэн газрын зураг** гэдэг нь 1861 онд Ким Чөнхо (김정호)-гийн хийсэн Солонгосын хойгийн газрын зураг, газрын зургийн ном билээ. Энэ номны 3 зүйл нь БНСУ-ын ховор эд зүйлээр бүртгэгдсэн бөгөөд, 2008 онд модон бар нь 1581 дугаартайгаар бүртгэгджээ. Энэ газрын зураг бол орчин үеийн хэмжилт хийхээс өмнө хийж гаргасан Солонгосын хойгийн газрын зургууд дундаа хамгийн зөв, тодорхой газрын зураг юм. “Чхөнгү газрын зураг (청구도)”-тай адил түвшний газрын зураг бөгөөд, агуулгын хувьд бага зэрэг засвар хийгдсэн хувилбар ажээ.

대마도, 對馬島, **Сүшима арал** гэдэг нь Солонгос улс, Японы Кйүшйү арлын хооронд байрлах арал юм.

대원군, 大院君, **тайвөньгүнъ буюу жонон** гэдэг нь хаан эцгийг нэрлэдэг бөгөөд, Эзэн хааны ширээ залгамжлах үр хүүхэд байхгүй тохиолдолд, хаан ширээнд суусан хааны эцэгт өгөх зэрэг дэвийг хэлдэг ажээ.

대조선독립협회회보, 大朝鮮獨立協會會報, **Их Чосөн-ийн тусгаар тогтнолын нийгэмлэгийн мэдээ**: 1896 оны 11 дүгээр сард Тусгаар тогтнолын хаалганы

суурь тавих ёслол хийж, түүний дараа жилийн 5 дугаар сард Тусгаар тогтнолын ордны засвар дуусч, нээлтийн ёслолыг өргөн дэлгэр тэмдэглэж байжээ. Тусгаар тогтнолын нийгэмлэгт энгийн иргэд голлоод ирмэгц нийгэм, улс төрийн идэвхтэй хөдөлгөөн өрнүүлэх болжээ. Тухайлбал, ням гараг бүр Тусгаар тогтнолын өргөөнд нийгэмлэгийн гишүүд болон сонсогчид нийлсэн хэдэн зуун хүний уулзалт, ярилцлагыг хийдэг болжээ. Мөн нийгэмлэгийн албан ёсны сонин “Их Чосён-ийн тусгаар тогтнолын мэдээ”-г сард хоёр удаа гаргаж, албан ёсны бус сонин болох “Тусгаар тогтнолын сонин (독립신문)”-г өдөр тутам хэвлэн гаргах болжээ. Тус сонинг энгийн иргэдэд ойлгомжтой байлгах, олон түмэнд хүртээлтэй болгох үүднээс дан хангыг үсгээр бичиж хэвлэж байсан бөгөөд, нийгэмлэг байгуулагдсанаас хойш нийгэмлэгийн үзэл санаа, ялангуяа өрнөдийн либерал үзэл сурталтай танилцсан сэхээтэн давхаргын үзэл бодлыг илэрхийлэх сонин болсон ажээ.

대한광복회, 大韓光復會, Солонгосын тусгаар тогтнолын холбоо – 1915 оны билгийн тооллын 7 дугаар сарын 15-ны өдөр Тайгү хотын Тальсөн цэцэрлэгт хүрээлэнд Ханьмал ыйбийн урсгал, Гэгээрүүлэх хөдөлгөөнийхөн нэгдэн байгуулагдсан тусгаар тогтнолын хөдөлгөөний байгууллагыг хэлдэг ажээ. Энэ холбоо зэвсэггүй тэмцлээр тусгаар тогтнолоо олж авахыг хүсч байжээ.

대한민국, 大韓民國, Republic of Korea, ROK, Бүгд Найрамдах Солонгос улс буюу өөрөөр Солонгос, Өмнөд Солонгос, Өмнөд Чосён гэж нэрлэгддэг улс нь Зүүн Азийн Солонгосын хойгийн өмнөд хэсэгт байрладаг улс юм. БНСУ-ын төрийн далбааг Тхайгыгги (태극기), төрийн дууллыг Айгүгга (애국가), улс, үндэстний цэцгийг Мүгүнхва (무궁화), албан ёсны хэлийг Ханьгүго (한국어) гэдэг. Улсын нийслэл нь Сөүл (서울) юм. БНСУ нь ойролцоогоор 51.6 сая орчим хүн амтай бөгөөд, нийт хүн амын тал орчим хувь нь (26.11 сая орчим) нийслэл орчмын газар нутагт амьдардаг. БНСУ 1948 оны 5 дугаар сарын 10-ны өдөр бүх нийтийн сонгуулиар Үндэсний Ассамблей байгуулж, 1948 оны 8 дугаар сарын 15-ны өдөр БНСУ-ын засгийн газрыг байгуулжээ. БНСУ нь 2022 онд нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 34,994 доллар байна. Ийм дэвшил ололтын хажуугаар амиа хорлолтын түвшин өндөр, урт цагаар ажилладаг соёл,

үйлдвэрлэлийн ослоос үүдэлтэй нас баралт их, төрөлт бага зэрэг нийгмийн асуудлууд мөн зэрэгцэн оршиж байдаг. БНСУ нь "Economist" сэтгүүлийн мэдээлснээр Ардчилалын индексийн судалгаагаар 2019 онд 8.0 оноогоор 23-р байранд бичигдсэн Азидаа ардчилал өндөр хөгжсөн орнуудын нэг юм. Мөн БНСУ нь Их 20 улсын нэг (G20), Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD), Хөгжлийн тусламжийн хороо (DAC)-ын гишүүн улс юм. 1948 оноос хойш өнөөг хүртэл Солонгосын хойгийн өмнөд, хойд хэсэгт БНСУ, БНАСАУ гэсэн хоёр хуваагдмал улс тус тус оршиж байна. Солонгосын хойгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 220,000 км² орчим бөгөөд, 2019 оны байдлаар БНСУ, БНАСАУ-ын хүн ам нийлээд 77 сая орчим болсон байна.

대한민국임시정부, 大韓民國臨時政府, **Их Хань улсын түр засгийн газар**: 1919 оны 4 дүгээр сард Шанхайд Их Хань улсын түр засгийн газрыг байгуулж, түүнд хилийн чанад дах тусгаар тогтнолын хөдөлгөөнийхөн, 3 дугаар сарын 1-ний дараа хилийн чанад руу гарсан хүмүүс бүгд багтжээ. Түр засгийн газар нь хууль тогтоох Ый жөн вөнъ (의정원), засаг захиргааны хэрэг хариуцах Төрийн хэргийн газар (군무원), хууль цаазын хэрэг хариуцах Хуулийн газар (법원) гурваас тогтож байжээ.

대한제국, 大韓帝國, Korean Empire, **Их Хань улс**: Кожон ваныг Оросын консулын газраас ордондоо эргэн ирмэгц улсынхаа нэр хүндийг өсгөх ёстой гэсэн олон түмний шүүмжилэх дуу хоолой өндөрсөв. Иймд Кожон ван улсынхаа нэрийг Их Хань (대한), оны чимгийг Гэрэлт зэвсэг (광무) гэж өөрчлөөд, ван гэдэг нэрийг эзэн хаан (황제) -аар сольж, тусгаар тогтносон эзэнт улсаа тунхаглажээ. (1897 он). Ингэж Их Хань эзэнт улсаа тунхагласан нь Хятад руу уламжлалын дагуу явуулж байсан алба гувчуурыг эцэслэх байр сууриа илтгэсэн төдийгүй дорно дахины уламжлалт дэг жаягт үлдээд байсан зусарч харилцааг цэгцлэх зорилготой байв. Түүнчлэн цэрэг, санхүү, худалдаа арилжаа, гадаад худалдаа зэргийн салбар бүр нь харийн гүрнүүдийн халдлагад өртөж байсан тухайн үед Япон, Орос, Европ, Америк зэрэг улсад тусгаар тогтнох хүсэл эрмэлзлээ тунхаглалаар дамжуулан илэрхийлсэн явдал байв. Их Хань улсын үндсэн

хуулийг 1899 онд баталснаар дотооддоо хааны эрх мэдэл бол хамгийн дээд эрх мэдэл болохыг, гадаад талдаа Их Хань улсын гол эрх мэдэл бол гадны ямар нэг хөндлөнгийн оролцоогүйгээр биеэ даасан тусгаар тогтнол гэдгийг хуулиар тогтоосон.

도고, 都賈, дого худалдаачин гэдэг нь Чосөн-ий сүүл үед бараа бүтээгдэхүүнийг худалдаалахгүй нөөцөлж хяналтандаа оруулан үнийн өсөлтийг зориуд зохион байгуулах бөөний худалдаачин, худалдааны байгууллага юм.

도조법, 賭租法, газар түрээслэх хууль бол Чосөн-ий үед газрын эзэн болон газар түрээслэн тариалан эрхлэгчид тохиролцсоны дагуу жил бүр ургацын хэмжээнээс үл хамааран түрээсийн төлбөр өгч аван, зээлийн газар дээр тариалан эрхлэх аргыг хэлдэг ажээ. Энэ нь Японы дарангуйлал эхлэхээс өмнө хэрэгжиж байжээ.

도화서, 圖畫署, уран зургийн газар – Чосөн-ий үеийн уран зурагтай холбоотой ажлыг хариуцсан албан газар бөгөөд, Чосөн улсын шилдэг зураачид шөнөжин цурам хийлгүй зураг зурах гээд завгүй байдаг байсан газар ажээ.
→ 화국(畫局)

독도, 獨島, Тогдо арал бол Гурван улсын үед Шилла (신라)-ийн Үсань хот улс (우산국)-ыг дагаар оруулсны дараагаас эхлэн Солонгосын газар нутагт харьяалагдах болжээ. Чосөн улсын хожуу үе Сүгжон ван (숙종) -гийн үед гадаад харилцааны түшмэлийн албыг хашиж байсан Ань Йонбуг (안용복) Үллын арал (울릉도) руу хууль бусаар халдан ирсэн япон загасчныг хөөж явуулан, Японд очоод Үллын арал болон Тогдо арал нь Солонгосын газар нутаг болохыг баталж байжээ. Гэвч Орос-Японы дайнд ялалт байгуулсан япончууд Америк, Англитай гэрээ байгуулан Солонгосыг захирах эрх бүхий зөвшөөрөл авснаар Тогдо арлыг хууль бусаар өөрийн газар нутаг хэмээж өнөөг хүртэл Японы газар нутаг гэж үзсээр байгаа ажээ.

독립군, 獨立軍, тусгаар тогтнолын цэрэг – Японы империализмын үеийн Чосөн улсын тусгаар тогтнолын төлөө байлдаж байсан цэрэг арми. ¶ 독립군의 항전. Тусгаар тогтнолын цэрэг армийн тэмцэл.

독립문, 獨立門, **тусгаар тогтнолын хаалга** – Сө Жайпхил тэргүүтэй тусгаар тогтнолын нийгэмлэгээс Солонгосын тусгаар тогтнолыг тунхаглахын тулд 1897 онд иргэдийн хандиваар Йөн-ынъ хаалганы суурин дээр бариулсан чулуун хаалга ажээ. Одоо Сөүл хотын Сөдаймүн дүүргийн Хйөнъжө хороонд байрладаг. Тусгаар тогтнолын хаалгыг босгосон нь улс орон тусгаар бие даан тогтнож байгаагийн илэрхийлэл байжээ.

독립선언, 二八獨立宣言, **2 дугаар сарын 8-ны тусгаар тогтнолын тунхаг** гэдэг нь 1919 оны 2 дугаар сарын 8-нд Японд суралцагч оюутнуудын гаргасан тусгаар тогтнолыг тунхагласан бичиг ажээ. 1918 онд Дэлхийн нэгдүгээр дайн дууссаны дараа Америкийн Вилсон ерөнхийлөгч улс орон бүр өөрсдийн хэргийг өөрсдөө шийдвэрлэх ёстой ба өөр улс үндэстэн оролцож болохгүй гэсэн “үндэстний бие даасан байдал”-ын тухай танилцуулжээ. Тус тунхаг бичигт сэтгэл нь хөөрсөн Японд суралцагч солонгос оюутнууд 1919 оны 1 дүгээр сард Чосөнъ улсын залуучуудын тусгаар тогтнолын бүлгэмийг байгуулан олон улс орны элчин сайдын яаманд үндэснийхээ тусгаар тогтнолын тухай мэдэгдэж, 2 дугаар сарын 8-нд Токиогийн Христийн Хүүхэд залуучуудын ордонд тусгаар тогтнолыг тунхаглах үйл ажиллагааг зохион байгуулжээ. Энэхүү хөдөлгөөнийг төдөлгүй япончууд хүчээр дарсан хэдий ч уур амьсгал нь Солонгост хүрч эцэст нь 3 дугаар сарын 1-ний хөдөлгөөн гарчээ. →이팔독립선언

독립선언서, 獨立宣言書, **Тусгаар тогтнолын тунхаг бичиг** гэдэг нь 1919 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн хөдөлгөөнөөр тунхагласан Солонгос улсын бие даасан тусгаар тогтнолын тунхаг бичиг бөгөөд Чхой Намсөнъ тэргүүтэй Сонъ Бйөнхый, Ханъ Йон-үнъ нарын үндэсний төлөөлөгч 33 хүн гарын үсэг зуржээ. →독립선언문(獨立宣言文)

독립신문, 獨立新聞, **Тусгаар тогтнолын сонин** бол Солонгосын Тусгаар тогтнолын нийгэмлэгээс 1896 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр ханьгыл үсгээр хэвлэн гаргасан анхны сонин юм. Хөх морин жилийн шинэчлэлтийг хэрэгжүүлсэн гэгээрэх үзэлтнүүд Тусгаар тогтнолын нийгэмлэгийг байгуулахаас өмнө Тусгаар тогтнолын сонинг засгийн газрын дэмжлэгээр

хэвлэж эхэлсэн бөгөөд, энгийн иргэдэд ойлгомжтой байлгах, олон түмэнд хүртээлтэй болгох үүднээс дан хангыл үсгээр бичиж хэвлэж байжээ. Тус нийгэмлэгийн албан ёсны сонин болох “Их Чосөн-ий тусгаар тогтнолын нийгэмлэгийн мэдээ (대조선독립협회회보)”- сонинг сард хоёр удаа гаргаж, албан ёсны бус Тусгаар тогтнолын сонинг өдөр тутам хэвлэн гаргах болжээ. Харин нийгэмлэг байгуулагдсанаас хойш нийгэмлэгийн үзэл санаа, ялангуяа өрнөдийн либерал үзэл сурталтай танилцсан сэхээтэн давхаргын үзэл бодлыг илэрхийлэх сонин болсон байжээ. Тус сонинг 1899 оноос хэвлэхээ больжээ.

독립협회, 獨立協會, Тусгаар тогтнолын нийгэмлэг: Эзэн хаан, сайд түшмэд нар

улс орны тусгаар тогтнолыг хамгаалах талаар түр зуурын, ядруухан арга сүвэгчилж байх зуур засгийн газрын бодлогогүй, хойрго байдлыг шүүмжлэн, үндэстний бие даасан байдал, эрх чөлөөний төлөө энгийн ард иргэд баатарлаг тэмцэж иржээ. Ялангуяа өрнөдийн эрх чөлөөний үзэлд суралцаж ирсэн эрдэм боловсролтой сэхээтэн давхарга шинээр төрөн гарч, уг тэмцлийг манлайлах болов. Тэд янз бүрийн улс төрийн бүлгэм байгуулж, тусгаар тогтнол, иргэний эрхийг хамгаалахын төлөө тэмцэж эхлэсэн бөгөөд тэдгээрийн хамгийн анхных нь Тусгаар тогтнолын нийгэмлэг байжээ. Харин Тусгаар тогтнолын нийгэмлэгт энгийн иргэд голлоод ирмэгц иймэрхүү билэгдлийн шинжтэй үйл ажиллагаа төдийгүй нийгэм, улс төрийн идэвхтэй хөдөлгөөн өрнүүлэх болжээ. Жишээлбэл, ням гариг бүр Тусгаар тогтнолын өргөөнд нийгэмлэгийн гишүүд болон сонсогчид хэдэн зуун хүн цугларсан халуун уулзалт ярилцлага хийх болсон байна. Мөн нийгэмлэгийн албан ёсны сонин "Их Чосөн-ий тусгаар тогтнолын нийгэмлэгийн мэдээ" (대조선독립협회회보)-г сард хоёр удаа гаргаж, албан ёсны бус Тусгаар тогтнолын сонин (독립신문)-г өдөр тутам хэвлэн гаргах болжээ. Засгийн газар удалгүй Тусгаар тогтнолын нийгэмлэгийг эзэн хааныг огцруулж, ерөнхийлөгч сонгон, бүгд найрамдах улс тунхаглах гэж байна гэж буруутган И Сан жай тэргүүтэй арван долоон удирдагчдыг барьж хорьжээ. Нийгэмлэгийн гишүүд болон Сөүл хотын иргэд Цагдаагийн газар ба Жонро гудамжинд "Нийт иргэдийн цуглаан"(만민공동회) гэж нэрлэсэн өргөн олныг хамарсан эсэргүүцлийн цуглаан хийж, барьж хорьсон гишүүдийг суллахыг шаардаж байжээ. Тэдний эсрэг засгийн газар үүргийн наймаачдын

бүлгэм болох Эзэн хааны нийгэмлэг (황국협회)-ийн гишүүд хоёр мянган хүнийг хөлсөлж, террорист ажиллагаа явуулан, хүчээр тараажээ. Үүгээр Тусгаар тогтнолын нийгэмлэгийн үйл ажиллагаа төгсгөл болжээ.

동교동, 東橋洞, **тонгёдон** гэдэг нь улс төрийн фракцын нэр бөгөөд Ким Дай жүн (김대준) ерөнхийлөгчийг цэргийн засаглалын үед ардчилалын төлөө тэмцэснээс үүдэн байнгын мөрдлөгө, хавчилга, амь насанд нь заналхийлж байсан бөгөөд, тухайн үед амь биеийг нь хамгаалах зорилгоор байгуулсан улс төрийн бүлэглэл юм. Тонгёдон гэдэг нь Ким Дай жүн ерөнхийлөгчийн оршиж сууж байсан дүүрэг, газрын нэрийг товчлон зохиосон нэр ажээ.

동문학사, 同門學事, **“Тонмүнъ хагса”** нь шинэ үеийн улсын сургууль бөгөөд, 1883 оны 8 дугаар сард Сөүл хотод анх удаа байгуулан гадаад хэл зааж эхэлсэн сургууль ажээ. Кожон ван Хөх бичин жилийн төрийн эргэлтийг дарснаас хойш боловсролын салбарт гэгээрүүлэх бодлого явуулж байсны нэг нь “Тонмүнъ хагса” сургуулийг байгуулсан явдал ажээ. Үүнээс хойш энгийн иргэдийн байгуулсан шинэ цагийн хувийн сургуулиуд олноороо бий болсон бөгөөд, хамгийн анхны хувийн сургууль болох “Вөнъсанъ хагса (원산학사) 1883 онд байгуулагджээ.

동의보감, 東醫寶鑑, **“Дорнын анагаах ухаан”** гэдэг нь Чосөнъ-ий үед Сөнъжо-гийн 29-р /1596/ онд хааны зарлигийн дагуу бичиж эхлээд Кванхайгүний 2-р /1610/ онд дуусгасан анагаах ухааны зохиол ажээ. Эмнэлгийн анагаах аргуудыг дотрын, мэс заслын гэх мэт мэргэжлийн салбараар ялган өвчин тус бүрийг оношлох, эмнэх аргыг дурджээ. Дорно дахины хамгийн шилдэг анагаахын зохиол хэмээн үнэлэгддэг бөгөөд, эмийн ханд бэлтгэх тухай бүлэгт хэдэн зуун төрөл зүйл бүхий эмийн ургамлын нэрийг ханъгыл үсгээр бичжээ. Нийт 25 боть 25 ном бүхий тус номыг төмөр бараар барласан ажээ. “Дорнын анагаах ухаан” зохиол нь дэлхий дахинаа алдартай анагаахын бүтээл юм.

동인, 東人, **зүүнийхэн** гэдэг бол Өрнийн соёлыг эсэргүүцсэн Ким Хйовөнъ, Йү Сөнрийон нарын тэргүүтэй бичгийн хүмүүсээс бүрдсэн урсгал бөгөөд Чосөнъ-ий үеийн дөрвөн урсгалын нэг байсан ажээ.

동학, 東學, Тонхаг гэдэг нь 1860 оноос гараагаа эхлэсэн Тонхаг хэмээх суртал бөгөөд, тариачдын дунд хурдан тархаж эхлэхэд засгийн газар түүний нөлөөнөөс эмээж 1864 онд Тонхаг сурталыг үндэслэгч Цой Жэ Ү (최제우)-г ардын сэтгэлийг үймүүлж, мунхруулсан ялд унаган цаазалжээ. Тийнхүү энэ шашин нэг хэсэг дарагдаж, нам гүм болсон байна. Харин 1870-1880 оны үед их гүрнүүдтэй тэгш бус худалдааны гэрээ байгуулж, улмаар хөдөө тосгон ядуурч доройтоод ирэхэд Тонхаг сурталтнууд дуу хоолойгоо өндөрсгөн гарч ирцгээжээ. Тонхаг сурталтны удирдагчид хөрөнгө мөнгөтэй, эрдэм боловсролтой хүмүүс байсан бөгөөд шашиныхаа ёс дэг, бүлгэмүүдийг шинэ цаг үетэйгээ тохируулан дэглэжээ. Тонхаг суртлын судрыг хоёр янзаар туурвин хэвлэсэн байдаг. Эрдэм боловсролтой давхаргад зориулан "Тонхаг суртлын их судар (동학대전), эгэл харц ардад зориулж дан ханьгыл үсгээр "Луут цөөрмийн дуулал (1880, 용담유사)" гарган нийгмийн анги давхарга бүрт суртал ёсоо таниулан хүртээх болжээ.

동학농민운동, 東學農民運動, Дорнын суртлынхан, тариачдын хөдөлгөөн нь Чосөн-ий Кожон-ы 31-р /1894/ онд дорнын сурталт (동학) Чөнъ Бон жүнь (전봉준) тэргүүтэй дорнын суртлынхан болон тариачид Чёлла мужийн Кобү гүнъ (고부군)-ий захирагч Чо Бйөн габ (조병갑)-ын тариачдыг хэт дарлан мөлждөг шунахай нь хэтэрч дураараа авирлах явдлыг эсэргүүцэн гаргасан хөдөлгөөн ажээ. Харгис захирагчийн бусармаг явдыг олон удаа зогсоохыг шаардсан боловч амжилтанд хүрээгүй тул 1894 оны 2 дугаар сард мянга гаруй тариачид Кобү гүнъ-ий захиргааг эзэлж, зэр зэвсгийг булааж аваад хууль бусаар татварлаж хураасан тариа будааг ядууст тарааж өгөөд Маньсөгбо (만석보) хэмээх усан санг нурааж хаяжээ. →갑오농민전쟁(甲午農民戰爭), 동학운동(東學運動), 동학혁명(東學革命)

두만강, 豆滿江, Түмэн гол гэдэг нь Солонгосын зүүн хойд хэсэгт урсах гол бөгөөд, Пайгдү уулнаас эх аван Зүүн тэнгист цутгах ба 521 км урттай.

러일전쟁, 露日戰爭, Орос Японы дайн бол Солонгосын хойг, Манжуурыг дарангуйлах зорилготой 1904 онд Орос Японы хооронд гарсан дайн ажээ. Их

Хань улсыг нөлөөний хүрээндээ оруулахын төлөө Орос, Япон хоёр улс хамгийн ширүүн өрсөлдөж байжээ. 1895 онд Чин улс Ляодуны хойгийг Японоос эргүүлэн авсныхаа дараа Орос улстай цэргийн нууц хэлэлцээр хийж, Манжуурын тал дундуур Сибирийн төмөр замыг үргэлжлүүлэн барих, Люй шүнь (여순), Порт Артур (대련) -ыг хорин таван жилийн хугацаатай түрээсэлж аваад хооронд нь төмөр зам тавих эрх олж авснаар Манжуурт ноёлох байр суурьтай болсон Орос улс Солонгосын хойг руу түрэн орж ирэх болжээ. Япон улс Их Хань улсад бусад улсаас илүү давуу эрхтэй байх, Манжуурт гадаад худалдааны үүд хаалга нээлттэй байлгахыг шаардаж оронд нь Оросын Манжуур дахь төмөр замын конфепцийн монополь эрхийг зөвшөөрөхийг санал болгосон ажээ. Харин Оросын тал, Японыг цэрэг дайны зорилгоор ашиглахгүй гэдэг баталгаан дор Их Хань улс дах улс төр, эдийн засгийн давуу эрхийг хүлээн зөвшөөрч болох авч Манжуурт ямар нэг байдлаар нэвтрэхийг огтоос хүлээн зөвшөөрөхгүй гээд хойт өргөрөгийн 39-р шугамаас хойшхи Солонгосын хойгийн газрыг төвийн бүсээр тогтоож, хоёр улсын цэрэг нэвтрэхгүй байхыг санал болгожээ. Хоёр улс энэ талаар олон удаа хэлэлцээр хийсэн боловч улс төрийн арилжаа наймаа таараагүйн улмаас Япон зэвсгийн хүчээр асуудлыг шийдэхээр 1904 оны 2 дугаар сард Люй шүнь рүү дайрснаар Орос Японы дайн дэгдсэн ажээ. Орос, Японы харилцаа хурцадмал байдалтай болмогц 1904 оны 1 дүгээр сард Их Хань улс төвийг сахисан улс болсноо зарласан боловч Японы цэрэг Сөүлд нэвтрэн орж ирээд, олон барилга байшинг эзлэн авч 1904 оны 4 дүгээр сард зэвсгийн хүчээр сүрдүүлэн гэрээнд гарын үсэг зуруулжээ. Уг гэрээ нь Япон улс Их Хань улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг батлан хамгаална гэж заасан гэрээ байжээ. Орос Японы дайн дэлхийн олон орны урьдчилан таамаглаж байснаас өөрөөр эргэж Япон улс ялжээ. 1905 оны 6 дугаар сард Орос оронд хувьсгал гарч, дотоодын үймээнд автсан нь дайнд ялагдах гол шалтгаан болсон ажээ.

만국평화회의, 萬國平和會議, **бүх дэлхийн энх тайвны хурал** гэдэг нь Нидерландын Хэгью (Гаага-wiki) хотноо хоёр удаа явагдсан цэргийн зардлыг багасгах дэлхийн энх тайвны төлөөх олон улсын хурал юм. →평화회의(平和會議), 헤이그만국평화회의(Hague 萬國平和會議), 헤이그평화회의(Hague 平和會議)

만민공동회, 萬民共同會, “**Нийт иргэдийн цуглаан**” гэдэг нь өргөн олныг хамарсан эсэргүүцлийн цуглаан бөгөөд, Тусгаар тогтнолын нийгэмлэгийн удирдагчдыг барьж хорьсонд эсэргүүцэн суллахыг шаардсан цуглаан юм. Их Хань эзэнт улсын засгийн газар Тусгаар тогтнолын нийгэмлэгийг эзэн хааныг огцруулж ерөнхийлөгч сонгон бүгд найрамдах улс тунхаглах гэж байна хэмээн буруутган И Сан жай тэргүүтэй арван долоон удирдагчдыг барьж хорьсон байжээ. Иймд нийгэмлэгийн гишүүд болон Сөүл хотын иргэд Цагдаагийн газар болон Жонро гудамжинд “Нийт иргэдийн цуглаан” өрнүүлсэн хэдий ч засгийн газар тэдний эсрэг үүргийн наймаачдын бүлгэм болох Эзэн хааны нийгэмлэг (황국협회) -ийн гишүүд хоёр мянган хүнийг хөлсөлж, террорист ажиллагаа явуулан хүчээр тарааснаар Тусгаар тогтнолын нийгэмлэгийн үйл ажиллагаа төгсөхөд хүрчээ.

만주국, 滿洲國, **Маньжү улс** – Япон улсын 1932-1945 оны хооронд Хятадын зүүн хойд нутагт байгуулсан улс бөгөөд гадаад байдлаараа бие даасан улс мэт боловч бодит хэрэг дээрээ колони улс байжээ. Япон улс нь Маньжү улсыг байгуулсан нь Их газрыг эзлэх дайны бааз газар болгох зорилготой байжээ.

만주사변, 滿洲事變, **Манжуурын дайн** - 1931 оны 9 дүгээр сард Японы цэрэг Хятадын зүүн хойд зүгийн нутаг руу довтолсон нь Хятад Японы дайны эхлэлийг тавьжээ.

명성황후, 明成皇后, **Мйөнсөн хатан** (1851-1895) бол Чосөн улсын Кожон вангийн хатан бөгөөд, тэрээр Кожон ван төр барихад тусалж байсан ба гадаад харилцааг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байжээ. Тайвөнхгүнь, Кожон-ы 10-р (1873) онд улс төрөөс зайлуулагдсан нь гадаад худалдаа хийх бас нэг нөхцлийг бий болгосон ажээ. Вангийн хадам талын их гэр бүлүүд төрд ноёрхох болсны улмаас учирсан хор хохирлыг сайн ойлгосон Тайвөнхгүнь, Кожон ванд язгуур угсаагүй Минь овогт хатан авч өгчээ. Хожим Цой Иг хйён (최익현)-ы Тайвөнхгүнь-г буруутгасан бичиг ванд өргөхөд уг бичгээр шалтаглан түүнийг төрөөс зайлуулж, Минь хатан болон түүний талынхан улс төрд ноёрхох болсон ажээ. Тэрээр 1876 онд Япон улстай, 1882 оны цэргийн үймээний дараа Хятадын Чин улстай харилцаа тогтоож, Чосөн улсын Соён гэгээрүүлэх бүлэгт шахалт үзүүлэн Орос улсад ээлтэй бодлого явуулж байжээ.

Кожон-ы 18-р (1881) онд Тайвөнъгүнъ эрх мэдлээ эргүүлж авахыг оролдож, улмаар түүний хүү И Жай сөнъ (이재선) нь вангийн ордон, Минь хатны талынхан, Японы элчин төлөөлөгчийн газрыг дайрч, Кожон ван болоод Минь хатны засаглалыг унагаж төрийн эргэлт хийхээр төлөвлөсөн хэдий ч төлөвлөгөө нь илэрч хэрэг бүтэлгүйтэн И Жай сөнъ тэргүүтэй гучин хүнийг цаазалсан ажээ. Тайвөнъгүнъ-ийг толгойлогч нь гэдгийг бүгд мэдэж байсан боловч вангийн эцэг тул нэг удаа даран өнгөрөөжээ. Чосөнъ улсад Оросын нөлөө бэхжихээс болгоомжилсон Япон улс Минь хатны талынхныг зайлуулахаар хүчирхийллийн арга сонгосон бөгөөд, Иноүэ-Каорү-гийн оронд томилогдсон дэслэгч генерал Миүра Гороо 1895 оны 8 дугаар сард ордон руу дайран орж Мйөнсөн хатны амийг хороожээ. Улсын хатан эхийг хорлож алсны дээр Японы хүчээр тулган явуулсан эрс шинэчлэлтийн арга хэмжээ зэрэг нь энгийн чосөнъчуудын уур хилэнг төрүүлж, улмаар газар бүр журамт цэргүүд Японы эсрэг тэмцэлд босч байжээ.

모스크바 3 상회의, -三相會議, гадаад харилцааны сайд нарын Москвагийн зөвлөлгөөн – 1945 оны 12 дугаар сард ЗСБНХУ-ын нийслэл Москва хотноо зохион байгуулсан АНУ, Англи, ЗСБНХУ-ын Гадаад харилцааны сайд нарын гадаад харилцаа, худалдааны талаар хийсэн хурал юм. Тус хурлаар БНСУ-ыг харийнхны өмгөөллийн захиргаанд оруулах шийдвэр гаргахад түүнийг эсэргүүцсэн болон хүлээн зөвшөөрсөн хөдөлгөөнүүд ар араасаа өрнөжээ.

목민심서, 牧民心書, “Ард түмнийг жолоодох сэтгэлийн толь” гэдэг нь Чосөнъ-ий Сүнъжо вангийн үед орон нутгийн удирдлагыг анхаарч тариачин ардын аж байдлыг тогтвортой болгох зорилготой Чөн Йагйөн-ы бичсэн ном ажээ. Зохиогч нь 48 боть 16 ном бүхий тус зохиолоо орон нутгийн удирдагчийн мөрдвөл зохих журмыг өөрийн туршлага, цөллөгт байх үеийн амьдралд үндэслэн бичжээ.

목재일기, 默齋日記, Мүгжэ-гийн өдрийн тэмдэглэл (1535.11-1567.2) нь Чосөнъ-ий эхэн үеийн бичгийн түшмэл И Мүнъ гөнъ (이문건) 41 настай байх үедээ буюу Чүнжон вангийн 30-р он (1535)-ы 11 дугаар сараас эхэлж, 73 настай буюу насан эцэслэхээсээ 1 сарын өмнө буюу Мйөнжон вангийн 22-р он

(1567)-ы 2-р сар хүртэл тэмдэглэсэн өдрийн тэмдэглэл ажээ. Энэ тэмдэглэл нь нийт 10 дэвтрээс бүрдэх бөгөөд, 1-2-р дэвтэр нь И Мүнъ гөнъ-ий шимё (эцэг эхийгээ нас барахад гашуудан, 3 жилийн турш булшных нь ойролцоох газар гэр ухаж, булш бунханыг нь арчлахыг хэлнэ) хийж байсан үеэс хойшхи албан тушаал хашиж байсан үеийг нь харуулсан агаад 3-10-р дэвтэр нь бүгд И Мүнъ гөнъ-ийг Кйөнсандо-гийн Сөнъжү-д цөллөгт байх үеийн тэмдэглэл ажээ. Хэдийгээр цөллөгт байсан боловч янбан-ы өдөр тутмын өдөр тутмын амьдралаас онц ялгагдах зүйлгүй тул 16-р зууны хөдөө нутгийн нийгмийн дүр төрхийг тодруулах гол эх сурвалж болж хэрэглэгдэж байгаа ажээ.

문세, 門稅, хаалганы татвар – Кожоны эцэг Тайвөнъгүнъ, вангийн угсааны сүр хүчийг гайхуулах зорилгоор Кйөнбог ордон (경복궁)-г сэргээн барих ажлыг Кожон-ы 2-р (1865) онд эхлүүлж хоёр жилийн дараа дуусгажээ. Ордонг сэргээн барих ажилд оруулсан зардал мөнгийг олохын тулд нийслэл Сөүлийн хэрмийн хаалгаар нэвтрэх бараанаас “Хаалганы татвар (문세)” авах болжээ. Тухайн үед хаалганы татвараас гадна нэг *кёл* талбайд зуун зоос оногдох *кйөлдүжөнъ* (결두전) гэдэг онцгой татвар болон “сайн дураар тушаах зоос (원납전)” гэдэг нэртэй атлаа хүчээр хурааж авдаг мөнгөн татвар зэргээр татварыг нэмэгдүүлж олон харш бүхий сүрлэг том Кйөнбог ордонг хоёр дах удаа сэргээн босгожээ.

문화정치, 文化政治, соёлт засаглал нь 3 дугаар сарын 1-ний хөдөлгөөнөөр Хань улсын ард иргэд Японы колоничлолыг дуртайяа дагаж буй мэтээр таниулсан нь худал болох нь илрэн дэлхий нийтээрээ буруушаан шүүмжлэх болсон тул Япон улс колоничлолын бодлогоо хэлбэрийн хувьд өөрчилж Хань улсад тогтоосон цэрэг, цагдаагийн дэглэмээ өөрчлөн соёлт засаглал (문화정치) гэж нэрлэсэн улс төрийн бодлого явуулах болжээ. Энэ бодлогын дагуу ерөнхийлөн захирагчийг явган цэрэг юмуу тэнгисийн цэргийн генералаас томилдог байснаа хамгийн түрүүнд өөрчилж энгийн түшмэд томилох болжээ. Мөн цэрэг, цагдаагийн дэглэмийг устгаж, нийгмийн дэг журмыг энгийн цагдаа нар сахиулах, япон хүнтэй адил түвшинд боловсрол эзэмших боломжтой болгох, хэвлэлийн хатуу хяналтыг зөөлрүүлж, ханьгыл үсгээр

сонин гаргах, солонгос хүн сонингийн газар эрхлэхийг зөвшөөрөх зэрэг өөрчлөлт хийсэн нь шинэ ерөнхийлөн захирагч Саито Макото-гийн хэрэгжүүлсэн соёлт засаглал байжээ. Гэвч Японы соёлт засаглал гэдэг нь арга хэлбэрээ өөрчилсөн болохоос биш жинхэнэ зорилгоо өөрчлөөгүй нүд хуурсан, заль мэх төдий байсан учир колоничлолын бодлогод өчүүхэн ч өөрчлөлт гаргаагүй ажээ.

물산장려운동, 物産獎勵運動, Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих хөдөлгөөн бол 1920 оны эхээс 1930 оны сүүл хүртэлх хугацаанд гарсан эдийн засгийн хараат бус байдлын төлөөх үндэсний хөдөлгөөн ажээ. 1920-оод оноос худалдаачид, газрын эзэд уралдан үйлдвэрлэл эрхлэх болсноор олон тооны үйлдвэр бий болсон хэдий ч япончуудын үйлдвэрлэлтэй харьцуулахад жижиг, дорой байсан тул нийгмийн дэмжлэг тусалцаагүйгээр цааш хөгжих аргагүй болжээ. Тиймээс 1923 онд байгуулагдсан Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих нийгэмлэгээс үндэсний үйлдвэрлэлээ дэмжих хөдөлгөөнийг дэлгэрүүлжээ. Энэхүү хөдөлгөөн нь Японы бараа бүтээгдэхүүнийг хэрэглэхгүй байхыг уриалж “Чосөнъ хүний оёсныг өмсч, Чосөнъ хүний хийснийг идэж, Чосөнъ хүний гараар бүтсэнийг хэрэглэцгээе” гэх уриан дор өрнөж байжээ. Энэ хөдөлгөөн Сөүл, Пхйөнян мэт томоохон хотуудад эхэлж, төд удалгүй бүх улс орныг хамрах болжээ.

미군정, 美軍政, Америкийн цэргийн засаглал бол Япон улс бууж өгсөн 1945 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс умард өргөргийн 38 хэмээс урагш Өмнөд Солонгос улсад Засгийн газар байгуулагдах 1948 оны 8 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд америк цэргүүдийн тогтоосон засаглалыг хэлдэг ажээ.

미암일기, 眉巖日記, Миам-ын өдрийн тэмдэглэл (1567.10-1577.5) нь Чосөнъ-ий бичгийн түшмэл Йү Хыйчхунъ (유희춘) -ийн 1567 оны 10 дугаар сарын 1-нээс 55 нас хүртлээ буюу нас барсан жил болох 1577 оны 5 дугаар сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд бичсэн өдрийн тэмдэглэл ажээ. Анх 14 ном байсан ч одоогоор ердөө 11 ном байгаа гэдэг. Йү Хыйчхунъ (유희춘) энэ тэмдэглэлдээ Чүнжон (중종) вангийн сүүлч үеэс Сөнъжо (선조) вангийн эхэн үе хүртэл бараг

11 жилийн үйл явдлыг тэмдэглэсэн бөгөөд, голдуу түүний насны эцэс дэх амьдралыг харуулдаг ажээ. Энэ нь орон нутагт суурилсан өндөр албан тушаалтны төв дэх амьдралын дүр төрхийг харж болохуйц ховор чухаг эх сурвалж ажээ.

민족말살정책, 民族抹殺政策, **үндэстнийг устгах бодлого** гэдэг нь колони юмуу хараат байдалд буй үндэстний үндсэрхэг чанарыг үгүй болгон бүрмөсөн дагаар оруулах зорилго бүхий дарангуйлагч үндэстэн, улсын бодлого юм.

민족자결주의, 民族自決主義, **үндэсний үзэл** гэдэг нь үндсэрхэг үзэлтэй нэгэн бүлэг бие даасан улсыг бүрэлдүүлж, өөрийн Засгийн газрыг сонгох эрхтэй гэсэн үзэл ажээ. Энэ нь улс төрийн зарчмын нэг бөгөөд анх Францын хувьсгалаас гаралтай аж. Солонгос улс дэлхийн 1-р их дайны үед ч мөн адил энх тайвныг зорилгоо болгон тус үзлийг хүлээн зөвшөөрсөн нь 3 дугаар сарын 1-ний Тусгаар тогтнолын тунхаглалд ч тусгалаа олжээ.

박정희, 朴正熙, **Паг Жөн хый бол** 1961 оноос эхлэн 1979 онд бусдын гарт амиа алдах хүртлээ Өмнөд Солонгосын ерөнхийлөгч байсан улс төрч, генерал хүн юм. Пак Жөн хый явган цэргийн хошууч генералын хувьд 1961 оны 5 дугаар сарын 16-ний өдрийн үүрээр голцуу Офицерын цэргийн сургуулийн найм дах төгсөлтийн залуу офицеруудаар удирдуулсан 3600 гаруй цэргийг удирдан Сөүл хотыг эзлээд дайны цагийн онцгой дэглэм зарлаж байжээ. Тийнхүү цэргийн эргэлт хийгчид төрийн эрхийг атгах болжээ. Энэхүү үйл явдлыг түүхэнд цэргийн эргэлт, цэргийн бослого (구테다) хэмээн нэрлэдэг ажээ. 1963 онд Үндсэн хуулийн дагуу ерөнхийлөгчийн сонгууль явуулж, ерөнхийлөгчөөр Паг Жөн хый сонгогдож байжээ. Паг Жөн хый-гийн засгийн газар гараагаа эхэлмэгцээ улсынхаа эдийн засгийг хөл дээр нь зогсооход шаардагдах хөрөнгө мөнгө олохын тулд Японтой харилцаагаа хэвийн болгох, Вьетнам руу цэрэг илгээх зэрэг ажилд шамдан оржээ. Тэрээр Өмнөд Солонгосыг удирдахдаа эдийн засгийн өсөлтийг нь хурдасгаж Хан мөрний эрэг дэх ид шидийг бүтээсэн ажээ. Түүний дэглэмийн үед хүний эрхийг зөрчих, халдах тохиолдол их байсан тул нэг хэсэг нь түүний дэглэмийг буруушаадаг бол нөгөө хэсэг нь түүний хийсэн өөрчлөлтийг үнэлэх ёстой гэж

хоёр хуваагддаг ажээ. 1978 оны 7 дугаар сард Пак Жөн хый дахин ерөнхийлөгчөөр сонгогдож, үүрэгт ажилдаа орсон тэр үед ардчилаллын төлөө тэмцэгчдийн эсэргүүцлийн хөдөлгөөн олныг хамарч улс орныг бүхэлд нь хамарчээ. Ийм үед 10 дугаар сарын 26-ны өдөр ерөнхийлөгч Пак Жөн хый Хөх ордны хажууханд болсон засгийн газрын цайллаган дээр Мэдээллийн Төв Штабын дарга Ким Жай гю (김재규)-д буудуулан нас баржээ.

반격, янбанъ-ы зэрэг зиндаа нь янбанъ нарын дунд бий болсон дээд, доод олон янзын төвшнийг нэрлэсэн үг ажээ. Чосөнъ улсын эхэн үеийн нийслэлийн янбанъ нарын худ ургийн харилцаанд өөрчлөлт гарч эхэлжээ. Янбанъ удам угсааны дотроос өндөр албан тушаалыг гартаа атгаж байсан алдар нэртэй гэр бүл хийгээд хамгийн доод албан тушаалыг хэсэгхэн хугацаанд хашихаас өөр албан тушаал хашиж байгаагүй янбанъ нарын хооронд асар их ялгаа байжээ. Гэвч 15-р зуун, 16-р зууны эхэнд эдгээр нийслэлийн янбанъ нар дотроо “янбанъ-ы зэрэг зиндаа” гэдгийг хайхрахгүй болж эхэлжээ. Төвд албан тушаал хашигчдын тусгай эрх мэдлийнх нь баталгаа хязгаарлагдаж, устаж үгүй болох явцад худ ураг болоход зэрэг зиндааны ялгаа нэг их том асуудал болохоо байжээ.

백오인사건, 百五人事件, 105 хүний хэрэг гэдэг нь 1911 онд Японы цагдаа үндэсний хөдөлгөөнийг дарахын тулд Анъ Мйөн гынъ гэх хүнийг Чосөнъ дахь Амбан сайдыг хороохыг оролдсон хэргээр шалтаглан Шинэ Ардын Намын 105 гишүүнийг баривчилж тамласан хэрэг ажээ.

병산 서원, 屏山書院, Пйёнсанъ бичгийн хүрээлэн нь Чосөнъ улсын Сөнъжо вангийн үеийн нэрт бичгийн түшмэл Йүсөнрийон (유성룡)-ы дурсгалд зориулж Кванхай гүнъ (광해군)-ий 6-р он (1614)-д байгуулсан бичгийн өргөө ажээ. Одоогийн Умард Кйёнсөн мужийн Анъдон хотын Пүнчөнъ (경상북도 안동시 풍천면) гэх газарт байдаг аж. 1978 онд “Анъдон Пйёнсанъ бичгийн хүрээлэн (안동 병산 서원)” нэрээр түүхийн дурсгалт газраар бүртгэгдсэн бөгөөд, 2019 онд Сосү (소수), Тосанъ (도산) зэрэг бусад бичгийн хүрээлэнтэй хамт Юнеско-гийн дэлхийн өвөөр бүртгэгдсэн ажээ.

병인양요, 丙寅洋擾, **Улаан бар жилийн барууны самуун** гэдэг нь 1866 онд Кожон вангийн эцэг Хынсөнъ католик сүмийг хавчлаа хэмээн Францын цэргийн флот Канхва арал руу дайралт хийсэн хэрэг ажээ. →강화부피습사건(江華府被襲事件)

병자수호조약, 丙子修好條約, **Улаан хулгана жилийн найрамдлын гэрээ**-г Канхва арлын гэрээ ч гэж бас нэрлэдэг. (Кожон-ы 13-р, 1876 он). Арван хоёр зүйлтэй уг гэрээнд, Чосөнъ нь бие даасан улс тул Японтой адил тэгш эрхтэй, мөн хорин сарын дотор Пусанъ (부산) болон бусад хоёр боомтыг нээнэ гэсэн чухал заалт оржээ. Мөн япончууд үе үе ирж, Чосөнъ-ий тэнгисийн эрэг газарт хэмжилт хийх, боомтууд дээр Японд түрээсийн газар олгох, боомтын дэвсгэр газарт япон хүн Японы хуулиар шийтгэгдэх зэрэг заалт байжээ.

병자호란, 丙子胡亂, **Улаан хулгана жилийн самуун** гэдэг нь 1636 оны 12 дугаар сараас 1637 оны 1 дүгээр сарын хооронд Чин улс Чосөнъ улс руу довтолсон хоёр дохь дайралтын үеэр гарсан үймээн самууныг нэрлэдэг ажээ. Чосөнъ улсын түүхийг хоёр хуваасан хоёр үйл явдал байдаг ба нэг нь Хар луу жилийн Японы довтолгоон (임진왜란) бол нөгөө нь Улаан хулгана жилийн самуун ажээ.

병조, 兵曹, **Цэргийн яам** бол Чосөнъ-ий үеийн батлан хамгаалах хэргийг хариуцаж байсан яам ажээ.

부산포, 釜山浦, **Пүсанъ-ы боомт** – Чосөнъ-ий үеийн гурван боомтын нэг бөгөөд одоогийн Пүсанъ хотын Пүсанъжинъ-д байрладаг боомт юм.

북인, 北人, **умардынхан** гэдэг нь И Бал, И Санъ-хай тэргүүтэй Чосөнъ-ий үеийн 4 урсгалын нэг ажээ.

북조선로동당, 北朝鮮勞動黨, **Умард Солонгосын Хөдөлмөрийн нам** – Солонгосын Коммунист нам хоёр хуваагдсан бөгөөд, Умард Солонгосын нам нь 1946 оны 8-р сард Солонгосын Шинэ Ардын намтай нэгдсэний дүнд байгуулагдсан нам ажээ.

북조선인민위원회, 北朝鮮人民委員會, **Умард Солонгосын Ардын Хороо** –1947 оны 2 дугаар сард байгуулагдсан Умард Солонгосын Ардын Хурлын байнгын үйл ажиллагаа явуулах гүйцэтгэх байгууллага юм.

북학 (北學), **북학론**, 北學論, **умардаас суралцах үзэл** гэдэг нь Чосөн-ий үеийн Йёнжо болон Чёнжо вангийн үед Сирхаг бодит судлалын ухааны эрдэмтэд Чин улсын шинжлэх ухаан, соёл иргэншлээс үлгэр жишээ аван улмаар өөрийн орны соёл иргэншлийг хөгжүүлбэ гэсэн үзэл ажээ.

붕당, 朋黨, **нам бүлэг** гэдэг нь Хятад юмуу Чосөн улсад ижил улс төрийн үзэл бодол, эрх ашиг нэг хүмүүсийн нэгдлийг хэлдэг байжээ.

브라운 각서, Brown 覺書, **Брауны меморандум** – 1966 оны 3 дугаар сарын 7-ны өдөр Америкийн элчин сайд Браун, БНСУ-ын засгийн газарт өргөн барьсан меморандумын гол агуулга нь Өмнөд Солонгосын армийг орчин үеийн техник хэрэгслээр хангах, Өмнөд Солонгосоос Вьетнамд цэрэг илгээх, Америкийн Өмнөд Солонгост олгох шинэ зээл тусламжийн тухай байжээ. 1965 оны 6 дугаар сарын 22-ны өдөр БНСУ, Япон улстай хэлэлцээр хийсэн бөгөөд, хэлэлцээрийн үр дүнг 8 дугаар сард парламентаар батлаж мөн Вьетнамын дайнд цэрэг илгээх шийдвэрийг батлажээ. Америкийн хүчтэй шахалт шаардлагын улмаас хэлэлцээр хийж, улмаар засгийн газар Вьетнамд цэрэг илгээхээр зөвшөөрчээ. Түүний хариуд цэрэг армийг өргөтгөх, эдийн засгийн хөгжлийг дэмжих зээл авахаар болж, “Брауны меморандум (브라운 각서)”-аар баталгаажуулжээ. Түүнээс хойш 1965 оноос 1970 оны эхэн хүртэл “Догшин бар (맹호)”, “Хөх луу (청룡)” хэмээх цэргийн ангийн 55 мянга гаруй байлдагч Вьетнамын дайнд оролцсон ажээ.

비격, 飛擊, **пигйөг** тэсрэх бөмбөг нь Чосөн улсын үеийн нууц зэвсэг бөгөөд, тэнгэр ниргэж байгаа мэт дуугардаг учраас ингэж нэрлэсэн гэдэг ба өнөөгийн их бууны сумтай зүйрлэж болно. Хар луу жилийн Японы довтолгооны үед бүтээсэн яст мэлхий байлдааны хөлөг онгоц (거북선) болон пигйөг тэсрэх бөмбөг нь япончуудыг үлдэн хөөхөд их тус болсон гэдэг. “Японтой байлдахад Солонгосын пигйөг тэсрэх бөмбөгийг дийлэх зэвсэг байгаагүй” гэж тухайн

үеийн цэргийн жанжин Ким Хай (김해) “Орон нутгийн цэргийн өдрийн тэмдэглэл” (향병일기)-дээ тэмдэглэсэн байдаг байна.

비변사, 備邊司, **Пибйонь жанжин штаб** гэдэг нь Чосонь-ий цэргийн хэрэг хариуцсан ерөнхий газар ажээ.

사간원, 司諫院, **Сагань хааны зөвлөл** нь Чосонь-ий үед хааны үйлдлийн зөв бурууг шүүн тунгааж, алдааг залруулахыг зөвлөх ажлыг хариуцан ажилладаг байсан газар ажээ. 1401 онд байгуулагдсаныг Йоньсаньгүний үед татан буулгаснаа Чүнжоны үед дахин ажиллуулах болжээ.

сарим, 사림파 士林派, 士林, Sarim: сарим гэдэг нь ууланд болон хээр талд хүнзийн суртлыг сурч байсан бичгийн эрдэмтэй хүмүүсийг хэлдэг бөгөөд 15-р зуунаас хойш Чосонь улсын дунд үед гол улс төрийн ертөнцийг удирдаж байсан улс төрийн бүлэглэл юм. Корйө улсын сүүл үед хүнзийн суртлыг баримтлагч Килжай 길재(吉再) чөлөөнд гарч төрсөн нутагтаа очиж хоцрогдлыг арилгах ажилд гар бие оролцсоны үр дүнд Йоннам (영남) бүс нутагт түүний шавь нар ихээр төрөн гарч Чосонь улсын үед хүнзийн суртлын бүлгэмийг байгуулсан ба улс төрд шууд оролцдог том газрын эзэд болох Хүньгү нарын урсгалынхан (훈구파)-тай зөрчилдөж Саримчуудын урсгал 사림파(士林派) гэж нэрлэгдэж болжээ. Түүнээс гадна хүнзийн суртлыг тахин шүтэгчид ч гэж тэдгээрийг дууддаг байжээ. Дундыг баримтлагч түшмэл, язгууртанг залгамжилж байжээ. Килжайгийн шавь Ким Сүг жа (김숙자) болон түүний хүү Ким Жон жиг (김종직) нар Йоннам нутгийн хүнзийн суртлын багш нар бөгөөд, тэдний удирдлага дор Ким Гойн пил (김광필), Жөн Йө чан (정여창), Ким Ил сонь (김일손) нар гарч ирсэн бөгөөд Сонжон (성종) вангийн үед төрийн гол хэрэгт олноороо оролцдог байжээ. Ийм хүмүүсийг Саримчуудын урсгал гэж нэрлэдэг байсан нь улсын сэхээтнүүдтэй харьцуулахад шинжлэх ухааны чиг хандлага нь өөр байснаас гадна ихэвчлэн гурав, дөрвөн бүлэг хэвлэлийн эх

бичгийг хариуцдаг байсантай холбоотой байжээ. Эдгээр хүмүүс хүнзийн суртлыг улс төрд биелэлээ олоход хүчин зүтгэж байсан ба улс төрийн ертөнцөд хэдийнээ байр сууриа эзэлчихсэн Хүнзгү нарын урсгалынхантай зөрчилдөн байж Чосөн улсын нийгэмд шинэ үзэл суртлын ид хавыг цогцлоожээ. Энэ хүмүүс гарч ирснээр нийгэм дахин давтагдаж хэсэг хугацаанд том цохилт авч байсан хэдий ч Саримчуудын урсгалынхан Бичгийн хүрээлэн болон Тосгоны журамд тулгуурлан хүнзийн суртлын хууль дүрмээ тасралтгүй үргэлжлүүлэн хөгжүүлж байжээ.

사색, 四色, **сасэг** дөрвөн өнгөтөн гэж “хуучин, шинэ номлолынхон болон өмнөдийхөн, умардыхан”-ыг нэрийддэг байжээ. Кожон вангийн эцэг Хынсөн Тайвоньгүнъ (흥선대원군) төр барьж байхдаа “сасэг” дөрвөн хүчинг төрийн албанд зүтгэх адил тэгш бололцоогоор хангасан бөгөөд энэ нь орон нутаг, нийгмийн гарлаар ялгаварлах үзлийг үгүй хийх нэг алхам болжээ. Тэрбээр өмнөх эрх баригчдын алдаа завхарлыг залруулж, вангийн засаглалыг бэхжүүлэх, вант улсаа хүчирхэгжүүлэх зорилготой шинэчлэлт хийж байсны нэг алхам нь байжээ. Эдийн засгийн хувьд ч мөн уг шинэчлэлтийн дагуу бодлого явуулж байжээ.

사장, 社長, 1. **агуулах хариуцагч** – Чосөн-ий үед тариа буудайг иргэдэд зээлээр өгч, өссөн хэмжээтэй эргүүлэн авах зориулалттай тариа буудайн агуулах хариуцагч. 2. захирагч – Чосөн-ий үеийн орон нутгийн засаг захиргааны нэгэн нэгжийн захирагч.

사전, 私田, **хувийн газар** гэдэг нь Корйё болон Чосөн улсын үед Санхүүгийн төв байгууллагад татвар төлдөг “албаны газар (공전)”-тай адилгүй, татвараас чөлөөлөгдсөн газрыг хэлдэг байжээ. Хувийн газар (사전) нь улс нийтийн албан үүргийг хэрэгжүүлдэг байгууллага, хувь хүнд газрыг хуваарилж өгөх буюу тэрхүү газраас гарсан үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэг хэсгийг татвар болгон хурааж авах эрхийг хуваарилах маягаар олгогддог байжээ. Чосөн улс байгуулагдахын яг өмнө И Сөнге (이성계) ийм газрыг улс “вангийн газар” болгон мэдэлдээ авч, түүнийг тодорхой хэмжээнд хуваарилж олгодог “хувийн газар” болгон тогтоогоод, өөр газрын эзэд ийм газрыг хамаагүй хэрэглэхийг

хоригложээ. Чосөнъ улсын дунд үед албан байгууллага (관공서)-д л хуваарилагддаг байсан “хувийн газар” нь нийтийн ажил үүрэгт зориулагдсан газар гэдэг утгаар “албаны газар (공전)” хэмээн нэрлэгдэж, харин татвар төлдөг байсан “албаны газар” нь хувь хүний эзэмшил мэт ойлгогдох болж, “хувийн газар” хэмээн нэрлэгддэг ойлголтын эсрэг үзэгдэл бий болж байжээ.

사초, 史草, **түүхэн тэмдэглэлийн эх ноорог** нь Чосөнъ-ий үед бичгийн түшмэд тухайн үеийн түүхэн үнэнийг тэмдэглэж бичсэн “Түүхэн тэмдэглэл” зохиолын эх ноорог юм.

사화, 士禍, **түшмэдийн дарангуйлал** гэдэг нь Чосөнъ-ий үед урсгалуудын зөрчлөөр сарим угсаа гаралтай захирагч, билгүүн номч нар сөрөг урсгал болох хүнгү нарт дарамтлуулж байсныг нэрлэсэн үг ажээ. Шар морин, хөх хулгана, шарагчин туулай, хөхөгчин могой жилүүдэд түшмэдийн дарангуйлал гарч байжээ.

삼-공형, 三公兄, **самгонхйөн** гэж Чосөнъ улсын эхэн үед хожан (호장), кигванъ (기관), чангё (장교) гэх гурван зэрэг дэв бүхий хянри нарын тэргүүнийг нэрлэдэг байжээ. Хожан гэдэг нь нийт хянри нарыг төлөөлөх орон нутгийн чухал хүчний нэг байсан бол кигванъ гэдэг нь албан яамны ажил албыг хувааж хариуцан явуулдаг жирийн хянри нар байсан агаад, тэдний тэргүүн болох ибан (이방) нь хожан-гийн дараа орохуйц байр суурьтай байжээ. Харин чангё гэдэг нь цагдан сэргийлэх, хамгаалалтын ажлыг хариуцдаг байсан ажээ. Энэхүү гурван төрлийн хянри нарын тэргүүн болох “самгонхйөн” нь хянри-г төлөөлөн сүрйөн-г байхгүй үед күнь хйёнъ-ий ажил үүргийг орлон явуулах буюу улсын чухал арга хэмжээний үед күнь хйёнъ-ийг төлөөлөн оролцдог байжээ. Чосөнъ-ий хожуу үе болж ирэхэд самгонхйөн-оос чангё хасагдаж, тухайн бүс нутгаасаа хамааран хожан, ибан-гийн хамтаар түхйёнбан (두형방), сынбаль (승발) нар самгонхйөн-гийн нэг хэсгийг бүрдүүлж байжээ.

삼사, 三司, **гурван зөвлөл** – Чосөнъ улсын үед хаан улсын гол асуудлуудыг ганцаар шийдвэрлэлгүй, тэргүүн сайд болон зүүн, баруун тэргүүн сайдаас бүрдсэн Ыйжёнбү (의정부) гэх хувийн сайдын яамаар хэлэлцэн, гүйцэтгэлийг зургаан

яам (육조)-д даатгадаг байжээ. Мөн Сахонь төрийн хяналтын газар (사헌부), Сагань вонь (사간원), Хонмунь гвань (홍문관) гэсэн гурван зөвлөл байжээ. Энэхүү гурван зөвлөл нь хэрэгжүүлэ буй төрийн бодлогыг шүүмжлэн, түшмэлүүдийн ёс бус үйлдлийг илрүүлж, таслан зогсоох үүрэгтэй байжээ. Тус гурван зөвлөлд үнэнч шударга, залуу боловсон хүчнийг сонгож, үнэн зөв мэдээллийг цуглуулдаг байжээ. Гурван зөвлөл (삼사) нь эзэнт хаант тогтолцоог хадгалахын зэрэгцээ бодлого хэрэгжих явцад гарсан алдаа дутагдал, шударга бус үйлдлийг таслан зогсоох үүрэгтэй байсан ба энэ нь Чосонь-ий төрийн онцлог байсан ажээ.

삼수미, 三手米, **гурван цэргийн зориулалттай татварын будаа** гэдэг нь Чосонь-ий үед тодорхой цалинтай цэргийг бэлтгэхэд хэрэглэх зориулалттай хураадаг байсан татварын будааг нэрийддэг байжээ. →삼수량(三手糧)

삼수병, 三手兵, **гурван цэрэг** – Сөнъжогийн 27-р /1594/ онд бий болсон их бууч, харваач, жадчин цэргийг нэрийдсэн үг юм. →삼수(三手)

삼전도, 三田渡, **самжоньдогийн гаталга** гэдэг нь Сөүл болон Кванжү хотыг холбох Хань гол дээрх бярвааз гаталга юм. Одоогийн Сонпха дүүргийн Самжонь хороонд байрлах ба тус газар Чосонь улсын 16 дахь Инъжо ван 1636 оны Манчүг-ийн самууны үеэр Хятадын Чин улсад бууж өгчээ. Энэ тухай Самжонь хорооны хадны бичээсэнд тэмдэглэгдсэн байдаг ажээ.

상민수륙무역장정, 商民水陸貿易章程, **худалдаачин иргэдийн усан ба хуурай замын худалдааны журам** бол 1882 онд үйлдсэн журам бөгөөд, энэ журмын дагуу хятад хүн, эзэн улсын иргэний хувьд Чосонь-ий дотоодод оршин суух, худалдаа эрхлэх, аялан явах эрхтэй болсон байна. Худалдааны гэрээг Японоос хожуу хийсэн хэрнээ илүү ашигтай нөхцлөөр гэрээ байгуулж чадсан гэсэн үг юм. Үүний улмаас хятад худалдаачдын тоо эрс өсч, Чосонь-ий худалдаачдад хүнд цохилт болсон бөгөөд аяндаа жирийн иргэдийн дунд Чин улсад дургүйцэх, үзэн ядах байдал газар авч байжээ.

상평통보, 常平通寶, **санпхйөн зоос** бол Чосөнъ-ий үе буюу Инъжогийн 11-р /1633/ онд хэрэглэж байсан зоос юм. Шинэ мөнгөн тэмдэгт гарах хүртэл буюу Чосөнъ улсын сүүл үе хүртэл хэрэглэгдэж байжээ.

서열, 庶孽, **татвар эмийн хүүхэд** - Энэ нь янбанъ эрэгтэй авааль эхнэрээсээ өөр эмтэй нөхцсөнөөр төрсөн хүүхдийг нэрлэдэг нэр томъёо ажээ. Үүнийг дотор нь “сө (서)”, “өл (열)” хэмээн ангилдаг бөгөөд, эхийнх нь гарал угсаа “сайн хүн (양인)” байх тохиолдолд “сө”, эхийнх нь гарал угсаа “доорд хүн (천인)” байх тохиолдолд “өл” гэж нэрлэдэг байжээ. Сө-өл (서열) татвар эмийн хүүхдүүд гэр бүлийн дотор төдийгүй нийгмийн хувьд ч гэсэн ихэд ялгаварлан гадуурхагдаж байсан бөгөөд, түшмэлийн албан тушаалд орох бараг боломжгүй байжээ. Тэд гарал угсааны шинжтэй янз бүрийн дүрэм журам, хязгаарлалтын улмаас дардан бус амьдрал туулах ёстой байсан бөгөөд, эцэг нь өөрийн шивэгчнийг татвар эм болгон авсан тохиолдолд үр хүүхдүүдийнх нь хооронд “эзэн-боол”-ын харилцаа ч бүрэлдэж болдог байжээ.

서열금고법, 庶孽禁錮法, Янбанъ язгууртан эцэгтэй ч татвар эмийн үр хүүхдэд зэрэг дэв өгөхийг хориглосон хууль журам

서열차대, 庶孽差待, Чосөнъ улсын үед татвар эмийн үр хүүхдийг авааль эхнэрийн үр хүүхдээс ялгаварлан хандах байдал

서원, 書院, **Бичгийн хүрээлэн** нь Чосөнъ улсын үед эрдэмтэн, бичгийн түшмэд цуглан эрдэм мэдлэгээ уралдуулах юмуу өөд болсон их эрдэмтэн, үнэнч түшмэлд тахил өргөдөг байсан газар ажээ. Тухайн үеийн Бичгийн хүрээлэнгүүд нь асар том эдлэн газар, олон тооны боол зарцтай, алба гувчуур төлдөггүй онцгой эрх дарх эдэлдэг төдийгүй улс төрийн хувьд ч төрийн захиргаанаас толгой дээгүүр байж, орон нутагт онцгой эрх дарх эдэлж байжээ. Ялангуяа бичгийн түшмэл Сон Ши йөр (송시열)-ийг тахин шүтдэг Хва ян дон Бичгийн хүрээлэн (화양동서원) засгийн газраас ч илүү сүр хүчтэй, нөлөөтэй байсан гэдэг аж. Тийм учир Бичгийн хүрээлэнгүүд байгаа цагт төвлөрсөн засаглалыг бэхжүүлэх ямарваа арга хэмжээ үр дүнд хүрэхгүй нь тодорхой байсан тул Кожон вангийн 2-р (1865) онд Кожон вангийн эцэг Тайвөнъгүнъ (대원군) Бичгийн хүрээлэнгүүдийг татан буулгаж, Сон Ши йөр-ийн

гэрээслэлийн дагуу босгосон Маньдон бунхан (만동묘) хэмээх Мин улсын хааны тахилгын газрыг үгүй болгон улмаар Кожон-ы 5-р (1868) онд Бичгийн хүрээлэнгүүдээс татвар хураах болжээ. Эцэст нь Кожон-ы 8-р (1871) онд улсын хэмжээнд дөчин долоон Бичгийн хүрээлэнг үлдээж бусдыг нь татан буулгасан ажээ. Тайвоньгүн-ийн Бичгийн хүрээлэнгийн эсрэг авсан энэхүү арга хэмжээ нь тухайн үеийн хүнзийн сурталтангуудын дургүйцлийг ихэд төрүүлж байжээ.

서인, 西人, **барууныхан** гэдэг нь Чосөн-ий Сөнъжо вангийн үед Сим Ый гйөм цэргийн түшмэл тэргүүтэй зүүнийхэнтэй зөрчилдөж байсан урсгал болон түүнд хамрагдах гишүүнийг нэрийддэг байжээ.

서재필, 徐載弼, Сө Жай пхил (1864~1951) бол Солонгосын тусгаар тогтнолын хөдөлгөөний идэвхтэн, улс төрч юм. Тэрбээр Ким Ог гйүн-ы нарын хамт гаргасан хөх бичин жилийн төрийн эргэлт бүтэлгүйтсэнээс хойш Япон, Америк улсуудад дүрвэн гарч амьдарчээ. Хожим эх орондоо эргэн ирж Тусгаар тогтнолын холбоо байгуулан Солонгосын анхны иргэний сонин болох “Тусгаар тогтнолын сонин”-г хэвлүүлэн гаргажээ.

서학, 西學, **барууны судлал, католик шашин** бол Чосөн-ий үед католик шашныг нэрийдэж байсан үг ажээ.

석보상절, 釋譜詳節, “**Бурхан багшийн намтар**” гэдэг нь Чосөн-ий Сэжон-ы 29-р /1447/ онд хааны зарлигийн дагуу Сү-йан тайгүн-ы Бурхан багшийн намтрыг тайлбарын хамт Хүнъминъжөн-ым үсгээр бичсэн ном ажээ. Сэжон хааны хатан бөгөөд Сү-йан тайгүн-ий эх болох Сохөн хатан Сим овогтны хойдоход зориулан бичсэн 24 боть бүхий тус ном үндэсний 523 дахь үнэт зүйлээр бүртгэгджээ.

선물경제, 膳物經濟, **бэлэг сэлтийн эдийн засаг** гэдэг нь зах зээлээс илүүтэй бэлэг сэлтээр дамжуулан хэрэгцээтэй эд зүйлсээ олж авдаг байсан үйлдлийг нэрлэдэг ажээ. Чосөн-ий нийгмийн хамгийн дээд давхарга болох янбань (양반) өөрийн улс төр, эдийн засгийн байр суурь, танил талын сүлжээг ашиглан, бусдаас бэлэг авах үйлдэл нэлээд түгээмэл байжээ. Бэлэг сэлтийн

ихэнх хэсгийг орон нутгийн захирагч (지방관) нар хариуцаж байсан агаад, кванъчхальса (관찰사)-гаас авахуулаад орон нутгийн күнь (군)-ий захиргааны доод зэрэглэлийн сүрйөн (수령) хүртэл өөрийн күнь-ий захиргаанаас бэлэн бүтээгдэхүүнээр хурааж авсан газрын татвар, алба татварын нэг хэсгийг янбанъ нарт бэлэг сэлтийн хэлбэрээр өгдөг байжээ. Ийм бэлэг сэлт хурааж авах үйлдэл нь зах зээл хөгжихийн өмнө янбанъ нар өөртөө хэрэгцээтэй эд зүйлсийг олж авах гол арга байсан гэж үздэг бөгөөд, ийм эдийн засгийн хэлбэрийг зах зээлийн эдийн засагт хандах логигоор бэлэг сэлтийн эдийн засаг хэмээх нэр томъёогоор нэрлэдэг ажээ.

성읍, 城邑, **бэхлэлттэй хот балгад** нь Чосонь-ий үед орон нутгийн засаг захиргааны нэгж болох хот, дүүрэг, хороо, тосгон зэргийг нийтэд нь нэрийдсэн нэр ажээ.

성절사, 聖節使, **Сөнжол хааны төрсөн өдрийн элч** гэдэг нь Чосонь-ий үед Хятадын Эзэн хааны мэндэлсний ойн баяр хүргэхийн тулд жил бүр илгээж байсан элчийг нэрийдсэн үг ажээ.

성호사설, 星湖僊說, “**Сөнхо-гийн түүвэр зохиол**” гэдэг нь Чосонь-ий Йөнжо хааны үед бодит судлалын эрдэмтэн И-иг-ийн жирийн үеийн тэмдэглэл болон шавь нарын асуултад хариулсан агуулга бүхий бичээс бөгөөд, 1740 онд үеэл дүү нар нь 30 боть 30 ном бүхий зохиол болгон эмхэтгэсэн нь тэнгэр газар, түмэн бодис, хүний аж амьдрал, шүлэг зохиол гэсэн хэсгүүдээс бүрдэх ба өргөн мэдлэг, оновчтой судалгааны дүгнэлт гаргасан байдгаараа олноо танил болжээ.

세도, 勢道, **дарангуйлал** гэж улс төрийн хувьд засаглалыг гартаа атгах хүчнийг нэрийддэг. → 권세(權勢), 권력(權力), 세력(勢力)

세도정치, 勢道政治, **дарангуйллын засаглал** гэж Чосонь-ий үед хааны итгэлийг олсон түшмэл юм уу, хатан эхийн талаас улс төрийн эрхийг барин улс гүрнийг захирах хэвийн бус засаглалын хэлбэрийг хэлдэг ажээ.

세종, 世宗, Sejong, Sejong the Great, **Сэжон ван** (1397. 5.7~1450.3.30) бол Чосонь улсын дөрөв дэхь хаан бөгөөд, 1418 оны 9 дүгээр сарын 9 ний өдрөөс 1450

оны 3 дугаар сарын 30 ны өдөр хүртэл хаан ширээнд суужээ. Сэжон вангийн ололт амжилтыг хүндэтгэх утгаар "Сэжон их хаан" (세종대왕) хэмээн нэрийдэх болжээ. Тэрээр Чосөн улсын дөрөв дэх хаан бөгөөд Тхайжон ван болон Вөнъгийн хатан хоёрын хүү билээ. Түүний ах болох Йан нйөн Тайгүнъ (양녕대군)-ийг огцрох үед түүнийг угсаа залгамжлах ханхүүгээр өргөмжилж, Тхайжон вангийн хаан ширээг залгамжилжээ. Сэжон ван бол шинжлэх ухаан, технологи, урлаг, соёл, улс орноо хамгаалах зэрэг олон салбарт гайхалтай амжилт гаргасан хаан байжээ. Тэрээр ард иргэддээ зориулан газар тариалан эрхлэх тухай ном хэвлүүлсэн боловч, бичиг үсэг мэддэггүйгээс болж уншиж чадахгүй, ойлгохгүй байгааг хараад ямар ч хүн амархан сурч болох үр ашигтай, шинжлэх ухааны тогтолцоотой Хүнминъ чөным (훈민정음) үсэг бүтээжээ. Хүнминъ чөным үсгийг зохиосон цагаас эхлэн хааны гэр бүл болон энгийн иргэд хэрэглэж байгаад, 20-р зууны үед Ханъгыл (한글) үсэг болгон хөгжүүлж, одоо цагт БНСУ-ын албан ёсны үсэг болгон өргөнөөр хэрэглэж байна. Сэжон ван шинжлэх ухаан, технологид ч мөн адил анхаарал хандуулж, тэнгэрийн бөмбөрцөг-хонъчөнъый (혼천의), нарны цаг-анбүилгү (양부일구), усан цаг- чагйөгрү (자격루), хур тунадас хэмжигч-чыгүги (측우기) зэргийн шинээр зохион бүтээсэн бүтээлүүдийг бүх талаар нь дэмжиж, Чан Йөншил (장영실), Чой Хайсанъ (최해산) зэрэг эрдэмтдийг нийгмийн байр сууринаас нь илүү дэмжиж байжээ. Улсыг батлан хамгаалах ажилд И Жөнмү (이종무)-ийг томилон далайн дээрэмчдийг дарж Цүшима (대마도) арлыг булаан эзэлсэн бөгөөд, И Жиног (이정옥), Чой Йүнъдөг (최윤덕), Ким Жонсө (김종서) нарыг хойд нутаг руу явуулж Пхйөнәнъ муж (평안도) болон Хамгил муж (함길도)-д харьяалагдах Зөрчид овог (여진족)-ийг хилээр гаргаад 4-р арми, 6-р цэргийн лагерийг нээж, улсын хилээ Ялу гол, Түманъ голын сав газар хүртэл өргөжүүлжээ. Түүнчлэн ард түмнээ нүүлгэн шилжүүлж амьдруулахад таатай байлгах үүднээс энгийн иргэдэд чиглэсэн бодлого (사민정책) хэрэгжүүлж улс орноо тэнцвэртэй хөгжүүлэхийн төлөө хүчин зүтгэж байжээ. Улс төрийн хувьд, Хван Хый (황희), Майн Сасөн (맹사성), Йүнъ Хой (윤회), Ким Жонсө (김종서) нарыг албан тушаалд томилж, төрийн хэргийг удирдсан хэдий ч энэхүү удирдлагын тогтолцоо нь нэг төрлийн танхим төвтэй улс төрийн

тогтолцоо болох Ыйжөнбү-хувийн сайдын яам болон зургаан яаманд төвлөрсөн улс төрийн тогтолцооны эхлэл болж байжээ. Үүнээс гадна хуулийн эмхэтгэл, соёлыг цэгцэлж, газар нутгийг үржил шимээр нь зургаан зэрэглэлд хуваан өөр өөр татвар ногдуулдаг тогтолцоо (전분육등법) болон татвар ногдуулах шалгуур (연분구등법) зэргийн хууль тогтоомжийг баталж, татварын тогтолцоог бий болгох ажил нь ч гэсэн биелэлээ олжээ.

소론, 少論, **соронь залуусын хүчин** бол Чосөн-ий үед барууныхан “норонь”, “соронь” гэж хуваагдсан бөгөөд, энэ хоёр хүчний нэгийг хэлдэг аж.

솔혹, 率蓄, **солхйүг** гэдэг нь улсын байгууллагад харьяалагддаг дууч эмийг татвар эм болгохыг ийнхүү нэрлэдэг байжээ. Чосөн-ий янбань нар авааль эхнэрээс гадна татвар эм авах тохиолдол элбэг байсан бөгөөд, татвар эм болох эмэгтэй нь ерөнхийдөө дууч эм, эсвэл эмэгтэй боол байдаг байжээ. Албаны дууч эм нь улсын “нийтийн эд” тул тэднийг татвар эм болгох нь хууль зөрчсөн хэрэг байсан хэдий ч, тухайн үед ийм үйлдэл нэлээд дэлгэрч байсан ажээ. Улсаас энэ асуудлыг шийдэхийн тулд албаны дууч эмийг угийн ажлын газарт нь буцаахыг шаардсаар байсан боловч, уг асуудлыг үндсэндээ шийдэж чадаагүй ажээ.

쇄국정책, 鎖國政策, **Хаалттай хаалганы бодлого** гэдэг нь өөр улс оронтой худалдаа, харилцаа тогтоохыг хориглон хязгаарласан бодлого юм. XIX зууны дунд үе гэхэд өрнөдийн орнуудын усан онгоцнууд Чосөн улсын хил хязгаар газраар эргэлдэн тандах нь олширч, улмаар худалдаа хийхийг шаардах болжээ. Тухайн үед болсон Чин улсын хар тамхины дайн, Эроу (Arrow)-гийн хэрэг зэрэг шил шилээ даран гарсан хэрэг явдлуудыг харсан Чосөн улсын хувьд дотооддоо ч тайван бус байсан учир өрнөдийн орнуудтай мөргөлдөхгүй байх арга зам бол тэдний худалдаа хийх шаардлагыг хүлээн авахгүй байх явдал гэж үзжээ. Мөн хил хязгаараа чандлан хаах болсон өөр нэг шалтгаан нь католик шашиныг түгэн дэлгэрэхээс болгоомжилж байсан учир өрнөдийн орнуудтай харилцаа тогтоохоос татгалзах нь зүйн хэрэг байжээ. Тиймээс Тайвөн-гүн-ий засаглал дорхи Чосөн улстай эвийн замаар худалдааны харилцаа тогтооно гэдэг боломжгүй гэдэг нь тодорхой байсан тул өрнөдийн хэд хэдэн орон цэрэг

зэвсгийн хүчээр сүрдүүлээд ч атугай худалдаа хийхийг зөвшөөрүүлэх гэж оролдож байжээ.

쇄미록, 瑣尾錄, Суэмирог (1591-11-1601.2) нь нийслэлд суурилсан янбань О Хый мүнъ-ий хар луу жилийн самууны үед зохиосон өдрийн тэмдэглэл ажээ. “Суэмирог (쇄미록) гэдэг нь “Шүлэглэлт ном”-оос эш татсан “дорой бөгөөд өчүүхэн, хэрэн хэсэж явдаг аянчин” хэмээх утгатай ажээ. Энэхүү өдрийн тэмдэглэлд О Хый мүнъ-ийг дайны самууны аюулаас зугтааж Чхүнчхондо (춘천도) -гийн Имчхонъ (임천)-д 4 жил, Канвонъдо (강원도) -ийн Пхйонган (평강)-д 4 жил ядуу зүдүү амьдарч байсан дүр төрх туссан агаад улмаар О Хый мүнъ-ий дуулж сонссон хар луу жилийн самууны дайн тулааны нөхцөл байдал, И Сүнъшинъ (이순신) жанжин далайн тулалдаанд идэвхтэй байлдсан зэргийг тэмдэглэсэн тэмдэглэл ажээ.

수미법, 收米法, будаагаар татвар төлөх хууль гэдэг нь Чосонъ-ий үед хааны өргөө болон албан газруудад өргөх онцгой бүтээгдэхүүний гувчуурыг тутрагаар төлөхөөр тогтоосон хууль захирамжийг хэлдэг байжээ.

수신전, 守信田, үнэнч эхнэрт соёрхсон газар гэдэг нь Чосонъ-ий эхэн үед газар соёрхон авсан түшмэл нас барж, эхнэр нь бэлэвсэрсэн тохиолдолд өвлүүлдэг байсан тутраганы талбайг ийнхүү нэрлэдэг байжээ.

승정원, 承政院, Хааны Сынжон тамгын газар гэдэг нь Чосонъ-ий үед хааны зарлиг тушаалыг бичиж тэмдэглэн, олонд мэдүүлэн тараадаг тамгын газрыг нэрийддэг байжээ. Чонжоно 2-р /1400/ онд Хааны зарлиг түгээн хүргэх газар хэмээн нэрээ өөрчилжээ. →은대(銀臺), 정원(政院), 후원(喉院)

식민주의사관, 植民主義史觀, колоницлолын түүхэн үзэл – Японы империализмын үед солонгос хүнийг хялбар захирах зорилго бүхий улс төрийн болон бүтцийн хувьд нарийн төлөвлөсөн, Японы колоницлолыг зөвтгөх гэсэн түүхэн үзэл юм. Өөрөөр хэлбэл, япончууд солонгос үндэстэн нь түүхэн хөгжлийн үйл явцад өөр улс орны хамааралд байж ирсэн ба бие даан хараат бус оршин байх чадваргүй хэмээн онцлох замаар өөрсдийн дарангуйллыг хаацайлах гэсэн түүхэн үзэл ажээ.

신간회, 新幹會, **Шиньганъхой** нь 6 дугаар сарын 10-ны хөдөлгөөн гарсны дараах жил 1927 онд коммунистууд, үндсэрхэг үзэлтнүүдтэй нэг фронтод нэгдэн, үндэстний нэгдсэн улс төрийн байгууллага Шиньганъхой-г байгуулжээ. Япон энэ үед соёлт засаглалын бодлогоо тунхагласан үе байсан бөгөөд, мөн Хань улсын тусгаар тогтнолын хөдөлгөөний дотоод хүчийг тандан мэдэх зорилгын үүднээс ч юм уу, Шиньганъхой-г хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрсөн ажээ. Шиньганъхой жанжин шугамаа дараах гурван зүйлээр тодорхойлж байжээ.

- Бид зусар зулгуйг арилгана.
- Бид улс төр, эдийн засгийн ухамсрыг дээшлүүлнэ.
- Бид эв нэгдлийг бэхжүүлнэ.

Шиньганъхой Японы байнгын мөрдлөг хавчилгын улмаас үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулж чадахгүй байсан ч улс даяар олон салбартай болж, гишүүдийн тоо нь гучин мянга хүрсэн байна. Кынь Ү хой (근우회) хэмээх эмэгтэйчүүдийн байгууллага Шиньганъхой-гийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллаж байснаас үзэхэд ард түмэн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг хэрхэн дэмжиж байсан нь тодорхой ажээ. Кванжугийн оюутны эсэргүүцлийн хөдөлгөөн гарахад Шиньганъхой-гаас баг илгээж, бүх нийтийг хамарсан цуглаан хийхээр төлөвлөх зэргээр оюутнуудыг дэмжиж байжээ.

신기전, 神機箭, Singijeon, Singichon: **шиньги жөнъ** (байлдааны сум)-ыг Чосөнъ улсын үе болох 1448 он (Сэжон ваны 30 жил)-д үйлдвэрлэж эхэлсэн ба 17-р зууны сүүл үе хүртэл өргөн хэрэглэж байсан хатуу биет пуужин гэж хэлж болно. Цэргийн зориулалттай пуужингийн сумаар ашиглаж байжээ. Сэжон вангийн захирч байсан Чосөнъ улс нь шинжлэх ухаан, техник технологийн судалгаанд хүчээ сорьсны үр дүнд тухайн үедээ хамгийн шилдэг пуужингийн технологийг эзэмшиж байжээ. Пуужин харвахад зориулж хийсэн сум харвагч тэрэг болох Шиньги жөнъ бол зураг нь хадгалагдаж үлдсэн олон хөөргөх системтэй пуужингийн харвах төхөөрөмж юм. Үйлдвэрлэх явцын тухай нарийвчилсан материал нь “Цэргийн зэвсгийн зурагтай тайлбар” (병기도설)-т хадгалагдаж байгаа бөгөөд, дэлхий дээрх хамгийн урт хугацаанд хадгалагдаж

байгаа дахин харвах боломжтой пуужингийн сум гэж 1975 онд анх эрдэмтэн Чай Йёнъ сөг (채연석) судалсан байна. <Кйөнхян сонин (경향신문) 1975.11.22>

Чай Йёнъ сөг эрдэмтэн 1993 онд Дайжёнъ (대전) хотод болсон үзэсгэлэнгээр бага, дунд хэмжээний пуужингийн сум болон сум харвагч тэргийг сэргээн засварлаж 1993 оны 4 дүгээр сарын 27ны өдөр тус хотын Кабчонъ (갑천) гэх газрын ойролцоо анх олонд нээлттэйгээр пуужин харвах туршилт хийж байжээ. Шиньги жонъ бол Корйё улсын үед Чой Мү сөнъ (최무선) гэх хүн олж нээсэн пуужингийн зэр зэвсэг бөгөөд химийн бодист тулгуурлан хийсэн зүйл гэдэг. <Чосонъ улсын хаадын судар бичиг>-т тэмдэглэгдсэнээс үзвэл 1592 оны Хар луу жилийн Японы довтолгооны үеэр “Яст мэлхий” онгоцтой хамт хамгийн гол чухал зэр зэвсгээр хэрэглэж байсан гэдэг. Гэхдээ Шиньги жонъ сум харвагч тэрэг нь тэсрэх бодис болох дарь хэрэглэх хэмжээ маш их байсан бөгөөд онох магадлал бага байсан учир үр дүн багатай байсан гэдэг. Шиньги жонъ сум харвагч тэрэг хэмжээ болон хэлбэр дүрснээсээ хамаарч том Шиньги жонъ (대신기전 (大神機箭)), хүчиллэг Шиньги жонъ (산화신기전(散火神機箭)), дунд Шиньги жонъ 중신기전(中神機箭), жижиг Шиньги жонъ 소신기전(小神機箭) гэх мэт олон төрөл байжээ.

신부, 信符, **итгэмжит пайз** бол Чосонъ-ий үед гэнэтийн хэрэг гарсан тохиолдолд хааны ордонд орж гарах зөвшөөрсөн тэмдэг болгон тодорхой тооны зарц нарт тарааж өгдөг байсан модон пайз ажээ.

신유박해, 辛酉迫害, **1801 оны католик шашиныг хавчсан хэрэг** – Католик шашин нь Хятадтай байнгын харилцаатай элчээр дамжин Чосонъ улсад орсон иржээ. Тухайн үеийн сэхээтнүүд католик шашиныг эрдэм боловсрол хэмээн үзэж судлан, тус шашинг өөрсдийн итгэл үнэмшил болгож байжээ. Католик шашин нь бүх хүн төрөлхтөн бурханы өмнө эрх тэгш, нас барсны дараа ч тэнгэрийн оронд заларна гэж сургадаг учир хувраг, эмэгтэйчүүд, эгэл ардын дунд өргөн тархжээ. Ийнхүү католик шашин аажмаар дэлгэрсэн нь эрх тэгш байдлыг

тэргүүнд тавьж, өвөг дээдэстээ тахил өргөхийг эсэргүүцэн, улсын дэг журмыг гажуудуулж байна гэж төр засаг шүүмжилж, католик шашиныг хоригложээ. Сүнъжо (순조) ван хаан ширээнд сууснаар засгийн газар тус шашинг шахан хавчиж эхэлсэн бөгөөд, маш олон католик шашинтнууд цаазаар авахуулж, католик шашиныг дэлгэрүүлэгч өрнөдийн санваартны амийг хороожээ. Энэ үйл явдлыг түүхэнд “Католик шашиныг хавчсан хэрэг (신유박해) хэмээн нэрлэдэг ажээ.

신진사대부, 新進士大夫, **шинэ садайбү буюу шинэ сэхээтэн язгууртан** гэдэг нь Корйе улсын хожуу үед Чосөнъ улсыг үүсгэн байгуулсан шинэ хүчийг хэлдэг ажээ. Шинэ садайбү нар бол нийгмийн зөрчлийг үнэн зөвөөр ухамсарлан, бодит байдлыг шүүмжлэх нийгмийн шинэ түшмэдийн давхарга ажээ.

신탁 통치, 信託統治, **Холбоотны засаглал** гэдэг нь НҮБ-аас хүлээн зөвшөөрсөн улс, тусгаар улсын хувьд бие даах чадваргүй, улс төрийн үймээнтэй бүс нутгийг түр хугацаанд хариуцан асрах засаглал юм. 1945 оны 12 дугаар сард Америк, Англи, ЗХУ-ын Гадаад хэргийн сайд нарын уулзалт Москвад болж, Солонгосын хойгийн асуудлыг хэлэлцжээ. Энэхүү уулзалтаар Солонгосын хойгт ардчилсан Түр засгийн газар байгуулахаар шийдэж, Америк-Зөвлөлтийн хамтарсан хороо байгуулан, таван жилийн хугацаанд Холбоотны засаглал тогтоохоор шийдвэрлэжээ. Холбоотны засаглалын асуудлаар баруун, зүүний чиг баримтлалаараа хоёр хуваагдан, Солонгосын нийгэм задарч үймээн самуун болжээ.

실학, 實學, **Сирхаг бодит судлалын ухаан** нь Чосөнъ-ий сүүл үе буюу 17-р зуунаас 19-р зууны эхэн хүртэл хүчтэй тархсан, бодит явдалд үндэслэн үнэнийг судалж, бүтээлч санаа, чадварыг хүний аж төрөхөд арга хэрэгсэл болгон ашиглах тухай, улс төр, эдийн засгийн асуудал, шинжлэх ухаан, технологи, түүх, утга зохиол, уламжлал гэх мэтийн салбар дахь солонгосын соёлын тухай өргөн судалгаа явуулан тухайн үеийн Чосөнъ улсад өөрчлөлт, хувьсгал шаардлагатай хэмээн үзсэн үзлийг хэлдэг ажээ.

십삼도 창의군, 十三道 倡義軍, **13 мужийн шударга цэрэг** гэдэг нь 1907 оны 12 дугаар сард нийслэл хот руу дайралт хийхийн тулд Солонгос даяар цугларан байгуулагдсан сайн дурын шударга цэргийн арми ажээ. 1907 оны улаагчин хонь жилийн Долоон гэрээгээр татан буугдсан зарим цэргүүд тус армид элссэнээр хүчин нэмэгдсэн ба И Инь-йөн-ийг ерөнхий удирдагчаар томилон нийт 10000 цэрэг бүхий шударга цэргийн 13 ангийг бүрдүүлжээ.

십삼도, 十三道, **13 муж** – Чосонь-ий үеийн 1896 онд орон нутгийн тогтолцоог шинэчилж, Өмнөд Челла, Хойд Челла, Өмнөд Чхүнчхөн, Хойд Чхүнчхөн, Өмнөд Кйёнсан, Хойд Кйёнсан, Кйёнги, Хванхай, Канвөнъ, Өмнөд Пхйён-анъ, Хойд Пхйён-анъ, Өмнөд Хамгйён, Хойд Хамгйён гэсэн нийт 13 мужид хуваасан бөгөөд, энэ нь 1946 он хүртэл мөрдөгджээ. →조선십삼도(朝鮮十三道)

아관파천, 俄館播遷, **Оросын элчин сайдын яаманд хоргодох** – Чосонь-ий сүүл үеийн 1896 оны 2 дугаар сарын 11-ээс 1897 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Кожон ван ханхүүгийн хамт Оросын дипломат байгууллагын байранд амьдрахаар орсон явдлыг ийнхүү нэрлэдэг ажээ. →노관파천(露館播遷)

압양위천, 壓良爲賤, **“сайн хүн (양인)”-ийг “доорд хүн (천인)” болгох** гэдэг нь янбанъ түшмэл хууль зөрчиж, хүсэлт гарган жирийн “сайн хүн”-ийг өөрийн боол болгох үйлдлийг хэлдэг байжээ. Ийм үйлдлийг Чосонь-ий нийгэмд янбанъ садэбү нарыг улсын захирах дэг журмаас урваж, хувийн эрх ашгаа дээгүүр тавьсан үйл ажиллагаа хэмээн үздэг байсан тул янбанъ-ы ёс зүйд нэлээд хүнд цохилт болдог байжээ.

양부일구, 仰釜日晷, Angbu-ilgu: **Анбү-илгү нарны цаг** нь 1434 онд Чосонь улсын Сэжон вангийн төр барьснаас 16 жилийн дараагаар зохион бүтээж хэрэглэгдэж байсан нарны цаг бөгөөд, шинжлэх ухаан, түүх, урлагийн үнэт зүйлээр хүлээн зөвшөөрөгдөж 1985 оны 8 дугаар сарын 9 өдөр БНСУ-ын 845 дугаарын үнэт эрдэнэсээр бүртгэгджээ. Анбү-илгү хэмээх нарны цагийг Чан Йён шил (장영실), И Чёнъ (이천), Ким Жо (김조) нарын эхэн үеийн зохион бүтээгчид оролцож хийсэн гэдэг ба энэ үед зохион бүтээсэн нарны цаг нь хадгалагдаж үлдээгүй тул 18-р зууны үед зохион бүтээгдсэн цагийг улсын

үнэт эрдэнэсээр бүртгэжээ. Үнэт эрдэнэсээр бүртгэгдсэн үүрэн нарны цаг нь халаасандаа хийж болохуйц жижигхэн хэмжээтэй хэрнээ бат бөх хийгдсэн зүйл ажээ. Үүнээс гадна Чан Йөн шил зохион бүтээгчийн модон дугуй хэлбэрийн элсэн цаг, тэнгэрийн бөмбөрцөг, нарны цаг, элсэн цаг, хадны бичээсийг бичиж тэмдэглэсэн ном зэрэг зохион бүтээсэн бүтээлүүд байжээ.

알타협정, Yalta Agreements, **Ялтагийн хэлэлцээр** гэдэг нь Дэлхийн 2-р их дайны сүүл буюу 1945 оны 2-р сарын 4-11-ний хооронд Оросын Крымын хойгийн Ялта хотноо Америкийн ерөнхийлөгч Рузвельт, Английн ерөнхий сайд Черчилль, Оросын тэргүүн Сталин нарын хийсэн хэлэлцээрийг хэлдэг ажээ. Энэ нь 2 дугаар сарын 11-нд дайныг дуусгаж, түүний дараа авах арга хэмжээнүүдийн тухай агуулга бүхий гэрээ байжээ. →알타비밀협정(Yalta 秘密協定)

양반, 兩班 Yangban: **ноёлогч бүлэг янбань** бол Корйө, Чосөнь улсын үеийн хамгийн дээд нийгмийн давхарга бөгөөд, Са 사(士), Нон 농(農), Гон 공(工), Сан 상(商) гэсэн давхаргын Са давхаргад багтдаг байжээ. Янбань нь Чосөнь улсын үед төрийн хэрэгт оролцох боломжтой түшмэл болон түшмэл болох магадлалтай далд нөөц бололцоотой удам угсааны хүн ажээ. Мөн Сарим гэж нэрлэгддэг байсан хүнзийн суртлыг баримтлагчдын давхаргыг хүртэл хамруулдаг вангийн удам угсааны онцгой нийгмийн давхарга ажээ. Эхэндээ бичгийн түшмэл, цэргийн түшмэлийн үүрэг гүйцэтгэдэг албан тушаал байсан бол Янбань болон дээд албан тушаалтныг ангилдаг тогтолцоо гарч ирснээр хэргэм зэргийн утга, чиг үүрэг өөрчлөгдөх болжээ. Янбань нь газар болон боол эзэмшдэг байсан бөгөөд Орогсдын шалгалт, шалгалтгүй албан тушаалд томилох, нэрийг дэвшүүлэх зэрэг ажлаар дамжуулан улсын дээд албан тушаалыг ганцаар эзэгнэдэг байжээ. Янбань нь эдийн засгийн байр сууриараа газрын эзний давхарга, улс төрийн байр сууриараа түшмэлийн давхаргад багтдаг байсны хувьд үйлдвэрлэх ажилд оролцолгүй зөвхөн өөрийн хариуцаж буй албан ажлаа хийхээс гадна түшмэл болох бэлтгэл ажилтай холбоотой ажлаа хийх юмуу хүнзийн суртлыг баримтлагчийнхаа хувьд ерөнхий мэдлэг болон мэргэжлийн ур чадвараа сайжруулахад хүчин зүтгэдэг байжээ.

양안, 量案, **газрын данс** гэдэг нь улсаас татвар ноогдуулахын тулд газрыг хэмжиж, зохиосон газрын данс бүртгэл ажээ. Газрын данс нь гувчуур хураах үндсэн данс бөгөөд, түүнийг чөнь-ань (전안), тохэнжан (도행장) гэх мэтээр нэрлэдэг байжээ. Газрын дансанд тариан талбайн орших газар, өргөн, газрыг эзэмшигч буюу түрээсэлж тариа тарьдаг тариачид төдийгүй газрын төрлийг хүртэл тэмдэглэдэг тул энэ дансаар дамжуулан газар эзэмших харилцаа, тариалах талбай болон тариачин өрхийн орлого зэргийг таамаглаж болдог байжээ. Тариан талбай, тутаргын талбайг хэмжиж, эзэмших харилцааг нь нягтлан, түүндээ үндэслэн алба татварын үндсэн эх материалыг бий болгохын тулд газрын тооллого явуулдаг байсан ажээ. “Газрын данс (양안)”-ыг цагаан хулгана жилийн газрын данс, Кванмү-гийн газрын данс хэмээн ангилдаг агаад цагаан хулгана жилийн газрын данс нь Сүгжон вангийн 45, 46-р он (1719-1720)-д өмнө зүгийн гурван бүс нутаг буюу Кйөнсандо (경상도), Чөлладо (전라도), Чхүнчхондо (춘천도)-гийн нутагт явуулсан газрын тооллогын үр дүн бөгөөд Кванмү-гийн газрын данс нь 1898-1904 оны хооронд Японы эзэрхийлэгчдийн явуулсан газар байцаан тогтоох ажлаас өмнө Чосөн-ий засгийн газраас явуулсан хамгийн сүүлчийн газрын тооллого ажээ.

양요, 洋擾, **Барууны самуун** гэдэг нь Чосөн-ий сүүл үеэр европ хүмүүсийн гаргасан үймээн ажээ. Чосөн улсын Кожоны 3-р /1866/ онд хааны эцэг Хынсөнъ католик шашинтнуудад шахалт үзүүлэхэд Францын цэргийн усан онгоц Канхва арлын нутаг дэвсгэрт нэвтрэн орж ирсэн улаан бар жилийн барууны самуун бөгөөд, Кожон (고종)-ы 8-р /1871/ онд хүчээр гадаад харилцаа тогтоохын тулд Америкийн цэргийн усан онгоцыг мөн л Канхва арал руу шахсан цагагчин хонь жилийн барууны самуун гэх мэтийг ийнхүү нэрлэдэг ажээ. →양란(洋亂)

양전, 量田, **газрын тооллого** гэдэг нь улсын санхүүгийн үндсийг бүрдүүлдэг тариан талбайн татварыг хураахын тулд нийт улсын газрыг хэдэн “кйөлбү (결부)” болохыг хэмжиж, бүртгэгдээгүй хоцорсон газаргүй болгох, ургацын хэмжээнээс хамааран газрын хэмжээг тэмдэглэдэг Солонгосын уламжлалт

“кйөлбүжэ тогтолцоо (결부제)-ургацын болон газрын хэмжээ аль алийг нь харгалзан тоолох тогтолцоо”-ны дагуу татварыг зүй зохистойгоор хураах зорилготой байжээ. Чосөн-ий үед газрын тооллогыг 20 жил тутам явуулдаг зарчимтай байжээ. Хар луу жилийн Японы самууны дараа Сөн-жог-гийн 36,37-р онд анх удаа нийт улсын хэмжээний газрын тооллого явуулсан агаад түүнээс хойш ихэвчлэн орон нутгийн засаг захиргааны хуваарийн хүрээнд явагдах болжээ. Нийт улсыг хамарсан хамгийн сүүлчийн газрын тооллого нь Кожон вангийн хаанчлалын үе буюу 1898-1904 оны хооронд явагдсан ажээ.

양천교혼, 良賤交婚, “сайн хүн (양인)”, “доорд хүн (천인)” хоорондоо гэрлэх – Сайн хүн хийгээд доорд хүн хоорондоо гэрлэх нь гарал угсааны ялгааг давж гарсан гэрлэлт бөгөөд, тэднээс төрсөн хүүхэд ямар гарал угсаанд багтах вэ гэдэг асуудлаар Чосөн-ий эхэн үеэс эхлэн байнга маргаан дэгдэж иржээ. “Сайн хүн”, “доорд хүн” хоорондоо гэрлэснээр төрсөн хүүхэд нь “нэг нь л доорд хүн бол нийтдээ доорд хүн (일천즉천)” гэсэн зарчмын дагуу “доорд хүн”-ий тоог нэмэгдүүлжээ. Эцэг эх нь хоёулаа “доорд хүн” байсан тохиолдолд эхийнх нь эзэн тэрхүү хүүхдийг эзэмших “эхийнхээ удмыг дагах хууль (천자수모법)” үйлчилдэг байжээ. Улсаас татвар төлж, улсын алба хүлээдэг “сайн хүн”-ийг ихэсгэхийн тулд “сайн хүн”, “доорд хүн” хоорондоо гэрлэхийг хориглосон боловч, үүнийг бараг биелүүлдэггүй байжээ. Үүний улмаас “сайн хүн”, “доорд хүн” хоорондоо гэрлэх явдал нь нэлээд их хувийг эзлэх болсон агаад энэ нь боолын эзэн янбань түшмэдийн зүгээс боолоо өсгөхийн тулд “сайн хүн”, “доорд хүн” хоорондоо гэрлэхийг өөгшүүлж байсны үр дүн гэж үздэг ажээ.

양천제 良賤制: янчон тогтолцоо нь улсынхаа бүх иргэдийг жирийн ард иргэд, харц ард гэж хуваадаг Зүүн Азийн нийгмийн гарлаар ангилдаг тогтолцоо бөгөөд, Солонгосын Чосөн улсын үед жирийн ард иргэдээс зөвхөн албан тушаалд томилогдох боломжтой байжээ.

언관, 言官, **хааны мэргэн түшмэл** – Чосонь-ий үед хааны хэлсэн үгийн зөв бурууг тунгаан шүүж, засч залруулах үүрэг гүйцэтгэгч түшмэл бөгөөд, Сагань хааны зөвлөл, Төрийн хяналтын газрын түшмэдийг нэрлэсэн үг ажээ. →**간관**(諫官)

역과, 譯科, **орчуулагч түшмэдийн шалгалт** гэдэг нь Чосонь-ий мэргэжлийн албан хаагчдын шалгалтуудаас хэлмэрч шалгаруулах шалгалт бөгөөд, Хятад судлал, монгол судлал, япон судлал, зөрчин судлал гэсэн дөрвөн хэсгээс бүрдэж байжээ.

역관, 譯官, орчуулагч – Орчуулагч хэлмэрчийн ажил үүрэг гүйцэтгэгч.

역마제, 役馬制, **өртөөний тогтолцоо** – Чосонь-ий үеийн цэргийн тогтолцооны нэг бөгөөд бүс нутаг хоорондын мэдээг түргэн шуурхай дэмжуулахын тулд ийнхүү өртөөний тогтолцоог бий болгон цэргийн хорооноос удирдаж байжээ.

열하일기, 熱河日記, “**Йөрха аян замын тэмдэглэл**” гэдэг нь Чосонь-ий үеийн 1780 онд Йонь-ам-ын Паг Жи вонь Хятадын Чин улсаас ирсэн элчийг даган Йөрхад аялж ирсэн тухай тэмдэглэл ажээ. Энэ нь 26 боть 10 ном бүхий зохиол юм.

영의정, 領議政, Yeonguijeong, Chief State Councillor: **Тэргүүн сайд** бол Чосонь улсын засгийн газрын хамгийн дээд албан тушаалтан бөгөөд одоогийн ерөнхий сайд гэсэн үг ажээ. Улсын их хурлын дарга, дээд шүүхийн дарга болох тухайн үеийн баруун, зүүн хувийн сайдын яамтай хамт гурвалсан удирдлагатай байсан бөгөөд Гурван хувийн сайдын яам **삼의정**(三議政), Гурван толгой **삼정승**(三政丞), Гурван бурхан **삼상신**(三相臣) гэж нэрлэдэг байжээ. Мөн Йонсан **영상**(領相), Сүсан **수상**(首相), Сансан **상상**(上相), Сүгюү **상상**(上相), Вүонбо **상상**(上相) гэж ч нэрлэдэг байжээ. Чосонь улсын үед вангийн удмын биш хүмүүсээс хамгийн өндөр албан тушаалтан байжээ.

영의정, 領議政, **тэргүүн сайд** – Чосонь-ий үед Ыйжөнбү хувь нийлүүлэх газрын тэргүүн хэргэм зэрэг. →**상**(上相), **수궐**(首揆), **영궐**(領揆), **영합**(領閣), **원보**(元輔)

예송논쟁, 禮訟論爭, **Ёс журмын маргаан** гэдэг нь ёс журамтай холбоотой маргааны улмаас Чосөнъ-ий Хйёнъжон вангийн үед ордны ёс журмын асуудалтай тал, ялангуяа хааныг сонгох хугацааны талаар өмнөдийхөн болон барууныхны урсгалын хооронд хоёр ч удаа гарсан том маргаан ажээ.

오가작통법, 五家作統法, **таван өрхийн харилцан хянах тогтолцоо** гэдэг нь Чосөнъ-ий үед ард иргэдийг оргон зайлахаас хамгаалахын тулд хэрэгжүүлсэн тогтолцоог нэрийддэг байжээ. 5 өрхийг 1 баг болгон харилцан бие биенээ харж хянаж байхаар зохицуулсан бөгөөд хэн нэгэн оргон зайлсан тохиолдолд улсад төлөх татвар болон цэргийн алба хаших иргэдийн тоо цөөрснөөр санхүү болон батлан хамгаалах тал дээр асуудал гардаг байжээ. Улс орны эдийн засаг, батлан хамгаалах чадварыг чангатгахад чиглэсэн тус тогтолцоог угийн болон пайзын тогтолцоотой зэрэг хэрэгжүүлж байжээ. →오가작통(五家作統)

오군영, 五軍營, **Таван цэргийн хуаран** гэдэг нь Чосөнъ-ий үед хар луу жилийн Японы довтолгооноос хойш шинээр томилон тогтоосон цэргийн таван хуаран ажээ. →오영(五營), 오영문(五營門), 오군문(五軍門)

오희문, 吳希文, **О Хый мүнъ** (1539-1613) бол Чосөнъ-ий дунд үеийн эрдэмтэн бөгөөд нийслэлийн янбанъ бөлгөө. Түүний бичиж үлдээсэн хар луу жилийн самууны үеийн тэмдэглэл болох “Суэмирог (쇄미록)” нь 16-р зууны сүүлийн хагасын доод давхаргын янбанъ-ы амьдралыг харж болохуйц гарын арван хуруунд багтах цөөхөн эх сурвалжийн нэг ажээ.

왕토사상, 王土思想, **Вангийн газар хэмээх үзэл санаа** нь “Тэнгэрийн доор вангийн газраас өөр газар үгүй бөгөөд газрын хязгаар хүртэл “вангийн иргэд”-ээс өөр хүмүүс үгүй” хэмээх үгээс гаралтай ажээ. “Вангийн эрх мэдэл”-ийг бэлгэдлээ болгосон хэмжээлшгүй эрхт засаглал бүхий улсад вангийн эрх мэдэл хүрч буй нийт газар нутгийн үйлдвэрлэлийн хэрэгсэл, ард түмэн цөмөөрөө ван эзний эзэмшил хэмээн тогтоосон байдаг ажээ. Чосөнъ улс нь хэмжээлшгүй эрхт засаглалтай улс (전제국가)-ын ийм зарчмыг дахин тодруулснаар байгуулагдсан агаад Чосөнъ-ий бүхий л үеийн турш энэхүү улс төрийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх гэж хичээсээр байжээ. Түшмэлийн бүгийн онцгой эрхийг үгүй болгосноор вагийн эрх мэдэл ард түмэнд шууд хүрдэг захирах

систем нь вангийн журамт засаглал эрдмээр засах (덕치) хийгээд ард иргэдийг аюул зовлонгоос аварч туслах явдлыг туйлын зорилго болгож байжээ. Чосөнъ улс мөхөх хүртэл “вангийн газар хэмээх үзэл санаа” бүрэн биелэлээ олоогүй боловч, шинэ үеийн иргэний улс бүрэлдэн бий болохын өмнөх шатанд хамгийн их төвлөрсөн засаглалын шинжтэй захирах хэлбэрийг агуулж байсан ажээ.

왜양일체론, 倭洋一體論, **Япон Өрнөд хоёрын нэгэн биеийн үзэл** гэдэг бол Япон улс нь Өрнөдөөс ялгаагүй тул харилцаа тогтоож болохгүй гэсэн үзэл юм. Чосөнъ-ий сүүл үед гадаадтай харилцаа тогтоохыг эсэргүүцэн гаргасан үзэл ажээ.

외정, 外情, **Войжөн буюу бусадтай нөхцөх** гэдэг нь Чосөнъ-ий үеийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн харилцаанд эр нөхөр нь “авааль эхнэрээсээ өөр эмэгтэйтэй нөхцөх”-ийг хэлдэг байжээ. Энэ нэр томъёо нь И Мүнъгөнъ (이문건)-ий “Мүгжэ-гийн өдрийн тэмдэглэл (목재일기)”-д Ким овогт эр нөхрөө хэдэн өдөр дараалан дууч эмтэй хамт архи уусанд нөхөртөө хандаж “Та войжөн-гүй байсан бол би юунд хардах билээ” гэж нөхөртэйгөө хэрэлдэх үед гардаг нэр томъёо бөгөөд, энэ нь Чосөнъ-ий үеийн янбанъ эрэгтэйчүүдийн бэлгийн харилцаанд донтож байсныг илэрхийлэхэд тохиромжтой үг гэж үздэг байжээ.

용비어천가, 龍飛御天歌, “**Тэнгэрт халин нисэх лууны дуун**” гэдэг нь Чосөнъ-ий үеийн 1445 онд Чөн Инъжи, Анъжи, Квөнъжэ нар хааны зарлигийн дагуу бичсэн 10 боть 5 ном 125 бүлэг бүхий магтаалын яруу найргийн ном ажээ. Солонгос үсгээр бичсэн хамгийн анхны бүтээл бөгөөд, энэ номонд Чосөнъ улсын төр бүрэлдэн тогтсон үйл явцыг Хятадын эртний түүхт үйл явдлуудтай харьцуулан магтан дуулжээ.

운양호사건, 雲揚號事件, **Үнь-йан усан онгоцны хэрэг** бол Чосөнъ-ий 1875 онд Японы цэргийн усан онгоц Үнь-йан нь Канхва-гийн хоолой руу хууль бусаар нэвтрэн орсноор гарсан мөргөлдөөнийг нэрийддэг ажээ. Тус усан онгоцны нэрийг японоор ‘Unyo’ гэж дууддаг ажээ. →운요호 사건(Unyo[雲揚]號事件)

위안부, 慰安婦, **тайтгаруулагч бүсгүй**: 1944 оны 9 дүгээр сард “Эмэгтэйчүүд сайн

дураар хөдөлмөрлөх захирамж” гэх хачин зүйл гаргаж, охид бүсгүйчүүдийн “Сайн дурын хороо (정신대)” гэгчийг байгуулж, 12-оос 40 хүртэлх насны хань ижилгүй 200 гаруй мянган бүсгүйчүүдийг дайчлан бүрдүүлж, фронт дээрх цэргүүдийг “тайтгаруулах” үүрэг гүйцэтгүүлж байжээ. Тэдний нэг хэсэг нь Японд болон дотооддоо цэргийн үйлдвэрт ажиллаж байсан боловч ихэнхийг нь “тайтгаруулагч бүсгүй (위안부)” гэдэг нэрээр Хятад, Зүүн өмнөд Азийн фронт руу илгээж байжээ. Тэдгээр бүсгүйчүүд насан туршдаа эрэмдэг зэрэмдэг болж, хэвийн амьдарч аж төрөх боломжгүй болжээ.

위정척사, 衛正斥邪, Зөвийг сахиж хорон мууг эсэргүүцэх хөдөлгөөн бол Чосөн-ий сүүл үед гадны хүч, соёл орж ирэхэд үүний эсрэг хүнзийн уламжлалыг сахих шаардлага тавин гарсан нийгмийн хөдөлгөөн ажээ.

위정척사사상, 衛正斥邪思想, Зөвийг хамгаалж бурууг зайлуулах үзэл -ийг "Гэгээрүүлэх хөдөлгөөн"-ийг тэр чигээр нь буруутгаж эсэргүүцэн босч ирсэн хүнзийн сурталтнууд "Зөвийг хамгаалж бурууг зайлуулах үзэл" санаан дор хөдөлгөөн өрнүүлжээ. Энэ нь хүнзийн суртлын шинэ урсгалаас урган гарсан, хүнзийн суртлаас бусад үзэл суртал, уламжлалт бус гадны соёлыг үгүйсгэдэг үзэл юм.

유신체제, 維新體制, Юшинь тогтолцоо: Юшинь гэдэг нь хуучин тогтолцоог халж, шинэчилж өөрчлөнө гэсэн утгатай үг. Паг Жөн хый ерөнхийлөгчийн дарангуйллын тогтолцоог нэрлэх нэр томъёо болон тогтжээ. Умард Солонгостой харилцах харилцаанд аятай нааштай өөрчлөлт гарч, ард түмэнд итгэл найдвар төрж байхад 10-р сарын 17-ны өдөр ерөнхийлөгч онцгой байдал зарлан парламентыг тараагаад засгийн газрын тустай хурал хуралдуулан "Юшинь" хэмээн нэрлэсэн Үндсэн хуулийг тунхаглаж, тэр жилийнхээ 11-р сард бүх ард түмний санал асуулга явуулж баталгаажуулжээ. Мөн 12-р сарын 15-нд шинэ Үндсэн хуулийн дагуу “Үндэсний нэгдлийн иргэний хурал (통일주체국민회의)” буюу өөрөөр хэлбэл иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль явуулсан бөгөөл залгаад 12-р сарын 23-ны өдөр Чанцүн спортын ордонд болсон иргэдийн төлөөлөгчдийн хурлаас Паг Жөн хый-г 8 дах ерөнхийлөгчөөр сонгожээ. Юшинь үндсэн хуулиар “Үндэсний нэгдлийн

иргэний хурал” хэмээх төрийн дээд байгууллагыг шинээр байгуулж, түүнээс ерөнхийлөгчийг дам сонгохоор тогтоож, ерөнхийлөгчөөр нэг хүнийг дахин сонгохгүй байх хоригийг цуцлаад иргэний хурал, шүүхийг захирах өргөн эрх мэдлийг ерөнхийлөгчийн гарт зангидаж өгчээ. Үндэсний нэгдлийн иргэний хурлын гишүүнээр 2,395 хүн сонгосон бөгөөд энэ хурал ерөнхийлөгчийг сонгох үүрэгтэй гэж байсан ч ерөнхийлөгч өөрөө хурлын дарга болсон тул ерөнхийлөгчийн шууд захиргаанд байснаас ялгаагүй байжээ. Мөн Юшинь үндсэн хуулийн дагуу ерөнхийлөгч Үндэсний нэгдлийн иргэний хурлын гишүүдийн гуравны нэгийг шууд сонгох, шүүх прокурорын боловсон хүчний эрх, онцгой арга хэмжээ авах, иргэний хурлыг тараах зэрэг асар их эрх мэдэлтэй болжээ. Юшинь засаглал тогтмогц Умард Солонгос 1973 оны 8-р сард Өмнөд Умард Солонгосын яриа хэлцлийг зогсоосноо зарлаж, хоёр улсын харилцаа дахин хүйтэрчээ.

유신헌법, 維新憲法, Юшинь үндсэн хууль бол 1972 оны 10 дугаар сарын онцгой арга хэмжээнд үндэслэн 7 дахь удаа засвар оруулах болж 1972 оны 12 дугаар сарын 27-нд олон түмэнд шинээр зарлан тунхаглан мөрдөх болсон Солонгосын Үндсэн хууль ажээ. Энэ хуулиар ерөнхийлөгчийн байр суурь, эрх мэдлийг чангатган нэмэгдүүлж, Улсын их хурлын эрх мэдэл, байр суурийг бууруулах зэргээр ерөнхийлөгчийн ганцаарчилсан удирдлагатай улс орон болгох суурийг тавьжээ.

유엔한국임시위원단, (UN 韓國臨時委員團 UNCOK), Солонгосын сонгуулийн НҮБ-ийн ажиглагчдын хороо бол НҮБ-ийн 2-р нэгдсэн хурлын шийдвэрийн дагуу Солонгосын 5 дугаар сарын 10-ны өдрийн сонгуулийг шударга ажиглах, хянах зорилготой ирсэн НҮБ-ийн харьяа түр байгууллага юм.

유일, 唯一, Ю-ил - ганц хүнийг тахин шүтэх үзэл – 1960-аад оны эхэн үед Умард Солонгост Ким Ил сөн, Хөдөлмөрийн намын нэр хүндийг өргөхийн тулд Ким Ил сөн-г тахин шүтэх, Ким Ил сөн-ий гэр бүлийнхийг онцгойлон бишрэх үзлийг дэвэргэж, Солонгосын түүхийг дарлагдагч ангийн байр сууринаас ангич үзэлд тохируулан бичүүлсэн бөгөөд, ялангуяа шинэ, нэн шинэ үеийн түүхийг партизаны тэмцлийн түүх болгон зохиолгож байжээ. Түүх судлалын

ухааныг Хөдөлмөрийн нам гартаа атгаж, Ким Ил сөн-ий “Их удирдагчийн заавар” түүхийн судлалд ноёлох болжээ. 1960 -аад оны сүүлээс дэвшүүлсэн чүцэ (주체) үзлийн жанжин шугам нь улс төрийн хувьд тусгаар байх, эдийн засгийн хувьд бие даах, батлан хамгаалахын хувьд өөрийгөө хамгаалах явдал байжээ. 1969 онд Хөдөлмөрийн нам чүцэ (주체) үзлийг ю-ил (유일) буюу ганц хүний тахин шүтэх үзлээр сольжээ. 1970-аад оноос Умард Солонгос эдийн засаг болон Өмнөд Солонгосын тал дээр хатуу байр сууриа зөөлрүүлж алдаатай бодлого явуулсан гэх нэрийдлээр хатуу үзэлтнүүдээ улс төрийн цэвэрлэгээ хийн зайлуулж, хувьсгалын хоёрдугаар үеийнхнийг дэвшүүлэн гаргасан бөгөөд, энэ үед Ким Жөн ил (김정일) тэргүүтэй Ким Ил сөн-ий ойр тойрны хүмүүс төрийн гол албан тушаалуудыг эзлэжээ. Ингээд Ким Ил сөн-ий эрх мэдлийг хязгааргүй ихэсгэх зорилгоор 1972 оны 12 дугаар сард “Иргэний ардчилсан үндсэн хууль”-ийг өөрчилж, “Социалист үндсэн хууль”-ийг тунхагласнаар төрийн бүх эрхийг Ким Ил сөн-ий гарт зангидаж өгчээ. Тухайлбал, засгийн газрын тэргүүний албан тушаалыг улсын даргаар сольж, улсын даргын шууд захиргаан дах “Иргэний Төв Зөвлөл (중앙인민위원회)”-д гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх засаглалын бүх эрхийг олгосон ажээ.

유향소, 留郷所, **Йүхянсо** нь Чосөнъ улсын үеийн орон нутгийн удирдагчдад тусалдаг зөвлөх байгууллага юм. Чосөнъ улсын үед орон нутгийн засаг захиргааны нэгжийг шинээр байгуулж, тухайн газар орны хэмжээ, ач холбогдлоос шалтгаалж пү (부), мог (목), күнь (군), хйөнъ (현) гэсэн нэгжид хувааж байсан бөгөөд, бүх күнь, хйөнъ-д тухайн газар амьдарч буй янбаньчуудаас бүрдсэн Йүхянсо хэмээх нутгийн зөвлөх байгууллага хүрч үйлчилдэг байжээ. Энэ нь төвөөс томилогдсон захирагчид туслах, эрх мэдлийг нь хязгаарлан тосгоны аж амьдрал, нийгмийг зохицуулах үүрэгтэй байжээ.

유희춘, 柳希春, **Йү Хыйчхүнъ** (1513-1577) бол Чосөнъ-ий дунд үеийн бичгийн түшмэл бөгөөд, сарим бүлэгт багтдаг алдарт түшмэл Чхой Бо (최보) -гийн зээ хүү, Ким Анъгүг (김안국)-ийн шавь ажээ. Бичгийн түшмэлийн шалгалтаар дамжин түшмэлийн албан тушаалд орсон боловч, “Хөхөгчин могой жилийн улс төрийн цэвэрлэгээ (을사사화)”-д холбогдож, 20 гаруй жил цөллөгт байжээ.

Сөнъжо ван сууринд сууснаар дахин албан тушаалд орж, вангийн илтгэлийг хүлээн, 10-аад жил төв болон орон нутгийн өндөр албан тушаал хашжээ. Түүний бичиж үлдээсэн “Миам-ын өдрийн тэмдэглэл (미암일기)” нь аж амьдралын түүхийн судалгааны гол эх сурвалж ажээ.

육영, 育英, Юүг-йөн нэртэй хүрээлэнг Кожон-ы 23-р (1889) онд тусгайлан байгуулж, өрнөдийн маягын боловсролын тогтолцоог бий болгохоор төлөвлөн, улмаар шинэ цагийн бага, дунд сургууль, багшийн сургууль, гадаад хэлний сургууль зэрэг олон улсын сургууль бий болжээ. Тухайн үед албан хаагч, түшмэд, өндөр албан тушаалтны үр хүүхдүүдэд шинэ цагийн боловсрол олгохоор “Юүг-йөн конвөнъ (육영공원)” гэдэг нэртэй хүрээлэндээ гадаад багш нарыг урьж багшлуулан, тоо, байгалийн ухаан, түүх, улс төрийн ухаан заалгаж байжээ. Улмаар Кожон-ы 32-р (1895) онд боловсролыг дээдэлсэн улс болох вангийн жуу бичиг гарч, түүнд улс орон хүчирхэг баян байх үндэс нь ард түмний гэгээрэл боловсрол мөн гэж онцгойлон чухалчилж байжээ.

육의전, 六矣廛, Зургаан худалдааны төв гэдэг нь Чосөн-ий үед Сөүл хотын Чонро-гийн гудамжинд олон нийтийн эрх ашгийн төлөө худалдааны онцгой эрх эдлэн Сижөнъ худалдааны төвийн үйл ажиллагаа явуулах зургаан захыг нэрлэдэг бөгөөд далайн бүтээгдэхүүн, цаас, бөс даавуу зардаг байжээ. →육주비전(六注比廛)

을미사변, 乙未事變, Хөхөгчин хонь жилийн хэрэг бол Чосөн-ий үеийн 1895 онд Японы нууц алуурчид Кйёнбог ордонд нэвтрэн Кожон вангийн хатан Мйёнсөн хатныг алсан хэрэг ажээ.

을사조약, 乙巳條約, Хөхөгчин могой жилийн гэрээ: Гэрэлт зэвсэгийн 9-р (1905) оны 11-р сард энэхүү гэрээг үйлджээ. Гэрээний агуулга нь нэгдүгээрт Японы гадаад хэргийн яам Хань улсын гадаад улстай харилцах алив хэргийг удирдан захирч хянах, хоёрдугаарт үүнээс хойш Хань улсын засгийн газар, Японы засгийн газарт мэдэгдэхгүйгээр аливаа олон улсын чанартай гэрээ, хэлцэл, тохиролцол үйлдэхгүй байх, гуравдугаарт Япон нь Хань улсын гадаад харилцааг хянахын тулд эзэн хааны хажууд Японы төлөөний сайд (통감)

суулгах зэрэг байжээ. Нэг ёсондоо Хань улсын гадаад харилцааны эрхийг бүрэн үгүй хийх зорилго агуулсан гэрээ байжээ.

음서, 陰敍, **Ымсө тогтолцоо** бол эцэг өвгөдийн гавьяагаар албан тушаалд дэвшдэг тогтолцоо бөгөөд, энэ нь өндөр албан тушаалтай түшмэдийн хүүхэд орогсдын шалгалт (과거) өгөлгүйгээр төрийн албан хаагч болж алба хаших боломжтой тогтолцоо юм. Төрийн алба хашсанаар цэргийн алба, биеэр гүйцэтгэх албанаас чөлөөлөгддөг байжээ. Чосөн-ий үеэс ымсө (음서) болон нэр дэвшүүлэх (천거) аргаар төрийн албанд орох явдал багассан бөгөөд, орогсдын шалгалтанд өндөр оноо авч байж өндөр албан тушаалд сууж, зэрэг дэвшдэг болжээ.

음양과, 陰陽科, **арга билгийн түшмэдийн шалгалт** бол Чосөн-ий үеийн мэргэжлийн албан хаагчдын шалгалтын нэг бөгөөд, энэ шалгалтыг одон орон, газар зүй, зурхай гэсэн гурван хэсэгт хуваан авдаг байжээ.

음양오행설, 陰陽五行說, **Арга билиг, таван махбодын онол** гэдэг нь сансар огторгуй, хүний нийгмийн үзэгдлийг арга билиг, таван махбодод тулгуурлан тайлбарлах онол юм. →오행설(五行說)

의방유취, 醫方類聚, “**Анагаах аргын төрөлжсөн түүвэр**” гэдэг нь Чосөн-ий Сэжон вангийн үед Ким Сүн-и, Но Жүн нйэ нарын хамтран бичиж гаргасан эмнэлгийн нэвтэрхий толь ажээ. Энэ толийг 1445 онд бичиж дуусгасан ба бүгд 266 боть ном болжээ.

의정부, 議政府, State Council of Joseon, Uijeongbu: **Ыйжонбү** -хувийн сайдын яам нь Чосөн улсын хуулийн хамгийн дээд байгууллага юм. Корё улсын үед байсан хамтын байгууллага Дупёнысаса (도평의사사) болон гүйцэтгэх байгууллага Сансосон (상서성) хоёрыг нэгтгэн байгуулжээ. Хувийн сайдын яам нь 3 толгой байгууллагатай, өөрөөр хэлбэл баруун, зүүн, төв гэсэн нэгдмэл байгууллагатай байжээ. 3 толгой байгууллага нь улсын гол бодлогыг хэлэлцэж, санал нэгдэсний дараа вандаа өргөн барьдаг байжээ. Вангийн шийдвэр ч мөн адил хувийн сайдын яамаар дамжин тухайн тамгын газарт

хүргэгддэг байжээ. Хувийн сайдын яам нь 6 яамны тогтолцоотой болсон үед ванд зөвлөгөө өгөх байгууллагын үүрэг гүйцэтгэж байсан ба, хувийн сайдын яамны Соса тогтолцоо (서사제)-гоор төрийн байгууллагын гол үүрэг гүйцэтгэдэг байжээ. Хувийн сайдын яамны 3 хүний эрх мэдэл, ажил үүрэг эн тэнцүү байсан бөгөөд эцсийн шийдвэрийг бүх гишүүдийн саналд үндэслэн гаргадаг байжээ. Гэхдээ хувийн сайдын яамны төрийн бодлогыг шийдвэрлэх явц нь тухайн жилийн бүх хувийн сайдын яамдын дээд тушаалтнуудын оролцоотойгоор явагддаг байжээ. Хувийн сайдын яамдын дээд тушаалтнуудыг сонгохдоо дээд зиндааны захирагчдаас төрийн хэрэг шийдэхэд оролцох ёстой хүн гэж хүлээн зөвшөөрөгдсөн чухал албан тушаалтай хүмүүсийг давхар ажил эрхлэх эрх олгож томилдог байжээ. Иймд тэдгээр албан тушаалтнууд төрийн ажил шийдвэрлэхдээ өөрсдийн үндсэн ажлаа явуулдаг арга барил, шаардлага, туршлага дээрээ үндэслэн харилцан зөвшилцөх болдог. Энд гарч байгаа 6 яамдын дээд түшмэлийг бүрдүүлэхдээ мэдээж вангийн ойр ажилладаг шадар туслах болон түшмэдийн доор ажилладаг цэргийн түшмэл, заримдаа орон нутгийн захирагч гэх мэт 40-50 орчим хүн оролцуулж бүрдүүлдэг байжээ. Ингэж бүрдүүлдэг байсан шалтгаан нь төрийн дээд байгууллагын ажил үүрэг явуулахад дээд, доод тушаалтан хоорондын дэг журамтай үл хамааран тухайн төрийн ажлыг явуулахад ямар үүрэг, хариуцлагатайгаар оролцохоос хамаарч хэнийг ч томилох боломжтой байжээ. Мөн сайд түшмэл болон сайд асангуудыг ч цөөнгүй оролцуулдаг байсан гэдэг. Ингэж хувийн сайдын яамын дээд албан тушаалтнууд хангалт нийлүүлэлтийн гарцыг хөгжүүлэх, ажил үүрэгт чиглэсэн ажлыг зохион байгуулах, сайдаар ажиллаж байсан хүмүүсийг оролцуулах зэрэг хамтын ажиллагааг гол зарчмаа болгодог байсан бөгөөд, Чосөн улсын вангийн төрийн дээд тушаалтнуудын тогтолцооны онцлог нь ажил үүргийн шинэчлэлийг харуулж байжээ. Хувийн сайдын яам нь гадны дайралт болон дотоодын сөргөлдөөн, буудалцааны үед Пибйён бат хамгаалах хуралдайг (비변사) зарлаж яамны үндсэн чиг үүргээ алдах үе ч байсан, түр хугацаанд үндсэн үүргээ буцааж сэргээж ажиллах ч үе байсан бөгөөд иймэрхүү байдалтай Модон хөх морин жил (갑오경장) -ийн шинэчлэлт хүртэл

үргэлжилж байжээ.

이문건, 李文健, И Мунъ гонъ (1494-1567) бол Чосонь-ий эхэн үеийн бичгийн түшмэл бөгөөд нийслэлд суурилсан сарим бүлгийн түшмэл ажээ. Бичгийн түшмэлийн шалгалтаар дамжин түшмэлийн албан тушаалд дэвшиж, Түшмэлийн явдлын яамны чваран (이조좌랑), Сынжонвонь-ий пүсынжи (승정원 부승지) зэрэг алба хашиж байжээ. Үеэл болох И Хүй (이휘) нь “Хөхөгчин могой жилийн улс төрийн цэвэрлэгээ”-нд холбогдсон тул түүний хоморгонд орж Кйонсандо (경상도) -ийн Сөнъжү (선주)-д цөлөгдсөн бөгөөд, 20 гаруй жил цөллөгт байж байгаад суллагдаж чадалгүй тэндээ нас баржээ. Түүний бичиж үлдээсэн “Мүгжэ-гийн өдрийн тэмдэглэл (목재일기)” нь 16-р зууны тэргүүн хагасын түүхийг сэргээн авч үзэх гол эх сурвалж болж хэрэглэгдэж байгаа ажээ.

이순신, 李純信, И Сүнъшинъ – Чосонъ улсын Сөнъжо (선조) вангийн үеийн нэрт жанжин ажээ. Тэрбээр Хар луу жилийн Японы самуун (임진왜란) болон Улаагчин тахиа жилийн самуун (정유재란) зэрэг Чосонъ улс руу халдсан Япон улсын эзлэн түрэмгийлэх дайнд гавъяа байгуулсан цэргийн хүн ажээ. Чосонъ улс Японы дайралтад бэлтгэхийн тулд нэр нь дуурсагдсан жанждыг сонгон, дайнд бэлдэж байсан бөгөөд, И Сүнъшинъ жанжин тэдний нэг байжээ. Чосонъ улсын баруун өмнөд хэсгийн далайн бүсийн усан цэргийн захирагч болсон И Сүнъшинъ нь “яст мэлхий усан онгоц көбүксөнъ (거북선)” хэмээх хуягласан усан онгоц, түүнчлэн дааган буугаар зэвсэглэсэн олон байлдааны хөлөг онгоц бүтээж, цэргүүдийг элсүүлэн тууштайгаар дайнд бэлджэ байжээ. Дайны эхний үед Чосонъ улсын цэргүүд дайны туршлагатайн дээр шинэ зэвсгээр зэвсэглэсэн Японы цэргүүдэд дараалан ялагдсаар байсан боловч далайд И Сүнъшинъ жанжин Японы далайн цэргүүдийг дараалан бут ниргэсээр Япон цэргийн давшилтыг зогсоож, дайны байдлыг өөрчилж байжээ. 7 жилийн дайнд И Сүнъшинъ олон арван удаа Японы усан цэрэгтэй тулгарч, нэг ч удаа ялагдаагүй бөгөөд сүүлчийн далайн тулалдаанд ухарч явсан Япон цэргүүдийг хөөж байгаад дайсны суманд оногдон эрэлхэгээр амиа алджээ. И Сүнъшинъ нь дайны бэлтгэл болон шилдэг арга барилаар ялалт руу хөтлөх мэргэн ухаан,

шулуун шударга, даруу төлөв зан, улс ард түмнээ хайрлах сэтгэл, амиа золиослон улсаа аварсан баатар хэмээн өнөөг хүртэл Солонгосчуудын хүндэтгэлийг хүлээсэн жанжин ажээ.

이승만, 李承晩, Syngman Rhee, **И Сын-Мань** (1875.3.26.~1965 7.19) бол БНСУ-ын

Түр засгийн газрын анхны ерөнхийлөгч, мөн сүүлчийн тэргүүн бөгөөд БНСУ-ын 1, 2, 3 дахь ерөнхийлөгчөөр ажиллаж байжээ. 1949 онд улс байгуулсан үндэсний гавьяаны одон болох БНСУ-ын гавьяаны одонгоор шагнагджээ. Чөнжү (전주) нутгаас гаралтай, нэр нь Ү нам (우남). Тэрээр 12 жилийн турш БНСУ-ын ерөнхийлөгчийн албыг хашсан бөгөөд, энэ нь Пак Жөн хый-гийн дараа орох хамгийн урт хугацаа гэж хэлж болно. Хуанхэ мужийн Пйёнсань гэдэг газар Йаннийөн тайгүнь-ийн 16-р үеийн удам болж төржээ. Их Хань эзэнт гүрний үед тэрээр “Тусгаар тогтнолын сонин” (독립신문), “Өдрийн сонин (협성회회보)” -ыг эрхлэн гаргах, Тусгаар тогтнолын нийгэмлэгт ажиллах зэрэг соён гэгээрүүлэх хөдөлгөөнийг удирдаж байсан бөгөөд, хаант засаглалыг халж бүгд найрамдах улс байгуулах гэж оролдсон, урвасан гэх хэргээр Ханьсөн-ийн шоронд хоригдож байжээ. Тэрээр шоронд байх хугацаандаа христийн шашинд итгэн шоронд соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулж, улмаар “Тусгаар тогтнох оюун санаа” зохиолоо бичиж байжээ. Их Хань эзэнт улсын сүүл үеэр онцгой өршөөлөөр суллагдсанахаа дараа нууц элчээр Америкт ирсэн ч төдийлөн үр дүнд хүрээгүй бөгөөд, тэндээ үргэлжлүүлэн суралцаж 5 гаруй жилийн хугацаанд Жорж Вашингтоны их сургуульд бакалавр, Харвардын их сургуульд магистр, Принстоны их сургуульд докторын зэрэг хамгаалжээ. 1912 онд Америк руу дүрвэж, Хавайд солонгос хүмүүст зориулсан сургалтын төв, улмаар Солонгос сургууль байгуулан ажиллуулж байжээ. 1919 оны 3 дугаар сарын 1-нд болсон коммунизмд шилжих хөдөлгөөний дараа социалист үзэлтнүүд хоорондоо тусгаар тогтнолын хөдөлгөөний талаар санал зөрөлдөж байх үед тэрээр дотоодын нөхцөл байдлынхаа талаар гадаад улс орнуудад мэдээлж, харилцан ойлголцохыг хүсч дипломат тусгаар тогтнолыг эрэлхийлж байжээ. Тэрээр БНСУ-ын Үндэсний Ассамблей, Шанхай дахь Түр засгийн газар, Ханьсөн-ийн засгийн газар зэрэг олон газарт байгуулагдсан түр засгийн газрын

тэргүүнээр ажиллаж байгаад 1919-1925 онд БНСУ-ын Түр засгийн газрын ерөнхийлөгчөөр ажиллаж байжээ. 1919 оноос чөлөөлөгдөх хүртэл Европ Америкийн бүсийн Солонгос дахь комиссын дарга, Америк дахь гадаад хэрэг хариуцсан хорооны дарга, Америк дахь гадаад харилцааны комиссын дэд даргийн албыг тус тус хашиж, дипломат чиг баримжаатай тусгаар тогтнолын хөдөлгөөнийг голчлон Америк улсад явуулж байжээ. Японы колончлолын ид үед тэрээр “Японы дотор талд” хэмээн бичвэр бичиж, Япон АНУ руу довтлох гэж буйг анхааруулж байсан бөгөөд, 1941 онд Номхон далайн дайн эхлэхэд тэрээр Японы эзэнт гүрэн ялагдана гэдэгт итгэлтэй байж, Японы эзэнт гүрэн задран унамагц Солонгос улсынхаа тусгаар тогтнолыг эргүүлэн олж авахын тулд БНСУ-ын Түр засгийн газрыг Олон улсын хамтын нийгэмлэгт албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэхийн тулд дипломат үйл ажиллагаа явуулж байжээ. Мөн “Америкийн дуу хоолой” радио өндөр давтамжийн нэвтрүүлгээр эх орондоо байгаа элэг нэгтнүүдийнхээ тэмцлийг дэмжиж, Түр засгийн газар болон Америкийн цэргийн армийн OSS хоорондын Солонгос, Америк улсын цэргийн хамтын ажиллагааг зохион байгуулжээ. 1945 онд Японоос чөлөөлөгдсөний дараа тэрээр Ким Гү-тэй хамт итгэмжлэлийн эсрэг үндэсний хөдөлгөөн (신탁 통치 반대 운동)-ийг удирдаж байжээ. Түүнчлэн коммунист цэргийн лагерьтай буулт хийх боломжгүй гэж дүгнэж, 38-р өргөрөгийн өмнөд хэсэгт байрлах үндэсний хуаранд төвлөрөн Олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны засгийн газар дангаараа байгуулсны дараа 38-р өргөрөгөөс хойшхи хууль бус засгийн газар, коммунист лагерийг бүгдийг нь хөөн гаргаад Солонгосын хойгийг нэгтгэх оролдлого хийж байжээ. И Сын мань 1948 онд үндсэн хууль тогтоох Үндэсний Ассамблей-ийн даргаар ажиллаж байсан бөгөөд, тэр жилдээ БНСУ-ын анхны ерөнхийлөгчөөр сонгогджээ. Хүйтэн дайны үетэй хөл нийлүүлэн коммунизмын эсрэг, эрх чөлөөт ардчилсан үзэл, зах зээлийн эдийн засгийн тогтолцоотой БНСУ-ын үндэс суурийг тавьсан бөгөөд, 1949 онд Газрын шинэчлэлийн тухай хууль, 1953 онд Солонгос-АНУ-ын харилцан батлан хамгаалах гэрээ байгуулах зэрэг дотоод, гадаад талаас нь Солонгос улсын хөгжлийн үндэс суурийг тавьж байжээ. 1952 онд энх тайвны шугамыг зарлаж, Тогдо (독도) арлыг амь биеэрээ хамгаалж байжээ. Тэрээр 1952 онд ерөнхийлөгчийн шууд сонгуулийн

тогтолцоог хэсэгчлэн өөрчилж, 1954 онд ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа хязгаарлахыг халж, улмаар үндэсний эдийн засгийн заалтыг зах зээлийн эдийн засгийн заалт болгон өөрчилсөн гэх мэт үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн үндсэн дээр гурван удаа ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллажээ. 1960 онд 4 дэх ерөнхийлөгчөөр сонгогдсон хэдий ч 4·19 -ний хувьсгалын хариуцлагыг хүлээж, сайн дураараа огцорсон бөгөөд, Хавай руу дүрвэснийхээ дараа Солонгост буцаж ирж чадалгүй тэндээ нас баржээ. Түүний оршуулах ёслолыг Солонгост хийсэн бөгөөд, улсын өрхийн тэргүүний хувьд Сөүлийн үндэсний оршуулгын газарт оршуулжээ.

이승훈, 李承薰, **И Сын хүнь** (1756-1801) бол Чосөн-ий үеийн эрдэмтэн, католик шашинтан, Солонгост католик шашныг анх оруулж ирсэн хүмүүсийн нэг ажээ.

이이, 李珥, **И-и** (1536~1584) бол Чосөн-ий үеийн цэргийн түшмэл бөгөөд, шинэ хүнзийн суртлыг баримтлагч эрдэмтэн, улс төрч, сэтгэгч, багш, зохиолч, яруу найрагч ажээ. Есөн удаа түшмэл сонгох шалгууранд тэнцэн зэрэг дэвээ ахиулсан ажээ.

일부일처제, 一夫一妻制, **нэг эр нэг эхнэр авах тогтолцоо**: Чосөн-ий улсад “нэг эр нэг эхнэр авах тогтолцоо (일부일처제)”-г албан ёсоор тунхагласан байжээ. Анхны эхнэр нь нас барсны дараа дахин эхнэр авч болох хэдий ч, нэгэн зэрэг хоёр эмэгтэйтэй гэрлэж болдоггүй, харин бас дахин татвар эм авахыг зөвшөөрдөг байжээ. Янбан-ий түшмэл авааль эхнэрээ амьд байхад нь хүртэл “янинь (양인) буюу сайн хүн”-ээс доошхи эмэгтэйчүүдийг татвар эм болгосон жишээ их байдаг ажээ. Татвар эмийг өөрийнх нь гарал угсаанаас хамааран чхөб (첩), сошил (소실), чхыгшил (측실), пүшил (푸실), хүшил (후실) гэх мэтээр нэрлэдэг байжээ. Чосөн-ий түрүү үеийн дээд давхаргынхан нэг л хүнийг авааль эхнэрээ болгож, бусад эхнэрүүдийг татвар эм болгон тогтоогоод, гэр бүл болох тогтолцооны хувьд “нэг эр нэг эхнэр авах тогтолцоо”-г тодорхой болгохыг зорьж байжээ. Энэхүү тогтолцоо нь янбан-ы нийгмийн байр суурийг хадгалах арга байсан агаад, нөгөө талаар гэр бүл болж буй эмэгтэйн эр нөхрийнхөө улам угсааны дотор эзлэх байр суурийг харгалзан үзэж, эмэгтэйнх нь гэр бүлийнхний тулгаж байсан болзол ажээ.

일진회, 進會, Илжинъхой бүлгэм гэдэг нь Сөүл дэх Японы цэргийн захиргааны хэлмэрч Сон Бйөн жүнь (송병준), “Тонхаг” суртлаас тэрсэлсэн И Ён гү (이용구) нар Японоос санхүүгийн дэмжлэг авч, япон зөвлөхийн удирдлагаар байгуулсан бүлгэм юм. Энэ бүлгэм нь япон хүний хүсэл зоригийг төлөөлж байсан бөгөөд, Хань улс Япон улсаар ивээн өмгөөгүүлэх гэрээ байгуулахын ач тусыг ухуулж сурталчилж байжээ. Ингэхдээ Японы албадлагаар бус солонгосчуудын хүслээр болсон мэтээр харуулах гэж хичээж байжээ.

임오군변, 임오군란, 壬午軍亂, Хар морин жилийн цэргийн үймээн гэдэг нь 1882 онд Чөсөн улсын солонгос цэргүүд Японы цэргүүдээс өөр ялгавартай хандаж байгаа байдал болон цалингаа өгөхгүй удааж байгаа зэрэг асуудлаас үүдэн гаргасан үймээнийг хэлдэг ажээ. Цэргийн шинэчлэлтийн үр дүнд шинээр байгуулсан Тусгай цэргийн хороо (별기군) Кожон-ы онцгой ивээлд байсан бол хуучин цэргийн ангиудыг яваандаа татан буулгана гэж үзээд бараг хайхрахаа больжээ. Тэдний цалинг арван гурван сар тавьж өгөөгүй байснаа цалингийн оронд олгосон тутрагыг хүртэл дундаас нь түшмэдүүд шамшиж завхисан тул уурлаж хилэгнэсэн Сөүлийн цэргүүд 1882оны зургадугаар сард бослого гаргажээ. Энэ бослогод Ваншимри, Итайвөнъ (Сөүл хотын хорооллын нэр)-ы ядуучууд нэгдэж, Сөнъхечөн (선계청; тамгын газрын алба татварын хэрэг хариуцдаг тамгын газар)-ий ахлах түшмэл Минъ Гйөм хо (민검호)-гийн орон гэр болоод Японы элчин төлөөлөгчийн газрыг дайрч галдан шатаажээ. Энэ үймээний улмаас Минъ хатан Жанховөнъ руу амь дүрвэн зугатаж, Кожон ван хэрэг явдлыг хариуцлагыг хүлээн Тайвөнъгүнъ-д суудлаа тавьж өгчээ.

임진왜란, 壬辰倭亂, Хар луу жилийн Японы довтолгоон гэдэг нь Япон улс Чөсөн улс руу хоёр удаа довтолсноор дэгдсэн дайн бөгөөд, 1592 -1598 оны хооронд долоон жилийн туршид дайтжээ.

자유당, 自由黨, Эрх чөлөөний нам – 1951 оны 12 дугаар сард Ардын хурал, БНСУ-ын залуучуудын бүлгэм, Ажилчны нэгдсэн холбоо, Тариачны нэгдсэн холбоо, БНСУ-ын эмэгтэйчүүдийн нийгэмлэг зэрэг улсын байгууллагууд дээр үндэслэн эрх баригч И Сын манъ-ы засгийн газар Эрх чөлөөний намыг байгуулжээ. И Сын манъ-ы засгийн газар дайны үеийн түр нийслэл Пүсанъд

байрлаж байхдаа ард түмний дунд коммунизмын эсрэг үзэл хүчтэй болсныг ашиглан дангаар ноёрхох засаглалаа тогтоох олон арга ашиглаж байсны нэг нь Эрх чөлөөний нам байгуулсан явдал ажээ. 1951 оны 7 дугаар сард дайны онцгой байдал зарласан үедээ И Сын мань-ыг сонгуульд дахин ялуулахын тулд Үндсэн хуулинд өөрчлөлт оруулж, ерөнхийлөгчийг шууд сонгох сонгуулийн журмыг батлажээ. Ийм нөхцөл байдалд батлагдсан шинэ үндсэн хуулийн дагуу сонгуулийг явуулж, И Сын мань дахин ерөнхийлөгчөөр сонгогджээ. Тэрбээр эрх мэдлээ аль болох удаан хадгалахын тулд Эрх чөлөөний намын даргаар өөртөө үнэнч зүтгэдэг И Ги бүн (이기붕) -ийг тавьж байжээ. 1960 оны 3 дугаар сарын 15-ны дөрөв дэх удаагийн ерөнхийлөгчийн сонгуулиар Эрх чөлөөний намынхан төрийн албан хаагчид, албан байгууллагуудыг дайчлан урьдчилан 40 хувийн санал бэлэн болгох зэргээр зүйл бүрийн аргыг хэрэглэж байсан бөгөөд, энэ сонгууль бол И Сын мань-ы засгийн газрын хамгийн бусармаг сонгууль байжээ.

자유시참변, 自由市慘變, **Чөлөөт хотын хэрэг** – Японы цэргийн мөрдлөгөөс ангижрахын тулд Тусгаар тогтнолын цэргийн ангиуд Оросын хил дээрх Чөлөөт хот (Алексеев) руу дүрвэн орсон авч, улаантан цагаантнуудын дайны хөлд нэрвэгдэж улам тарж бутарчээ. Үүнийг Чөлөөт хотын хэрэг (1921.6.28) гэж нэрлэдэг ажээ.

잡색군, 雜色軍, **Чабсайг цэргийн анги** гэдэг нь цэрэг татлагаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчаас бусад эрчүүдээс бүрдсэн тусгай бэлтгэгдсэн цэрэг юм. Чосонь улс цэрэг, батлан хамгаалах салбараа бэхжүүлэхэд анхаарч, цэргийн хүчээ бататгахын тулд эгэл ардын тоог нэмж, өрхийн тооллого явуулж байжээ. 16-60 насны энгийн эрчүүд цэргийн алба хаах үүрэгтэй тул цэргийн алба хаах юмуу эсвэл цэргийн зардлыг гаргах үүрэг хүлээдэг байжээ. Боолууд цэргийн алба хаадаггүй байсан ба төрийн албан хаагч, мэргэжлийн тусгай үүрэгтэй хүмүүс цэргээс чөлөөлөгддөг байжээ. Төрөөс цэргийн албанаас чөлөөлөгдсөн хүмүүсийг Чабсайг хэмээх цэргийн ангид элсүүлж, гэнэтийн хэрэгт дайчилдаг байжээ.

전의학감, 典醫監, **Анагаах ухааны хүрээлэн** гэдэг нь Чосөн-ий үед ордонд хэрэглэх эмийн зүйл хариуцаж байсан газар ажээ. 1392 онд байгуулагдаад 1894 онд татан буугджээ. →사의서(司醫署)

정감록, 鄭鑑錄, **Чонгам эш үзүүлсэн бичиг** нь ард түмний дунд өргөн тархсан нууц бөгөөд, “Хүчтэй үймээн самуун дэгдэж, Чосөн улс мөхөж, шинэ хааны угсаа гарч ирэх болно” гэж зөгнөн өгүүлсэн зохиол юм. Чосөн улсын хожуу үед худалдаа наймаа, мөнгө санхүү, эдийн засаг хөгжин шинэ хүнзийн суртал дэлгэрснээр нийгмийн байдал эмх цэгцгүй, тогтворгүй болж анги давхаргын тогтолцоо алдагджээ. Тэр үед ноёлогч давхаргынхан өөрчлөгдөж буй нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй хандаагүй бөгөөд, ард түмний амьдрал өдрөөс өдөрт доройтож, тэдний дунд “Чонгамраг” мэтийн эш үзүүлсэн бичиг дэлгэрчээ.

정미칠조약, 丁未七條約, **Улаагчин хонь жилийн долоон заалт бүхий гэрээ** нь 1907 оны улаагчин хонь жилд байгуулсан долоон заалт бүхий Солонгос-Японы шинэ гэрээ ажээ. →한일신협약(韓日新協約)

정약용, 丁若鏞, **Чон Йаг йон** (1762~1836) нь Чосөн улсын хожуу үеийн эрдэмтэн бөгөөд, тэрээр төрийн байгууламжийн бүх талын шинэчлэлт, орон нутгийн засаг захиргааны шинэчлэлт, тариачдын эрх тэгш газар өмчлөх эрх, ажиллах хүчинд суурилсан ургацын тэгш хуваарилалт, мөн боолын тогтолцоог халах зэрэг ажлыг санаачилжээ. Түүх, газарзүйн салбарт анхаарал хандуулж, өөрийн байр суурийг илэрхийлж байсан төдийгүй өргөгч зэрэг тоног төхөөрөмж бүтээн шинжлэх ухаан, технологийн салбарт ч өөрийн мөрөө үлдээсэн хүн билээ.

정유재란, 丁酉再亂, **Улаагчин тахиа жилийн самуун** гэдэг нь Япончууд 1597 онд буюу Хар луу жилийн Японы довтолгооны дараа тогтоосон эв найрамдлыг эвдэн дахин дайралт хийсэн явдлыг нэрийддэг ажээ. И Сүнъ синь болон нэр бүхий хүмүүсийн гавьяагаар их гарз хохирол амссан японы тал Тойтоми Хидэйоши алагдмагц ухарчээ.

정음청, 正音廳, **Төв аялгууны хүрээлэн** бол Чосөн-ий Сэжон вангийн үед Хүнминьжөн-ым бичгийг зохиохын тулд ордонд байгуулсан газар ажээ. Мүнъжон вангийн 1450 онд байгуулагдаж 1452 онд татан буугджээ. →언문청(諺文廳)

정전, 丁錢, **цэргийн албанаас чөлөөлөгдсөний төлбөр** гэж Чосөн-ий үед цэргийн албанд дуудагдсан иргэн цэргийн албанаас чөлөөлөгдсөний төлбөрт төлөх мөнгийг нэрийддэг байжээ.

제물포조약, 濟物浦條約, **Жэмүл боомтын гэрээ** бол Чосөн-ий засгийн газар "Жэмүл боомтын гэрээ"-нд гарыг үсэг зурж, уг гэрээний дагуу Японд хохирлын мөнгөн төлбөр төлсөн бөгөөд Японы элчин төлөөлөгчийн газар, япон худалдаачдын мэдлийн бүс газрыг өргөжүүлж өгчээ. Үүгээр Чосөн-ий улс төр, эдийн засгийн хэрэгт оролцох Японы оролцоо улам нэмэгджээ.

제주도 濟州島, 濟州道, Jeju-do, **Чэжү арал** бол БНСУ-ын өмнөд тэнгист байрлах арал бөгөөд, БНСУ-ын хамгийн том арал билээ. Түүнчлэн Чэжү арал нь засаг захиргааны нэгжийн хувьд өөртөө удирдах тусгай мужид харьяалагддаг. Чэжү арлын нийт талбайн хэмжээ 1846 км² бөгөөд энэ нь Өмнөд Солонгос улсын нутаг дэвсгэрийн 1.83% -ийг эзэлдэг. 2020 оны байдлаар бүртгэлтэй хүн амын тоо 670 мянга орчим байсан бөгөөд, БНСУ-ын арлууд дундаас хамгийн их хүн амтай арал юм. Мөн Чэжү арал нь зүүнээс баруун тийш 73 км, хойноос урагш 31 км урт зууван хэлбэртэй бөгөөд төвдөө Халла уулыг тойрсон зөөлөн налуутай. Тойрог замын урт 181 км, эргийн шугам 258 км бөгөөд, Чэжү арлын хойд үзүүрт нь Кимнйөнг (김녕) далайн эргийн амралтын газар, өмнөд үзүүрт нь Сонаг (송악) уул, баруун үзүүрт нь Сүволбонг оргил (수월봉), зүүн үзүүрт нь Сонсан нар мандах оргил (성산 일출봉) байдаг. Чэжү арал нь халуун уур амьсгалтай газар нутагт хамаардаг бөгөөд, өвлийн улиралд ч гэсэн хасах температур биш нэмэх температуртай байдаг. Шар тэнгис болон Зүүн тэнгис, Зүүн Хятадын тэнгисийн хил дээр оршдог болохоор Солонгос улсын улс төр, эдийн засаг төдийгүй цэргийн салбарт ч чухал байр суурь эзэлдэг бүс нутаг юм. 2002 оны 12 дугаар сарын 16-нд ЮНЕСКО-оос уур амьсгал болон

биологийн олон төрлийн экологийн үнэ цэнийг нь харгалзан Чэжү арлыг биологийн бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалах газар болгожээ. Капа арал (가파도), Халла уул (한라산), Сонсан нар мандах оргил (성산 일출봉), Көмүньюрым лаавын агуйн систем (거문오름 용암 동굴계) зэргээс гадна эрдэм шинжилгээ, соёл, аялал жуулчлал, экологийн салбар дахь үнэ цэнэ, ач холбогдлыг нь хүлээн зөвшөөрч 2007 оны 6 дугаар сард Чэжү галт уулын арал болон лаавын агуй гэх нэрээр нь дэлхийн байгалийн өвд бүртгэжээ. 2010 оны 3 дугаар сарын 3ны өдөр ЮНЕСКО-гийн дэлхийн геопаркын сүлжээ (GGN) Чэжү арлыг дэлхийн геопарк гэж баталгаажуулжээ.

조병옥, 趙炳玉, Жо Бйон ог (1894-1960) Өвөр Цүнцөн муж (충청남도)-ийн хүн бөгөөд, Пайжай тусгай мэргэжлийн сургууль төгсөөд, Америкийн Колумбын их сургуульд эдийн засгийн мэргэжлээр сурсны дараа 1925 онд нутагтаа ирээд Йөнъхый тусгай мэргэжлийн сургуулийн профессор болжээ. Чөлөөлөлтийн дараа Хань улсын Ардчилсан намд элсэн орж, Америкийн цэргийн засгийн газрын Цагдаагийн яамны сайд, Солонгосын дайны үед Дотоод хэргийн сайдаар ажиллаж байжээ. 1949 оноос Ардчилсан Ардын намын, 1955 оноос хойш сөрөг нам болох Ардчилсан намын гишүүн байснаа 1958 онд Ардчилсан намын удирдах зөвлөлийн гишүүн болжээ. Тэрээр 1960 онд Ардчилсан намаас ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшсэн бөгөөд, сонгууль болохоос арав хоногийн өмнө гэнэт өөд болжээ.

조선, 朝鮮, Joseon, Chosŏn, Чосөнь улс бол 1392 оноос 1910 оныг хүртэл нийт 518 жилийн турш Солонгосын хойгт оршин тогтнож байсан хаант улс юм. Улсын вангаас гадна хүчирхэг бичгийн, цэргийн түшмэлүүд төвлөрсөн эрх барих тогтолцоог бий болгож улс төрийн бодлогыг явуулж байжээ. Энэ үед хөдөө аж ахуйн эдийн засагт төвлөрсөн байгалийн эдийн засгийн тогтолцоо хүчтэй байсан бөгөөд, Янбанъ (양반) бичгийн, цэргийн түшмэлүүд төвт анги давхаргын нийгэм байсан ч түүхий эдийн эдийн засаг хөгжихийн хэрээр анги давхаргын тогтолцоо аажмаар суларсан. Чосөнь улс нь Корйё улсын дараах, өөрөөр хэлбэл 1392-1910 он хүртэл Солонгосын хойг болон түүний харьяа арлуудыг 518 жил захирч байсан улс бөгөөд, Шинэ хүнзийн суртал (성리학)-д

суурилсан хэмжээгүй эрхт хаант засаглалтай улс юм. Корйё улсын сүүл үеийн эмх замбараагүй байдлын үед хүхрийн хүчлийн тулаан гэх тулалдааны идэвхтэй үйл ажиллагаа явуулснаараа агуу жанжин хэмээн алдаршсан И Сөнгйэ (이성계) жанжин Вүйхва арал (위화도) руу буцаж ирснээр Корйё улсыг устгаж, Ко Чосөнъ (고조선) улсын нэрийг залгамжилж улсаа байгуулжээ. Үүнээс хойш 1897 онд Кожон ван (고종) Их Хань улсыг тунхагласнаар улсын нэр өөрчлөгджээ. Улсынхаа нэрийг Чосөнъ хэмээн нэрлэсэн өдөр бол 1393 оны билгийн тооллын 2 дугаар сарын 15-ны өдөр байсан бол 1897 оны аргын тооллын 10 дугаар сарын 12-ны өдөр Их Хань улсыг албан ёсоор тунхагласан байдаг. 1910 оны 8 дүгээр сарын 29-ний өдөр Японы колоничлолын үе эхэлж үндэсний тусгаар тогтнолоо алдсанаар Их Хань улс дахин түүхийн харанхуй зам руу орох болжээ. Хожуу Гурван улсыг дахин нэгтгэсэн Корйё улсаас өөр нь И Сөнгйэ жанжины нэг талыг барьсан хувьсгалаас үүдэж улсыг удирдсан хүн нь хаан угсааны хүн байсан учир эхэн үедээ Корйё улсыг тэр чигээр нь удирдаж байгаагаас өөрцгүй байжээ. Хэдий тийм ч Корйё улсын сүүл үед Юань гүрэн улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцдог байсан тэр үеийн гадны нөлөө болон шинэ хүнзийн суртлын урсгалыг Корйё улсаас илүү Чосөнъ улсын үед маш их шийджээ. Корйё улсаас хамгийн их ялгаатай нь буддын шашиныг дарж хүнзийн суртлыг дэлгэрүүлсэн явдал юм. Чосөнъ улсаас өмнө оршин тогтнож байсан хойгийн улсууд Хятадаас гаралтай шашины өнгө аястай үзэл суртал болох хүнзийн суртлыг шашин гэж харалгүй төрийн үзэл суртлын хэмжээнд хүлээн зөвшөөрч байсан бөгөөд, Гурван улсын үеэс хойш мянган жилийн турш ноёрхож байсан уламжлалт буддын шашинаа төрийн шашин гэж үздэг байжээ. Гэвч Корйё улсын сүүл үед Хятадаас хүнзийн суртал орж ирэхэд Чендожон тэргүүтэй шинэ үеийн садайбү (사대부) сэхээтнүүд үүнд ихээхэн нөлөөлж Чосөнъ улсыг байгуулж хүнзийн суртлыг төрийн зарчим болгон баримталж байсан бөгөөд Чосөнъ улс мөхөх хүртэл хүнзийн суртал нь төрийн сургаал байжээ. Энэ бол Солонгосын хойгт оршин тогтнож байсан улсуудаас ялгарах хамгийн том ялгаа юм. Мөн Корйё улсаас нэг шат илүү сайжирч төвлөрсөн эрх барих захиргаадалтын системтэй улс болсон. Энэхүү хүчирхэг төвлөрсөн хүчээ түшиглэн “Хүнзийн

үзэл суртлын дагуу удирдуулсан өв тэгш улсыг байгуулах” хэтийн зорилгынхоо хүрээнд улс байгуулснаас хойш 100 жилийн дараа улс орныхоо онцөг булан бүрд хүнзийн суртлыг түгээн дэлгэрүүлж чадсан. Тийнхүү хүнзийн суртал дээд цэгтээ хүрч байсан үе бол 17-р зууны Чосөнъ улсын дунд үед юм. Энэ нь дахин тус улсын хожуу үед ч байсан бөгөөд, католик шашин дэлгэрч, шинжлэх ухаан сэргэн мандахтай зэрэгцэн хүнзийн суртлын өнгө аяс аажмаар бүдгэрч байсан ч аж үйлдвэржилт, хөгжил дэвшил орчин үежсэн өнөө үед ч түүний үлдэгдэл Умард болон Өмнөд Солонгост тодорхой хэмжээгээр үлджээ. Одоо цагт Солонгосын хойгт "уламжлалт соёл" гэж нэрлэгддэг зүйлсийн ихэнх нь Чосөнъ улсын үе (ялангуяа 18-р зуунаас хойших Чосөнъ улсын дунд, сүүл үе)-д үүссэн гэдэг. Чосөнъ улс түүх болон үлдсэнээс хойш 100 гаруй жил өнгөрсөн бөгөөд, Японы колоничлолын үе, цэргийн дэглэмийн үе, ардчиллын үе зэрэг нийгмийн олон өөрчлөлт гарсан ч Чосөнъ улсын үеийн хүнзийн суртлаас үүдэлтэй соёл өнөөг хүртэл Солонгост тодорхой хэмжээгээр гүн гүнзгий оршсоор байна. Үүний тод жишээ нь тахил өргөх ёслол, нас сүүдрээс хамаарч хүнийг хүндлэх соёл, эрэгтэй хүүхдийг илүү шүтэх үзэл, ууган хүүгээ чухалчилдаг үзэл, эмэгтэйчүүдийн цэвэр ариун байдлыг онцгой анхаардаг үзэл, эрэгтэй хүнийг гэрийн тулгуур багана хэмээн үздэг эцгийн эрхт соёл гэх мэт. Гэхдээ цаг хугацаа өөрчлөгдөхийн хэрээр дээрх үзлүүдийн мөн чанар ч бага зэрэг өөрчлөгдсөөр байна. Чосөнъ улсын үед бий болсон гар урлалын хэв маяг болох Чосөнъ цагаан шаазан өнөөг хүртэл Корйё улсын үеийн цэлладон шигтгээний нэгэн адилаар Солонгосыг төлөөлдөг гоёл чимэглэлийн ховор эд зүйлд тооцогдож байгаа бөгөөд Солонгосын олон ваар урлагчид үүнийг үйлдвэрлэдэг байна. Тиймээс Солонгос болон хөрш зэргэлдээ Япон улс хоёрын соёлын ялгаа гэж хэлэгдээд байгаа зүйлүүдийн ихэнх нь үнэндээ Чосөнъ улсын үед шахагдсан буддын шашины соёлоос үүдэлтэй зүйл маш их байгаа нь хоолны соёл, цайны соёл, хооллох ёс, оршуулгын ёслол гэх мэтээс харж болно. Японы түүхэнд буддын шашиныг шахаж хавчиж байсан үе байдаг хэдий ч Солонгос шиг олон зуун жилийн турш системтэйгээр шахаж байсан түүх байдаггүй ажээ. Өмнөд, Умард хоёр Солонгос улс Чосөний газар нутаг, соёл зэргийг хувааж өвлөн авсан хэдий ч тус хоёр улсын мөн чанар үүнээс огт тусдаа юм. Хэдий тийм

ч Өмнөд Солонгос нийслэл хотоо Чосөнъ улсын нийслэл байсан Сөүлийг тэр хэвээр нь өвлөж авсан бөгөөд, одоогийн хэрэглэж байгаа мөнгөн тэмдэгтийн стандарт болох вон болон Их Ханъ улсын үед хэрэглэсэн анхны нэгж, мөн тэрхүү мөнгөн тэмдэгтэд дүрслэгдсэн хүмүүс бол 100 хувь Чосөнъ улсын эхэн болон дунд үед 200 орчим жилийн хугацаанд амьдарч байсан хүмүүс юм. Кванхвамунъ зэрэг олон газарт Чосөнъ улсын агуу хүмүүсийн дурсгал байдаг ба үсэг бичгийн хувьд ч Чосөнъ улсын үед зохиосон Ханъгыл үсгийг албан ёсны болгон тасралтгүй хэрэглэсээр байгаа зэрэг нь Чосөнъ улсын соёлын нөлөө одоогийн БНСУ-д ч асар их нөлөө үзүүлсээр байгааг харуулж байна. Тэр бүү хэл улсын далбаа ч мөн адил Чосөнъ улсын сүүл үеэр анх хийж, хуульчилсан далбаа бөгөөд, Тайханъ (대 한) гэх улсын нэр нь Их Ханъ улсын үед анх хэрэглэсэн улсын нэрнээс гаралтай. Үүнээс гадна одоо ч гэсэн Хятад, Япон, Вьетнам зэрэг ханз үсгийн соёлтой улс орнууд Солонгосыг Чосөний хойг, чосөнъ хэл, чосөнъ үндэстэн, Чосөний дайн гэж нэрлэх нь элбэг. Түүнчлэн Японы колоничлолын үе болон Америк, Оросын цэргийн засаглалын үе хүртэл солонгосчуудын дунд “Чосөнъ” гэдэг үг албан ёсны болон өдөр тутмын аль алинд нь хойг, үндэстэн, хэл, соёл зэрэг утгыг илтгэдэг үндсэн нэр болон оршиж байсан бөгөөд, үүний дараа зөвхөн Умард Солонгосын засгийн газар өнөөг хүртэл албан ёсны улсын нэрээр ашигласаар байна. Улс байгуулагдсаны дараах эхэн үеэр Тхайжо вангаас Сөнжон ван хүртэлх хугацаанд хааны эрх мэдэл хүчтэй, амар тайван нөхцөл байдалтай ялагдашгүй байсан хэдий ч дунд үеэс эхлэн Японы довтолгоон, Улаан хулгана жилийн самуунаас болж бараг улс унах аюултай нүүр тулж байжээ. Дайны дараа сүйрсэн улс орноо дахин сэргээн босгож Йөнжо, Чөнжо вангийн үед гайхамшигт соёлыг цэцэглүүлэн хөгжүүлж улсын мандан бадрах ид үе байсан хэдий ч Чосөнъ улсын сүүл үеэр засаглалыг атгах эрх мэдлийн уршгаар улс дахин эмх замбараагүй болж энэ үед түрэмгийлэх үзэлтэй хүчирхэг гүрнүүд хөндлөнгөөс оролцдог сул дорой орон болж, эцэст нь Японы колони болсноор 1910 онд Чосөнъ улс түүхийн хуудаснаа алга болжээ. Цэргийн түшмэдийн эрх мэдэл хүчтэй байсанаас үүдэж бослого байнга гардаг байсан Корйө улсын нийгмийн гажуудлыг засч залруулах замаар улс байгуулсан гэх онцлогынхоо хүрээнд улс байгуулагдсаны эхэн үед бичгийн хүнийг цэргийн хүнээс илүүд

үзэх зарчимд тулгуурлан хүчирхэг төвлөрсөн эрх барих засаглалын тогтолцоотой болж, улс төрийн тогтвортой байдалд амар тайван амьдрах боломжтой болсон байна. Улс байгуулагдах эхэн үе буюу И Сөнгйэ, И Банвонь нарын үед цэргийн удирдагч улсыг удирдах эрх мэдэлтэй байсан нь мэдээжийн хэрэг байсан учир цэргийн хүмүүсийн хүч чадал хэзээ ч сул дорой байгаагүй ажээ. Харин цаг хугацаа өнгөрөхийн хэрээр улсын батлан хамгаалах хүчийг бэхжүүлэх ажил орхигдож, үндсэндээ цэргийн хүмүүсийн хүчийг дарж эхэлсэн нийгмийн байдлаас болж улсын хүчин чадал суларч эхэлжээ. Нөгөө талаараа Хятад, Японд хаагдсан байрлалтай хаалттай газар оршиж байсан хэдий ч Чосөнъ бол дэлхийн төв цэг гэж өөрсдөөрөө бахархах үзэл (소중화), хятад хүмүүсээс бусдыг жигших, үгүйсгэх Хваи үзэл (화이관) болон хүнзийн сурталтай зууралдаж, Чөнжо вангийн үеэс эхлэн бусад улсын усан онгоцтой харилцах саналаас өөрсдөө татгалзах зэрэг олон улсын харилцаа, худалдаа, аж үйлдвэрийн хөгжилд ахиц дэвшил гаргаагүйгээс гадна төрийн албаны хүнд сурталтнуудын шударга бус явдал зэрэг дотоодын асуудал хүртэл давхцсанаар эдийн засаг нь ч нилээд хүнд байдалд орж эцэстээ гадны түрэмгийлэлд аймшигтай харгислалаар сүйрэх нөхцөл байдалд бүрэн хүрчээ. Кожон вангийн үед л сэргэн мандалтаа өөрсдөө хамгаалсан боловч эрх баригч хүч нь шийдмэг бус, мэдлэг дутмаг ялзарсан хэвээр байсан тухайн үед бусад улс орнууд хэдийнээ орчин үеийн хөрөнгөтөн орон болж хүчирхэг цэргийн баазтай болсон хойно Чосөнъ идэвхтэй урагшилсан ч хэтэрхий оройтсон байсан учир Японы хараат болж, нэгдэхээс өөр гарцгүй болжээ. Чосөнъ улс хүнзийн сургаалыг төр удирдах үзэл баримтлалаа болгосон хаант улс байжээ. Чосөнъ улсыг 1392 оны 7 дугаар сарын 17ны өдөр Корйё улсын цэргийн офицер байсан Тхайжо, И Сөнге нар байгуулсан бөгөөд, 1897 оны 10 сард Кожон ван өөрийгөө эзэн хаан хэмээн өргөмжилж төрийн он тооллыг тогтоосноор улсын нэр Их Ханъ эзэнт улс болжээ. Нийслэл нь Ханъян (Одоогийн Сөүл)-д байсан бөгөөд, хойд талаараа Аброг болон Түмэн голоор Хятад, Орос улстай хиллэж байжээ. 1393 оны 2 дугаар сарын 15ны өдөр улсынхаа нэрийг “Чосөнъ” хэмээн нэрийдсэн бөгөөд, 1394 онд Ханъяныг нийслэлээ болгож “сайд төвтэй улс” болгохыг хүсч байсан Чөн Тожөнъ (정도전) тэргүүтэй хүмүүс Корйё улсын тухайн үеийн төрийн тогтолцоог

өөрчилжээ. Тхайжо (태조) вангийн хүү И Панвонь (Тхайжон) тусгай эрхт ангид харьяалагдаж байсан хувийн цэргийг хүчээр татан буулган Чосөний армид нэгтгээд, пайз хуулийг хэрэгжүүлж, хааны эрх мэдлийг ихээхэн бэхжүүлсэн бөгөөд, Чөн Тожөнъ-ийг хорлогдсоны дараа төрийн тогтолцоог сайд төвтэй Ыйжөнбү (의정부)-хувийн сайдын яамын тогтолцооноос хаан төвт зургаан яаманд төвлөрсөн улс төрийн тогтолцоо болгон өөрчилжээ. Сэжон ван 1443 онд эрдэм мэдлэгийг чухалчилан Мэргэдийн өргөө (집현전)-г ордонд байгуулаад, Чан Йёншил (장영실)-ийг албан тушаалд томилж хүү Мүнъжон (문종)-тойгоо хамт шинжлэх ухааныг хөгжүүлэхэд шаргуу ажилласан бөгөөд, хүнъминъ чөным (훈민정음) үсгийг зохиож ард түмэн рүүгээ чиглэсэн төрийн бодлогыг явуулж байжээ. Дараагийн хаан ширээнд суусан Танъжон (단종) ванг түүний үеэл болох Сэжо (세조) төрийн эргэлт хийн хөөн зайлуулж, улмаар хууль ёсны байдалд эсрэг байр суурьтай байсан хүчнийг зайлуулсны дараа Тхайжон ван шиг зургаан яаманд төвлөрсөн төрийн тогтолцоог сонгон хааны эрх мэдлийг бэхжүүлснээр “Дорнод гүрний түүхийн нэгдсэн толь (동국통감)”, “Улсын нэвтэрхий толь (국조보감)” зэргийг бичиж байжээ. Богино насалсан Йэжон (예종) вангийн дараагаар хаан ширээнд суусан Сөнжон (성종) ван улс орныг удирдах үндэс болгож “Төр засах их цааз (경국대전)”-ыг эмхэтгэх гэх мэт соёлын тогтолцоог засаж янзалжээ. 15-р зууны сүүл үеэс эхлэн орон нутгийн сарим сэхээтнүүд улс төрд оролцон тухайн үеийн сайд болох хүнъгү (훈구) буюу гавъяат түшмэлийн бүлгэмтэй зөрчилдсөнөөр улс төр нь будлиантах болжээ. Сарим сэхээтнүүд болон түшмэлийн бүлгэмийг аль алийг нь гадуурхаж ганцаараа улс төрийг удирдах болсон Йөнъсанъ гүнъ (연산군) ваныг Чүнжоны эргэлтээр (중종반정) хаан ширээнээс буулгасны дараа хаан сэнтийд заларсан Чүнжон ван Чо Кванжо (조광조)-ыг чухал албан тушаалд томилох зэрэг сарим гавъяат түшмэлүүдэд автуулахгүйг их хичээсэн хэдий ч энэ нь ямар нэг ололт амжилтанд хүрч чадаагүй ажээ. Инъжон ван, Мйөнжон ван хоёр ч мөн адил сарим, хүнъгү хоёрын хоорондын зөрчилдөөний улмаас идэр залуу насандаа нас баржээ. Сөнъжо вангийн үед хүнъгүгийн бүлгэм улс төрөөс хөндийрч, сарим бүлгэм улс төрд ноёрхох болжээ. Харин сарим сэхээтнүүд үзэл суртал, ашиг

сонирхлынхоо дагуу дотроо хуваагдан баруун, зүүн гэж сөргөлдөх өнцөг үүсгэснээр нам, бүлгийн улс төртэй болжээ. 200 жилийн турш томоохон дайн дажин хийлгүй амар тайван амьдарч байгаад 16-р зууны сүүлчээр Чосөн улс Японы довтолгооноор газар нутаг нь хөмөрсөн мэт ундуй сундуй болж, санхүүгийн байдал доройтож, ард иргэд нь зовлон бэрхшээлд нэрвэгджээ. Барууныхан төрийн эргэлтээр Кванхай гүн (광해군)-ийг хөөн зайлуулсны дараа хаан ширээнд суусан Инъжо ван Мин улстай ойртож Хожуу Алтан улсын эсрэг зогсох бодлого барьж өөрсдийгөө хамгаалж байсан энэ үед Чин улсаас Чосөн улс руу довтолсон хоёрдахь дайралтын үеэр гарсан Улаан хулгана жилийн самуун болжээ. Энэхүү мухардмал байдалд тулгуурлан хүнзийн суртлын нөлөө бэхжиж, Чосөн улсын түүх хожмын үе рүү шилжсэн. Самжонъдо-гийн гутамшигт нэрвэгдсэн ордонд Чин улсыг булаан эзлэх зорилготой умардыг дайлаар мордох бодлого (북벌론) болон Чин улсаас үлгэр дууриал авах умардаас суралцах бодлого (북학론) тус тус гарч ирсэн хэдий ч Хйожон (효종) ван эмчилгээний ослоор нас барснаар умардыг дайлаар мордох бодлого унаж, умардаас суралцах бодлого ч ялгаагүй Чин улсын Зөрчид (여진족) овгуудыг дорд үздэг хүнд сурталт хүмүүсээс болж төрийн хэрэгт биелэлээ олж чадаагүй ажээ. Үүний дараа хаан ширээнд суусан Хйонъжон (현종) ван ард иргэдээ их өлсгөлөнгөөс ангижруулж, улмаар дайнд шавхагдсан санхүүгээ тогтворжуулаад, үгүйрч сүйрсэн Чосөн улсаа дахин сэргээж барууныхныг хяналтандаа байлгах тал дээр хамаг хүчээ дайчилж байжээ. Энэ үед Сүгжон (숙종) ван нам, бүлгийн улс төрийг нэг өдрийн дотор ор мөргүй алга болгож улс орноо өөрчлөх оролдлого байнга явуулж байсан бөгөөд, нам бүлгийн улс төр нь хяналт, тэнцвэрт байдлаас үүдэж харилцан зэрэгцэн оршиж, улмаар ялзралтай тэмцэх журам нь бүдгэрч, засгийн эрхийг авах болгондоо сөрөг хүчнээ бүгдийг нь хөөн зайлуулах зэрэг нэг талын дарангуйлалын засаглал тогтох хандлагатай болж байжээ. Сүгжон вангийн таалалд нийцсэн Чан хыйбинь (장희빈)-ийн төрсөн хүү Кйонжон (경종) соронь залуусын хүчин (소론) болон норонь ахмадын хүчин (노론) хоёрын сөргөлдөөнд ядарч хаан ширээнд сууснаасаа хойш 4 жилийн дараа насан эцэслэжээ. Кйонжоны дүү Йонжо (영조) ван хоёр талын сөргөлдөөнийг таслан

зогсоохын тулд нам бүлгүүдэд тэнцүү хандах Танпйөн бодлого (탕평책)-ыг эхлүүлсэн боловч нам, бүлгийн улс төрийг бүрэн устгаж чадаагүй бөгөөд, эсрэгээрээ хоёр дахь хүү болох угсаа залгамжлах Садо ханхүүгээ будааны хайрцганд хорьж байгаад үхэхэд хүргэсэн Хар морин жилийн хачирхалтай хэрэг гарч байжээ. Энэ хэргийн дараахан Чосөн улсын нийгэмд өрнөдийн сургаал католик шашин орж иржээ. Йёнжо вангийн дараа хаан ширээнд суусан Чёнжо (정조) ван нам бүлгүүдэд тэнцүү хандах Танпйөн бодлогыг хэрэгжүүлэхээс гадна Чён йагйон (정약용) зэргийн нийгмийн шинэчлэлийн онол гаргасан шилхаг (실학) сурталтнуудыг олж Сүвонь хотын цайз хэрэм босгох ажил гэх мэт өөрчлөлт шинэчлэлт хийх бодлогыг явуулж байсан хэдий ч 1800 онд гэнэт нас нөгчжээ. Үүнээс хойш нэг угсаа гарал дангаар дарангуйлах засаглал эхэлж 19-р зуунд Сүнъжо (숙조), Хёнъжон (헌종), Чхөлжон (철종) гурван вангийн үе үргэлжилж байжээ. Энэ үед Чосөн улс маш хурдацтай уналтанд орж байжээ. Эхийн талын удам угсааныхан нь хаан ширээг томилоход хүртэл гар бие оролцох болж, улмаар шударга бус явдал, ялзралд идэгдэж эмх замбараагүй байдал даамжирч байжээ. Энэ хооронд Хынсөн гүн (흥선군), И хаын (이하응) нар Пхүнйан жо (풍양 조) овгийн гол хүн болох Чо дайби (조대비)-тай хуйвалдаж хоёр дахь хүү Мйёнбог (명복)-ыг Чосөн улсын хааны суудалд суулгасан бөгөөд, тэр нь Кожон ван юм. Кожон ван хаан ширээнд заларсны дараа Хынсөн гүн нь Хынсөн Тайвоньгүн (흥선대원군) болж Кожон вангийн ар талаас удирддаг байжээ. Тэрээр нам, бүлгийн улс төрийн үндэс суурь болох бичгийн хүрээлэнг татан буулгах, эхийн талын удам угсааныхан болох Анъдон (안동) нутгийн Ким овгийн нөлөө бүхий хүмүүсийг хөөн зайлуулах гэх мэт хааны хүчирхэг эрх мэдлийг бэхжүүлж байжээ. Франц, Америкын гадаад худалдаа хийх хүсэлт шаардлагад хамтарч ажиллахаас татгалзаж буйгаа илэрхийлж байжээ. 1873 онд Чой игхйонь (최익현) Хынсөн Тайвоньгүн-ийг буулгаж, улмаар Кожон ван улс орны асуудлыг шууд хариуцаж эхэлсэн бөгөөд, Кожон вангийн эхнэр Мйёнсөн хатан (명성황후) Минь овгийн хүмүүсийг төрийн чухал албан тушаалд олноор нь томилон төрийн эрхийг гартаа авч жинхэнэ эрх мэдэлтэн болсноор гадаад ертөнцийн үүд хаалгыг нээлттэй болгожээ. Хар морин

жилийн цэргийн бослого (임오군란) болж Чосөнъ улсын хаан угсааныхныг сүрдүүлмэгц Мйөнсөн хатан Чин улсыг татан оруулснаар тэрхүү бослогоос хойш Чин улс нэг талыг барьсны хувьд Чосөнъ улсын эрх баригчаар бат зогсох болжээ. 1876 онд Чосөнъ улс хамгийн анхны шинэ үеийн гэрээ болох Канхва арлын гэрээг Япон улстай байгуулжээ. 1882 онд хуучин цэргүүд тусгай цэргийн анги (별기군) -ийн ялгаварлан гадуурхах хандлагыг эсэргүүцэн бослого гаргасан бөгөөд, 1884 онд Ким Оггйүнъ (김옥균) зэргийн хүмүүс удирдаж эрс шинэчлэлт хийсэн боловч гурав хоногт л бүтэлгүйтжээ. 1894 онд тариачдыг дээрэмдэн мөлжих байдлыг эсэргүүцэж, тариачдын бие даасан байдлыг шаардсан Дорнын сурталт тариачдын хөдөлгөөн (동학농민운동) өрнөсөн бөгөөд, энэ нь Модон хөх морин жилийн шинэчлэлт болж үргэлжилжээ. 1895 онд Японыг дэмжигчдийн бүлгэмийнхэн Японы дарангуйлалтай зэрэгцэн Оросыг дэмжигч Мйөнсөн хатныг хороосноор занал сүрдүүлгэнд орсон Кожон ван 1896 онд нууцаар Оросын консулын газар орж хорогдож байжээ. 1897 оны 11 дүгээр сард Кожон ван Кйөн-үнъ (경운) ордон руугаа буцаж ирээд Төгсү (덕수) ордон болгож засаад, тэнгэр газарт тахил өргөдөг газраа Их Ханъ улсыг тунхаглажээ. Чосөнъ улсыг үндэслэгч шинэ садайбү сэхээтнүүд хүнзийн сургаалийг төрийн бодлого болгож, нийгмийг бүхэлд нь шинэчлэхийг оролдож байжээ. Чосөнъ улс хүнзийн суртлыг дэлгэрүүлэх, буддизмыг дарах бодлого явуулж шинэ хүнзийн суртлыг сурталчилан буддын шашиныг ихэд дарж байсан бөгөөд, үр дүнтэй төвлөрсөн бодлого хэрэгжүүлснээр улсын эрх мэдлийг бэхжүүлж чаджээ. Чосөнъ улс байгуулагдсанаасаа хойш 200 орчим жилийн турш тайван амгалан байдалтай байсан ба тэр дундаа Сэжон вангийн үед уран зохиол, шинжлэх ухаан, урлаг, уран барилга зэрэг бүхий л салбарт амжилт гаргаж, Чосөнъ улсын соёл хөгжих болжээ. Цаг хугацаа өнгөрөх тусам энэ байдал буурсан бөгөөд, улмаар гадаад худалдааны харилцаанд татгалзах бодлого баримталж, гадаад улстай харилцах харилцаагаа хаажээ. Үүнээс болж бусад улсууд Чосөнъ улсыг "Нуугдмал хаант улс" гэж нэрлэдэг байжээ. Чосөнъ улсын хожуу үед урлаг хөгжиж, хоол хүнс, үйлдвэрлэл нэмэгдснээр хүн ам ч өсчээ. Гэвч 18-р зуунаас эхлэн нийгмийн давхаргын үймээн, эрх мэдэлтнүүдийн эрх мэдлийн төлөөх

тэмцэл, шударга бус явдал, бослого зэрэг хор уршиг мэдэгдэхүйц хурцдаж, 19-р зуунд ард түмний хүч хүчирхэгжиж, төвлөрсөн засгийн газраас мужуудад тавих хяналт харьцангуй ихээр суларсантай холбоотой улсын хүчин чадал маш хурдацтай уналтанд орж байжээ.

조선공산당, 朝鮮共產黨, Чосонь-ий коммунист нам –Японы нийгмийн капиталист системийг нураах хэрэгтэй гэж үздэг марксист онолчид Японы дарангуйллыг эсэргүүцэн тусгаар тогтнолын хөдөлгөөн өрнүүлэх зорилгоор 1925 онд Чосонь-ий коммунист нам (조선공산당)-ыг байгуулж, ажилчдын тэмцлийг удирдах зэргээр тусгаар тогтнолын төлөө тэмцэж эхлэжээ. Нийт дөрвөн удаа нам шинээр байгуулагдаж байсан хэдий ч бүгд татан буугдсан ажээ. Чөлөөлөлтийн дараа Паг Хонь йон (박헌영) нийслэл рүү ирж Чосонь-ий коммунист намыг дахин байгуулж, ерөнхий нарийн бичгийн дарга нь болж намыг удирдсан бөгөөд, дахин сэргээсэн Чосонь-ий коммунист нам чөлөөлөлтийн дараа “хөрөнгөтний ардчилсан хувьсгалын онол” гаргаж, ажилчин тариачдаар манлайлуулан хотын иргэд, сэхээтнүүдийг нэг фронтод нэгтгэх, том газрын эздийн хөрөнгийг хураах бодлого дэвшүүлж байжээ. Тус нам өөрийн намын байгууллагуудаас гадна Ажилчны нэгдсэн хороо, Тариачны нэгдсэн холбоог байгуулж, хүчээ бэхжүүлжээ. 1945 оны 9 дүгээр сарын 6-нд Улсаа төвхнүүлэх бэлтгэл хорооноос Бүгд Найрамдах Чосонь Ард Улс (조선인민공화국) -ыг зарлан тунхагласан бөгөөд, тухайн үед баруунтны удирдагчдын идэвхгүй сул дорой байдлаас болж Чосонь-ий коммунист намыг байгуулсан Паг Хонь йон (박헌영) засгийн газрын бодот эрхийг атгах болж, үндсэндээ зүүний үзэл баримтлалтай засгийн газраас өөрцгүй болж байжээ. Чосонь-ий коммунист нам баруун, зүүний хүчнийг нэгтгэх хөдөлгөөнийг эсэргүүцэж, 1946 оны 7 дугаар сарын 26-ны өдрөөс олон нийтийг хамарсан тэмцэл хийж эхлэжээ.

조선노동연맹회, 朝鮮勞動聯盟會, Чосонь-ий ажилчдын холбоо – Японы колончлолын үед Хань улсын хямд хөдөлмөрийн хүчинд шунасан Японы том корпорациуд хөрөнгө оруулснаар уул уурхай түргэн хөгжихөд түүнийг дагаад ажилчдын хөдөлмөрийн маргаан ихэд гарах болжээ. Иймд 1920 онд “Чосонь-ий ажилчдын харилцан туслах нийгэмлэг (조선노동공제회)” байгуулагдаж,

улмаар 1922 онд “Чосөнъ-ий ажилчдын холбоо” нэртэй болж өөрчлөгдөөд улам бүр зохион байгуулалттай тэмцэх болжээ. Тухайлбал, 1921 онд Пүсанъ-ы боомтын ажилчдын ажил хаялт, 1923 онд Сөүлийн хаймрын үйлдвэрийн эмэгтэй ажилчдын ажил хаялт, мөн 1929 онд Вөнъсаны нийтийн ажил хаялт болж байжээ. Нэгэн нефтийн компаний япон хянагч, солонгос ажилчныг зодсон хэргээс үүдэж, түүнд Вөнъсаны Ажилчдын холбоо оролцсоны улмаас ажил хаялтын хүрээ өргөжиж, Вөнъсаны бараг бүх ажилчид оролцжээ. Уг ажил хаялтыг бүх улс даяараа дэмжиж, ажил хаягчдын амь зуулгыг залгуулахын тулд мөнгө хандивлах хөдөлгөөн ч өрнөж байжээ. Ажилчид эхэндээ хөдөлмөрийн хөлс нэмэхийг шаардан тэмцэж байсан бол аажмаар эвлэлдэн нэгдэх эрх олгох, ажлын найман цагтай болгохыг шаардаж эхлэсэн бөгөөд, улмаар Японы эсрэг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нэгэн хэсэг болон хөгжсөн ажээ.

조선민주주의인민공화국, 朝鮮民主主義人民共和國, Бүгд Найрамдах Ардчилсан

Солонгос Ард Улс (БНАСАУ): Солонгосын хойгын умард хэсэгт арай саад тотгор багатайгаар БНАСАУ тогтножээ. 1945 оны 9-р сарын 8-нд Америкийн цэрэг Инъцөнъ-д буухаас өмнө 8-р сарын 9-нд Зөвлөлтийн цэрэг Түмэн мөрнийг гаталж Умард Солонгост орж ирээд 8-р сарын 24-нд Пхйөнъян-д Ерөнхий штабаа байгуулжээ. Гэхдээ шууд цэргийн засаглал тогтоохоос зайлсхийж, нутаг тус бүрээс баруун зүүний хүчний төлөөлөгчдийг оролцуулан "Ардын хороо (인민위원회)" байгуулж түүгээр дамжуулан дам захирах арга сонгосон ажээ. Харин 9-р сарын дундуур Зөвлөлтийн армийн шууд нөлөөн дор байгуулсан Чосөнъ-ий ажилчны бригадын удирдагч Ким Ил сөн тэргүүтэй партизанууд орж ирээд зүүнтнүүдийг толгойлох болжээ. Гуч гаруй насны залуу Ким Ил сөн богино хугацаанд улс төрийн эрх мэдлийг гартаа оруулж эхлэжээ. 1945 оны 10-р сарын дундуур "Коммунист намын умард Чосөнъ-ий салбар (조선공산당 북조선분국)" -ыг зохион байгуулж, 11-р сарын дундуур "Умард Чосөнъ-ий таван мужийн захиргаа (북조선 5도 행정국)" -г байгуулж засаг захиргааны суурь тогтолцоог бий болгожээ. 1946 оны 4-р сард "Коммунист намын Умард Чосөнъ-ий салбар" -ыг "Умард Чосөнъ-ий коммунист нам" гэж өөрчлөн нэрлээд Ким Ил сөн-г даргаар тавьж,

Сөүлд төвтэй "Чосөн-ий коммунист нам"-аас бүрэн тусгаарлажээ. 1946 он гармагц Умард Солонгос үтэр түргэн өөрчлөн шинэчлэх ажилд орж байжээ. 1946 оны 2-р сард Ким Ил сөн даргатай "Умард Чосөн-ий ардын түр хороо"-г байгуулж, ардын ардчилсан засаглал тогтоож, "империализм, феодализмын эсрэг ардчилсан хувьсгал" хийжээ. Ардчилсан хувьсгалын гол тэнхлэг нь "Газрын шинэчлэлт", "үйлдвэрлэлийн гол салбарыг улсын өмчид шилжүүлэх" ажил байжээ. Умард солонгос ардчилсан шинэчлэлт"-тэй зэрэгцүүлэн коммунист намыг нийт ард түмний байгууллага болгон өргөжүүлэхийн тулд 1946 оны 8-р сард "Умард Чосөн-ий коммунист нам" ба Иён-аны фракцын удирдагч Ким Ду боны тэргүүлсэн "Умард Чосөн-ий шинэ иргэний нам (1946.2)"-ыг нэгтгэж, "Умард Чосөн-ий Хөдөлмөрийн Нам"-ыг үүсгэн байгуулжээ. Умард Солонгос 1947 оны 2-р сард засаг захиргааны дээд байгууллагаар "Умард Чосөн-ий ардын зөвлөл", 1948 он 2-р сарын 8-нд "Ардын цэрэг" үүсгэн байгуулснаа зарлажээ. Умард Солонгос 8-р сарын 25-ны өдөр Ардын дээд хурлын гишүүдийг сонгох сонгуулийг явуулж, 9-р сарын 8-нд Ардын ардчилсан үндсэн хууль батлан гаргаад 9-р сарын 9-нд "Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс"-ыг тунхаглажээ. Тэгээд төрийн далбаа, төрийн сүлд дуулал бүтээж, Сөүл хотыг нийслэл хот, Пхйөн-ян-г түр нийслэл хот болгожээ.

조선어학회, 朝鮮語學會, Чосөн хэл судлалын нийгэмлэг бол 1921 онд Жү Ши гйөн (주시경)-ий бичгийн шавь байсан 10 хүн эх хэлээ судлах, хөгжүүлэх зорилгоор байгуулсан иргэний эрдэм шинжилгээний хүрээлэн ажээ. 19-р зууны сүүлээр Жү Ши гйөн (주시경), Жи Сөг йөн (지석영) нар солонгос хэл судлах хүрээлэнгүүд байгуулж их зүйл хийсэн бөгөөд, 1907 онд Боловсролын яамнаас Эх хэл судлах газрыг байгуулснаар олон эрдэмтдийн хүчийг нэгтгэн зангиджээ. Тэднээс хамгийн том төлөөлөгч нь Жү Ши гйөн байсан бөгөөд, "Эх хэлний хэлзүй (국어문법)", "Хэлний авиа (말의 소리)" зэрэг ном зохиосон хүн ажээ. Түүний шавь нарын байгуулсан "Чосөн хэл судлалын нийгэмлэг" нь 1931 онд "Чосөн хэлний нийгэмлэг" хэмээн нэрээ өөрчилсөн

бөгөөд хожим “Ханъгыл судалгааны нийгэмлэг (한글학회)” болгон өөрчилсөн ажээ.

조선왕조실록, 朝鮮王朝實錄, **Чосөнъ улсын үнэн тэмдэглэл** бол Чосөнъ-ий хааны угсааг үндэслэн Тхайжо (태조) вангаас эхлээд Чхөлжон (철종) ван хүртэлх 25 хааны 472 жилийн (1392-1863) түүхийг он, сар, өдрийн дарааллаар тэмдэглэсэн ном юм. Чосөнъ улсын үеийн улс төр, гадаад харилцаа, цэрэг, төрийн тогтолцоо, хууль зэрэг бүхий л салбарын түүхийг тэмдэглэсэн түүхэн тэмдэглэл ажээ.

조선청년독립단, 朝鮮靑年獨立團, **Чосөнъ залуучуудын тусгаар тогтнолын бүлэг:**

1910-аад оны үед дотоодын тусгаар тогтнолын хөдөлгөөнүүд Японы дарамт шахалтын улмаас нууц байдалд үйл ажиллагаагаа явуулах болжээ. Дэлхийн I дайн дуусч, Америкийн ерөнхийлөгч үндэсний асуудлаа өөрөө шийдвэрлэх тухай үзэл дэвшүүлэн гаргасан нь солонгосчуудын тусгаар тогтнолын хөдөлгөөнд ихээхэн дэмжлэг болж байжээ. Шанхай дахь үндэсний удирдагч “Шинэ Солонгосын залуучуудын нам (신한청년당)-ыг байгуулан, Парисын энх тайвны хуралд тусгаар тогтнолын хүсэлт бичгийг төлөөлөгчөөр илгээж байсан ажээ. Мөн Японд сурч буй оюутнууд Токиод “Чосөнъ залуучуудын тусгаар тогтнолын бүлэг”-ийг байгуулж, 1919 оны 2 дугаар сарын 8-нд Тусгаар тогтнолын тунхагийг зарлан тунхаглажээ. Энэ мэдээ дотоодод тарж, улмаар 1919 оны 3 дугаар сарын 1-ний хөдөлгөөн өрнөх нөхцөл бүрдсэн юм.

조총, 鳥銃, **цахиур буу** бол Чосөнъ-ий үеийн биедээ авч явахад зориулагдсан жижиг галт зэвсэг ажээ. Хожим шижмээр асаадаг болсноор цахиур буу хэмээн нэрлэх болжээ.

족보, 族譜, **угийн бичиг** гэдэг нь нэгэн өвөг дээдсээс эхлэн хойч үеийн үр ач нарын угсаа залгамжлалын харилцааг батлан харуулдаг ном бөгөөд, ихэвчлэн “эцгийн талын цусан төрлийнхний нэгдэж нягтрах эд мөрийн үндэслэл”-ийн нэг болж байжээ. Угийн бичиг хөтлөх нь Чосөнъ-ий хожуу үед дэлгэрчээ. Энэ нь эрэгтэй хүний байр сууринаас тэмдэглэдэг байсан бөгөөд, угсаа гарлаа харуулах үндсэн сурвалж болдог байжээ. Чосөнъ улсын ард олны угийн бичиг

нь Хятадын эцгийн талын үр ач нарын үе удмын бичгийн хэлбэрийг үлгэр болгон 15-р зууны үед зохиогдож эхэлжээ. Үе удмын хэлбэрийг харуулах одоо үлдээд байгаа хамгийн эртний угийн бичиг нь 1476 онд хэвлэгдсэн “Аньдон-гийн Квөнъ овогтын Чэнхуа-гийн үед зохиогдсон угийн бичиг” юм. Энэхүү угийн бичиг зохиогдох үеийн буюу түүнээс хойш 17-р зуун хүртэлх угийн бичиг нь эцгийн талын эрэгтэйчүүд төдийгүй эцгийн талын эмэгтэйчүүдийн гэр бүл, улмаар тэдгээр эмэгтэйчүүдийн охин, тэр охиных нь охин гэх мэтээр худ ургийн сүлжээг харуулдаг байжээ. Угийн бичиг нь Чосөнъ улсын гарал угсааны тогтолцоо (신분제) утсаны яг дараа буюу 20-р зууны эхэнд зөвхөн дээд анги давхаргаар хязгаарлагдалгүй, бүхий л давхаргын дунд үе дамжин зохиогдож эхэлсэн бөгөөд, одоо ч гэсэн үргэлжлэн зохиогдсоор байгаа ажээ.

종가, 宗家, өвгийн гэр гэдэг нь нэгэн мүнхжүн (문중)-гийн дотор ахмад хөвгүүдээр залгамжлагдан ирсэн их гэр ажээ. Чосөнъ-ий хожуу үеийн тахилга өвлөх явдал нь ахмад хөвгүүн өвлөх тогтолцоонд шилжсэнээс хойш “өвгийн гэр” нь өвөг дээдсийнхээ тахилга, удам угсаа болон нийгмийн байр суурийг залгамжлан ураг төрлийн бүлгийг нэгтгэх гол төв болжээ. Үүнээс шалтгаалан “өвгийн гэр”-т онцгой эрх мэдэл олгодог байжээ.

좌수영, 左水營, Зүүн хязгаарын усан цэргийн хуаран гэдэг нь Чосөнъ-ий үеийн Чөлла мужийн Йөсүд байрлах зүүн хязгаарын усан цэргийн жанжины байрлах хуаран ажээ.

좌우합작위원회, 左右合作委員會, Баруун, зүүнийхний нэгдсэн хороо – Умард нутгийг Ким Ил сөн атгандаа оруулж, өмнөд хэсэгт бие даасан засгийн газар байгуулах тэмцэл эхлэхэд эх орноо хуваагдахаас эмээсэн алсын хараатай улс төрийн зүтгэлтнүүд баруун зүүний хүчнийг нэгтгэж нэгдсэн засгийн газар байгуулахаар тэмцлээ эхлэжээ. 1946 оны 7 дугаар сарын сүүлээр Ким Гю шиг (김규식) тэргүүтэй барууны таван төлөөлөгч, Йө Үньхйөн (여운형) тэргүүтэй зүүний таван төлөөлөгчөөс бүрдүүлж, “Баруун, зүүнийхний нэгдсэн хороо”-г байгуулсан бөгөөд, тэр жилийнхээ 10 дугаар сард “Баруун, зүүнийхний мөрдөх 7 зарчим”-ыг зарлажээ. Энэхүү зарчмаар өнгөрсөн хугацаанд хамгийн их санал зөрөлдөж ирсэн газрын шинэчлэлт, Японы талд урвагчдын асуудлыг

төвийг сахисан байр сууринаас зохицуулсан нь анхаарал татаж байжээ. 1947 оны 7 дугаар сард Баруун, зүүнийхний нэгдсэн хорооны гол удирдагч Йё Үнь хйён алагджээ. 1947 оны 3 дугаар сараас Америк, Зөвлөлтийн хоорондох хүйтэн дайн эхлэсэн бөгөөд, Америк урьд өмнө хэрэгжүүлж ирсэн баруун, зүүний хүчийг нэгтгэх байр сууриа өөрчилж, эрс хатуу бодлого явуулж эхлэжээ. Америкийн толгойлдог НҮБ-аар Солонгосын асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэхээр болжээ. Ингээд Америк, Зөвлөлтийн нэгдсэн хороо тарж, 1947 оны 12 дугаар сард Баруун зүүнийхний нэгдсэн хороог мөн татан буулгажээ.

주체사상, 主體思想, **чүцэ үзэл** гэдэг нь Ким Ил сөн-ийн үзэл буюу бие даан орших, өөрийнхөөрөө амьдрах үзэл юм. Солонгосын дайны дараа Умард Солонгосын бүхий л эрх мэдэл Ким Ил сөн-ийн гарт орсон бөгөөд, тэрээр дайны дараах хариуцлага, улс орны эдийн засгийн бүтээн байгуулалт нэрийн доор өөрийн бүх өрсөлдөгчдөө устгажээ. 1960 оноос хойш Ким Ил сөн-ийн ганцаар дарангуйлах тогтолцоо улам бэхжих болжээ. Дарангуйллаа улам бэхжүүлэхийн тулд Ким Ил сөн өөрийн “чүцэ” үзлийг гаргаж тавьсан нь Зөвлөлтийн нөлөөнөөс ангижрах зорилготой байжээ. 1967 оны 12-р сард Ардын Их Хуралд тавьсан илтгэлдээ дотоод, гадаад бодлогын үндсэн чиг шугамыг тодорхойлж, түүнийгээ "чүцэ" гэж нэрлэжээ. Улс төрийн хувьд тусгаар, эдийн засгийн хувьд бие даасан байдлаа бэхжүүлж, дотоодын хүчээр улс орноо батлан хамгаалах болно гэж заасан бөгөөд үүнээс хойш Ким Ил сөн-ийн эрх мэдэл улам ч ихэсчээ. Ким Ил сөн “чүцэ” үзлийг Умард Солонгосын бүхий л төрийн бодлогод тусган оруулж, 1972 онд Үндсэн хуулиа өөрчлөн, төрд тэргүүлэх байр суурьтай болгон өөрийн ноёрхлоо хуулиар баталгаажуулжээ. Үүний дараа Ким Ил сөн өөрийн хүү Ким Чөнил (김정일) -ийг залгамжлагчаар товлон, төрийн тэргүүний суудлыг үе залгамжлан өвлүүлдэг болжээ. 1994 онд Ким Ил сөн нас барж, хүү Ким Чөнил төрийн эрхийг гартаа авжээ. Харин 2011 онд Ким Чөнил нас барсны дараа түүний хүү Ким Ченынь (김정은) эрх мэдлийг нь залгамжилжээ.

중인, 中人, **чүнинь буюу дунд хүн**: Чосөнъ улсын хаан улсаа удирдахын тулд ард түмэнд тавих хяналтыг сайжруулах ёстой гэж үзэн ард иргэдэд нийгмийн зэрэг

тогтоож, энгийн ардыг дотор нь янбань (양반), чүнинь буюу дунд хүн, санминь (상민) буюу эгэл ард гэж гурав хуваадаг байжээ. Харин харц ард гэдэгт боол, тусгай хүмүүс болох харц боолоос ялгаагүй мал нядлагч, бөө, шивэгчин, дуучин, жүжигчид багтдаг байжээ. Дунд хүн (중인) нь ноёлогч давхаргад багтдаг хэдий ч янбаньчуудаас доогуур зэрэгтэй бөгөөд, тэд янбаньчуудад туслан, өөрсдийн давхаргын хүмүүсийг удирдах үүргийг гүйцэтгэдэг байжээ. Тэд ихэнхдээ төрийн төв байгууллагад доогуур алба хаших, мэргэжлийн түшмэл, орон нутгийн ахлагч хийдэг байжээ. Янбаньчууд өөрсдийн эрх мэдлээ дангаар эзэмшихийн тулд дунд хүн давхаргын хүмүүсийг өндөр албанд дэвшихийг хязгаарладаг байжээ.

중종반정, 中宗反正, **Чүнжон-ы эргэлт** гэдэг нь Йёнъсань гүнъ (연산군)-ийг хаан ширээнээс буулгаж, Чүнжон (중종) ван хаан болсон хэрэг явдлыг нэрлэдэг ажээ. Сөнжон (성종) вангийн дараа хаан ширээнд суусан Йёнъсань гүнъ түшмэдийн эрх мэдлийг хасаж, хааны бүрэн эрхийг сэргээжээ. Йёнъсань гүнъ хааны эрх мэдлээр далайлган удирдсаар байсан явдалд сайд, түшмэд хүчтэй эсэргүүцэж, түүнийг хаан ширээнээс буулгаж Чүнжон ван шинэ төр байгуулан хаан болжээ.

중추원, 中樞院, **Төв зөвлөл** гэдэг нь Японы колончлолын үед Япончууд Ерөнхийлөн захирах яамны хавсарга яам болгож байгуулсан байгууллага ажээ. Төв зөвлөлийн сайд нь япон хүн бөгөөд, дэд сайд болон гишүүдээр нь И Вань ён тэргүүтэй улсаа худалдагсдыг томилжээ. Ерөнхийлөн захирагчийн асууж зөвлөсөн зүйлийн талаар хэлэлцэж, санал тавих эрхтэй байгууллага гэж хэлж байсан ч үнэндээ улс төр, эдийн засаг зэрэг улс орны чухал асуудлын талаар тэдэнд хэзээ ч хандаж байгаагүйгээс үзэхэд солонгос хүний улс төрд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх байгууллага мэтээр харагдуулах гэсэн нэр төдий яам байсан гэдэг нь тодорхой байжээ.

직전법, 職田法, **Албан тушаал эрхлэгчдэд газар олгох хууль** гэдэг нь Чосөн-ий үед албан тушаал эрхэлж буй тушаалтнуудад л газар олгохоор заасан хууль ажээ. 1466 онд Түшмэлд газар соёрхох тухай хуулинд өөрчлөлт оруулсан ба төв суурин газар дахь газрын хэмжээ багассантай холбогдуулан албан тушаал

эрхэлж буй тушаалтанд хэмжээг багасгаж олгохоор заасныг хожим хүчингүй болгожээ.

진경산수화, 眞景山水畵, **Чиньгйөн байгалийн зураг** нь Солонгосын уул, ус, гол, горхи зэрэг байгалийн үзэсгэлэнг бодитоор илэрхийлсэн цоо шинэ урсгалын зураг бөгөөд, бодит уул усны зургаас гадна хүмүүсийн ахуй амьдралыг дүрсэлсэн зан заншилтай холбоотой зураг ч байдаг ажээ. Чиньгйөн байгалийн зургийн нэрт зураач Чөн Сөнъ (정선) нь “Инъван уулын зураг (인왕제색도)” болон “Кымган уулын зураг (금강전도)”-гаа Инъван уул, Кымган уулыг яг л бодит мэт дүрсэлжээ.

집현전, 集賢殿, **Мэргэдийн өргөө** гэдэг нь Чосөнъ-ий Сэжон (세종) вангийн үед хааны ордонд байгуулагдсан эрдэм шинжилгээний хүрээлэн ажээ. Энэ нь Корйё улсын үед нэр төдий байсан бол 1420 онд Сэжон ван жинхэнэ эрдэм шинжилгээний хүрээлэн болгож, эртний сонгодог уран зохиол, хууль цааз, төрийн тогтолцоо судлах шилдэг эрдэмтэн мэргэдийг цуглуулсан газар болжээ. Мэргэдийн өргөөний эрдэмтдээр авиалбарыг судлуулж, солонгос хэл яриаг илэрхийлэхэд тохиромжтой Хүнъминъжёным (훈민정음) үсгийг зохиосон бөгөөд, энэ хүрээлэнгээс төрөл бүрийн ном зохион гаргаж соёлын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулжээ.

척화비, 斥和碑, **эв нэгдлийг эсэргүүцсэн хөшөө** нь Чосөнъ-ий үед Кожон вангийн эцэг Хынсөнъ-ий европ хүмүүсийг гадуурхан нийслэл болон орон нутгуудад босгосон чулуун хөшөө бөгөөд, хөшөөн дээр “Довтлон ирсэн европ хүмүүстэй дотносож болохгүй” гэж бичжээ.

천진조약, 天津條約, **Тяньжины гэрээ** нь 1885 онд Солонгос дахь цэргээ татан авах тухай Япон болон Хятадын Чин улсын хооронд байгуулсан гэрээ юм. →텐진 조약 (Tianjin 條約)

천추사, 千秋使, **чхөнъчхү элч** гэдэг нь Чосөнъ-ий үед жил бүр ёс болгон Хятадын Мин улсад хунтайжийн мэндэлсний баяр хүргэж, өргөн барих бэлгийн хамт илгээдэг 40 хүний дагуул бүхий элчийг нэрийддэг байжээ. →하성절사 (賀聖節使), 하천추사(賀千秋使)

청구도, 靑邱圖, **Чхөнгү газрын зураг** гэдэг нь 1834 онд Чосөн улсын Ким Чөнхо

김정호(金正浩) гэдэг хүний хийсэн Солонгосын газрын зураг юм. Энэхүү газрын зураг нь босоо, хэвтээ шугамыг оруулан хийсэн шинэ загварын газрын зураг билээ. Өөрөөр “Чхөнгүсөнхпхйо газрын зураг 청구선표도(靑邱線表圖)” ч гэж нэрлэдэг. Энэ зураг нь БНСУ-ын 1594 дугаартай ховор эд зүйлээр бүртгэгджээ. Одоо хадгалагдаж байгаа эртний газрын зургуудаас хамгийн том хэмжээтэй нь бөгөөд, өргөн нь 462 см, урт нь 870 см, масштаб нь ойролцоогоор 1:216,000 юм. Эртний газрын зургууд дотроо тодорхой хэмжээний газар нутгаар хуваагдсан зураг бөгөөд, масштаб ижил улсуудын газрын зурагтай харьцуулвал хамгийн нарийвчлалтай зураг гэгддэг. Хожим энэхүү газрын зурагны өнгөт гар бичмэлд тулгуурлан “Тайдунйөжиду (대동여지도)” (Зүүн гүрний нэгдсэн газрын зураг)-ийг хийжээ. Эдүгээ энэ 2 ном улсын төв номын сан болон Корйө их сургуулийн номын санд хадгалагдаж байна.

청일전쟁, 淸日戰爭, **Чин улс Япон улс хоорондын дайн** нь 1894 онд Чосөн-ий дорнын суртлынхан (동학) болон тариачид хөдөлгөөн гаргасны улмаас Хятадын Чин улс болон Япон улсын хооронд дайн гарчээ. Энэ дайнд Япон улс ялж Чин улс ялагдсан ажээ. Асань (아산)-ы буланд болсон энэ дайнд шилдэг цэрэг, зэвсэгтэй Япон улс хялбархан ялалт байгуулжээ. Японы Шимоносеки-д хоёр улс хэлэлцээр хийж, Чин улс Ляодуны хойг (요동반도) болоод Тайвань (대만)-ыг Японд өгөхөөр болжээ. Үүгээр Япон улс эх газар руу өнгөлзөж түрэмгийлэх санаархал нь биелэж эхэлжээ. Чин улс Япон улс хоорондын дайнд ялалт байгуулсныхаа дараа Японы тал Иноүэ Каорү-г онц, бүрэн эрхт элчин сайдаар илгээж Чосөн-ий дотоод хэрэгт шууд оролцож эхэлсэн ажээ.

총독, 總督, 1. **амбан сайд** – Колони улсыг захирах газрын тэргүүн. 2. **ерөнхийлөн захирагч** – Хятадын Мин, Чин улсын үед хотын бүх хэрэг, цэргийг захирагч.

총독, 總督, **Ерөнхийлөн захирагч**: Япон улс колоничлох бодлогоо хэрэгжүүлэхийн тулд Төлөөний сайдын оронд Ерөнхийлөн захирагч томилж, Ерөнхийлөн захирах яам байгуулжээ. Ерөнхийлөн захирагчийг Японы

цэргийн генералуудаас сонгон томилсон ба Хань улсын хууль тогтоох, засаг захиргаа, шүүх засаглал, цэргийн бүхий л эрхийг атгаж байв. Анхны Ерөнхийлөн захирагч Тэраучи-гийн засаглал туйлын хатуу, хүчирхийллийн арга барил дээр тулгуурлаж байсан бөгөөд, дэг журам чандлан сахихыг тушааж, тушаалаа хэрэгжүүлэхийн тулд харгис цэрэг, цагдаагийн журам тогтоожээ. Энэ журмаар Хань улс дахь Японы цэргийн ерөнхий захирагч Сөүл хотын цагдаагийн даргын ажлыг төдийгүй мужийн цагдаагийн дарга, мужийн цэргийн захирагчийн үүргийг тус тус хавсран гүйцэтгэх болжээ. Ингэж харгис цагдаагийн дэглэм тогтсоноор солонгос хүний хэлсэн дэл сул үгийнх нь төлөө ч хатуу цээрлүүлэх болж, 1912 онд тавин мянга гаруй, 1918 онд зуун дөчин мянга гаруй хүнийг хомроглон баривчилж хорьжээ.

총독부, 總督府, Амбан сайдын ерөнхий газар – Японы колонийн үе буюу 1910-1945 оны хооронд 36 жилийн туршид солонгос иргэдийг захиран, тодорхой бүс нутгийн бүхий л үйл ажиллагааг захиран хариуцаж байсан газар ажээ.

최제우, 崔濟愚, Чхой Жэ-ү (1824~1864) нь Дорнын суртлыг үндэслэгч тэрээр “Дорнын сурталын их судар”, “Йондам йүса” номуудыг эмхэтгэн гаргасан ба хожим садо нарын самуунаар баривчлагдан цаазаар авахуулжээ.

춘향전, 春香傳, Чхунъ хйан-ы тухай үлгэр бол Чосөн-ий Йөнжо, Чөнжо хаадын үед зохиогдсон панъсори хэлбэртэй эртний зохиол бөгөөд зохиогч нь тодорхой биш юм. Намвон-ий захирагчийн хүү И Мон нйон, дууч бүсгүй асан Велмай-гийн охин Сөн Чхунъ хйан хоёрын үнэнч хайр сэтгэлийг өгүүлсэн тус үлгэрээр тухайн үеийн нийгмийн онцгой эрх мэдэлтнүүдийн дур зоргоороо авирлаж, харц ардын нийгмийн байдал дээшилж буй тухай харуулжээ. →열녀춘향수절가(烈女春香守節歌)

칠정산, 七政算, Чхилжонсанъ цаг тооны бичиг бол Сэжон вангийн үед зохиогдсон бөгөөд, өөрийн улс оронд тохирсон зурхайн арга ухаан гэдгээрээ ач холбогдолтой ажээ. Үүнийг бүтээхийн өмнө Хятадын зурхайн ухааныг хэрэглэж байсан ба Хятад, Солонгосын газарзүйн байрлал өөр учраас таардаггүй байжээ. Хятад, Арабаас гаргасан цаг тооллын бичигт тулгуурлан

тэнгэрийн хөдөлгөөнийг Солонгосын хэм хэмжүүрээр нарийн тооцоолдог Чхилжёнсанъ нь долоон одыг тооцох буюу нар, сар, буд, сугар, ангараг, бархасбадь, санчир гарагийн хөдөлгөөнийг тогтоон өдөр хоногийг тооцдог байжээ.

탕평책, 蕩平策, Тхайнпйөн бодлого гэдэг нь нам, бүлэг бүрт ижил тэнцүү хандах

бодлого бөгөөд, 17-р зууны дунд үед нам, бүлгийн хоорондох зөрчил ширүүсч элдэв маргаан үүсэж дангаар ноёрхох нам бүлэг гарч ирснээр хааны эрх мэдэл буурчээ. Үүнийг шийдвэрлэхийн тулд нэг намд эрх мэдлийг төвлөрүүлэлгүй Тхайнпйөн төрийн бодлогыг хэрэгжүүлжээ. Ялангуяа Йёнжо болон Чёнжо ван уг бодлогыг хэрэгжүүлж улс төрийн аюулгүй байдлыг хамгаалан хааны эрх мэдлийг бэхжүүлэх гэж оролджээ. Тхайнпйөн төрийн бодлогын ачаар нам, бүлгийн асуудал намжиж, соёл иргэншил хөгжих болжээ. Гэвч тэр үеийн Тхайнпйөн бодлого нь нам, бүлгийн зөрчлийг үндсээр нь шийдсэн гэж хэлэхээс илүү хааны сүр хүчээр нам, бүлгийнхнийг түр сааруулсан гэж үздэг ажээ.

택리지, 擇里志, Газарзүйн ойллого хэмээх энэхүү номыг Чосөнъ улсын хожуу

үеийн шилхаг судлал (실학)-ын эрдэмтэн И Чүн хванъ (이중환) туурвисан бөгөөд, Солонгос орны бүс нутаг тус бүрийн байгаль орчин, хүн ам, ёс заншил зэргийг нарийн тусгасан газарзүйн ном юм. Уг номонд нутаг дэвсгэрийг найман муж буюу до (도)-д хуваан, тус бүрийн байгаль, хүн ард, ёс, зан заншлын онцлогийг тусгахаас гадна хүний амьдрах боломжтой газар нутгийг газарзүй, аж амьдрал, хүмүүний сэтгэл, байгалийн үзэмж цогцолсон байдлаар зааж өгчээ. Ялангуяа аж төрөхөд таатай газар нутаг болон үржил шимтэй, худалдаа наймаа, бараа таваар, тээвэр хийх тохиромжтой гол бүс нутгийг онцолсноор шилхаг судлалын газарзүйн өргөн мэдлэгийг илтгэн харуулсан ном болжээ.

토지개혁, 土地改革, газрын шинэчлэл – Газрын эзэмшлийн хэлбэрийг өөрчлөх ажил.

토지조사국, 土地調査局, **газрын судалгаа хариуцсан алба** - Японы Амбан сайдын ерөнхий газраас Чосөнъ улсын газар нутгийг булаан авах зорилготой байгуулсан байгууллага.

토지조사령, 土地調査令, **газрын судалгааны ажлын тухай хууль** гэдэг нь Японы империализмын үед 1912 онд батлагдсан Газрын судалгааны ажлын тухай хууль юм.

토지조사사업, 土地調査事業, **газрын судалгааны төсөл** гэдэг нь 1910-1918 онд Япон улс Солонгос улсын газар нутгийг булаан авах зорилготой зохион байгуулсан газар тариалангийн зориулалт бүхий газрыг судлах өргөн хүрээний компанит ажил юм. 1910 оноос бэлтгэл ажлаа эхлүүлсэн бөгөөд, 1912-1918 оны хооронд гол үйл ажиллагаагаа хэрэгжүүлжээ. Энэхүү Газрын судалгааны төслийн ажлаар дамжуулан Японы империалистууд тариаланчдаас газрыг нь хууль бусаар булаан авч байжээ.

통감부, 統監府, **Хянан захирах яам** нь 1906 онд Сөүл хотод Японы империализм Их Ханъ эзэнт улсын энх тайван, сайн сайхан байдлыг сахин хамгаалах нэрийдлээр байгуулсан удирдах байгууллагыг хэлдэг ажээ. Тус байгууллага нь 1906 оны 2-р сард байгуулагдсан бөгөөд тусгаар тогтнолоо алдаж, Японы ерөнхий засгийн газар байгуулагдах хүртэл (1910 оны 8-р сар) дөрвөн жил зургаан сарын турш Солонгосын засгийн газрын бүхий л салбарыг хянаж, колончлолын дэглэмд бэлтгэж байсан эрх бүхий байгууллага ажээ.

퇴계 이황, 退溪 李滉, **Тхойге И Хван** (1501-1570) бол Солонгосын гүн ухаантан, зохиолч бөгөөд, Чосөнъ улсын үеийн хүнзийн суртал судлаач ажээ. Түүнийг Солонгосын хамгийн нэртэй философич гэж үздэг бөгөөд, Солонгосын мөнгөн тэмдэгтийн 1000 воны дэвсгэртийн нүүрэн талд түүний хөрөг зураг, харин ар талд нь түүний байгуулсан Тосанъ бичгийн өргөө (도산서당)-ийн зураг байдаг ажээ. Түүний поньгванъ буюу овог нь Чиньбо (진보), цол (호) нь Тхойге (퇴계) болой. И Хван нь Чүжа-гийн шинэ хүнзийн суртал (주자성리학)-ыг гүнзгийрүүлэн хөгжүүлж, Чосөнъ-ий хожуу үеийн Йённам-ын урсгал (영남학파)-ын онолын үндэс суурийг бий болгожээ. И Хван нь 12 настайдаа бага авгаасаа “Шүүмжлэлт өгүүлэл”-ийг сурсан агаад 20-оод настайдаа шинэ

хүнзийн сурталд хамаг анхаарлаа хандуулах болжээ. 1527 онд орогсдын шалгалтын эхний шатанд тэнцэж, 1534 онд бичгийн түшмэлийн шалгалтанд тэнцэж улмаар төвийн олон албан тушаалд ажиллаж байжээ. 1560 онд Тосань бичгийн өргөө (도산서당)-г барьж, түүнээс хойш 7 жилийн турш ном унших, эрдэм сурах, зохиол туурвих ажилд бүхий л анхаарлаа хандуулахын зэрэгцээ олон шавь нарыг төрүүлжээ. Тэрбээр шинэ хүнзийн сурталтай холбоотой олон ном зохиол туурвиж, 1570 онд өвчний улмаас 70 настайдаа өөд болжээ.

팔도, 八道, найман муж бол Чосөн-ий үеийн нийтдээ найман засаг захиргааны нэгжид хуваан нэрийдсэн Кйёнги, Чхүнчхөн, Кйёнсан, Чёлла, Канвонь, Хванхай, Пхйён-ань, Хамгйён мужууд ажээ.

포도청, 捕盜廳, (the police bureau) Цагдаагийн газар – Чосөн-ий үеийн Ханьсөнбү, Кйёнги мужуудын амар тайван байдлыг сахиулах газар юм. Ханьсөн, Кйёнги мужуудыг зүүн, баруун аймагт хуваахтай холбогдуулан тус газрыг Зүүн товчоо, Баруун товчоо гэж хоёр хуваажээ.

하나회, 壹會, 一會, Hanahoe, Group of One, Ханахой бүлэглэл нь армид нэр нөлөө, эрх мэдлээ бэхжүүлэх зорилгоор Жөн Дү хван генералаар толгойлуулсан дээд тушаалын офицеруудын байгуулсан бүлэглэл бөгөөд “Хана” гэдэг нь нэг гэсэн утгатай үг учир бүгдээр нэг зорилгын төлөө нэгдэнэ хэмээн бүлэглэлээ ийнхүү нэрлэжээ. 1979 оны 12 дугаар сарын 12 өдрийн цэргийн эргэлтийг энэ бүлэглэл толгойлсон ажээ.

한국 전쟁, 6.25 전쟁, 六二五戰爭, Korean War: Солонгосын дайн нь 1950 оны 6 дугаар сарын 25 өдрийн үүрийн 04 цагт Умард Солонгос Өмнөд Солонгос руу гэнэтийн дайралт хийж дайныг өдөөснөөр эхэлсэн дайн юм. Умард Солонгосын энэхүү дайралтад Хятад улсын цэргийн арми тусалжээ. НҮБ-ийн арми болон Хятадын арми дайнд оролцох болсноор дайны цар хүрээ дэлхийн хэмжээний болж томорсон учир 1953 оны 7 дугаар сарын 27 өдрийн 22 цагт байгуулсан “Дайны гал түр зогсоох хэлэлцээр”-ийн дагуу эхний ээлжинд дайныг дуусгажээ. Дайны гал түр зогсоох гэрээ хийснээс хойш хоёр улсын орших уу эс орших уу гэх зөрчил өнөөг хүртэл үргэлжилсээр байна. Дэлхийн

2-р дайны дараа коммунизм болон коммунизмыг эсэргүүцэх хоёр хүчтэй зөрчилдөөнөөс үүдэлтэй дэлхийн хүйтэн дайн эхэлсэн бөгөөд, хүйтэн дайны үед ч хоёр улс зөрчилдсөн хэвээр байсны нэг жишээ нь нэг талыг хамарсан дайны үед нийтийг хамарсан дайн гэх ээдрээтэй үзэл, шинж чанартай байсантай холбоотой байжээ. Энэ дайн бол Олон улсын холбоотны цэргүүд болон эмчилгээний багаас эхлээд БНХАУ болон ЗХУ хүртэл оролцсон дэлхийн 2-р дайны дараах хамгийн том дайн байв. Энэ дайн эхлэхээс өмнө БНХАУ-ын Мао Зэдун (마오쩌둥) болон ЗХУ-ын Иосиф Сталин (이오시프 스탈린) нарын тохиролцоонд дэмжлэг олж авсан Ким Ил сөн (김일성) 1950 оны 6 дугаар сарын 25 өдрийн үүрийн 04 цагийн үед 38-р өргөрөг болон Зүүн тэнгис дагуух зурвас газар зэргийн 11 газарт хил даван дайн зарлаж буйгаа мэдэгдэлгүйгээр 38-р өргөрөгийн өмнөд бүсийн нутагт дайралт хийжээ. Умард Солонгосын цэргийн армийн хүчтэй дайралтад Нэгдсэн Үндэсний Байгууллага АНУ-ыг гол хүчин болгон Аюулгүй байдлаа бататгах удирдах зөвлөлийн хурал зарлаж 82-р шийдвэрийг гаргаж энэ дайнд Өмнөд Солонгост туслах шийдвэр гаргаж цэрэг илгээжээ. Ийнхүү 7 дугаар сарын 7 өдөр маршал Дуглас Макартур (더글러스 맥아더)-ыг ерөнхий командлагчаар томилж НҮБ-ийн цэргийн армийг удирдуулжээ. Өмнөд Солонгосын арми хамгаалах зэр зэвсэггүй болсон байсан тэр үед НҮБ-ийн арми төвийн болон баруун өмнөд нутгийг хэдхэн цагт хаман авжээ. Холбоотны цэргүүд Нагдон гол (낙동강)-ын хамгаалалтын шугамаас гол устай газар барьсан цэргийн хуаран хүртэлх шийдвэрлэх тулаанд оролцож байжээ. Холбоотны цэргүүд Дуглас Макартурыг 9 дүгээр сарын 15 өдөр Инъчхөн (인천)-д буух тактикт ажиллагааны өдрөөс эхлэн томоохон сөрөг довтолгоонтой нүүр тулсан бөгөөд, 10 дугаар сарын 10 өдөр Пхйөнян (평양)-д үргэлжилж Ялу мөрний (압록강) ойролцоох газар хүртэл сөрөг цохилтод өртөж байжээ. 11 дүгээр сарын дундуур Хятадын арми оролцож өмнөх байдал дахин өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 1 дүгээр сарын 4 өдөр Хөэсанжин (혜산진) хүртэл дайралт

хийж байсан цэргүүд Сөүл хотыг булаан эзэлжээ. Энэ өдрийг түүхэнд 1.4 ухралт гэж нэрлэдэг байна. Гэвч эцэст нь шийдвэр гарахад хүрчээ. 1953 оны 7 дугаар сарын 27 өдөр оройн 22 цагт байгуулсан “Дайны галыг түр зогсоох хэлэлцээр”-ийн дагуу Солонгосын хойгийн цэргийн хилийн зааг тавьснаар дайн түр зогсжээ. Одоо хүртэл бичиг баримт дээр дайны галыг түр зогсоосон хэмээсэн байдаг бөгөөд, хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш Умард болон Өмнөд Солонгос хоёр улсын хооронд цэрэг армийн том жижиг зөрчлүүд үргэлж гарсаар байна.

한국정신문화연구원, 韓國精神文化研究院, Солонгосын Оюуны Соёл Судлалын

Төв – Паг Жөн хый-гийн засгийн газар Солонгос судлалын төв болон дээд боловсролтой боловсон хүчний сургалтын байгууллага болох “Солонгосын Оюуны Соёл Судлалын Төв”-ийг 1978 онд Кйёнги муж (경기도)-ийн Сөннам хот (성남시)-д байгуулжээ. Уг төвөөс арав гаруй жилийн шургуу хөдөлмөрийн эцэст 27 боть бүхий “Солонгосын үндэсний соёлын их тайлбар толь бичиг (한국민족문화 대백과사전; 1988-1991)”-ийг гаргажээ. Энэхүү тайлбар толь болон Улсын түүх бичлэгийн хорооноос 1978 онд гаргасан 24 боть “Солонгосын түүх (한국사)” зэрэг бүтээлүүдийг Паг Жөн хый-гийн засаглалын үеийн эрдэм шинжилгээ, соёлын том бүтээлд тооцдог ажээ. “Солонгосын Оюуны Соёл Судлалын Төв” нь 2005 онд “Солонгос Судлалын Төв Хүрээлэн (한국학중앙연구원)” гэж нэрээ өөрчилжээ.

한글학회, 韓契學會, Ханьгыл судалгааны нийгэмлэг –1921 онд Жү Ши гйөн

(주시경)-ий шавь нарын байгуулсан “Чосөнъ хэл судлалын нийгэмлэг (조선어학회)” нь солонгос хэл судлалыг хөгжүүлэхэд гол үүргийг гүйцэтгэж байсан бөгөөд, “Чосөнъ хэл судлалын нийгэмлэг (조선어학회)” нь 1931 онд “Чосөнъ хэлний нийгэмлэг”, 1949 онд Ханьгыл судалгааны нийгэмлэг (한글학회) хэмээн нэрээ тус тус өөрчилжээ. Ханьгыл судалгааны нийгэмлэгийг И Юн жай (이운재), И Гыг ро (이극로), Цой Хёнъ бай (최현배), Ким Юнь гйөн (김윤경) нарын эрдэмтэд голлож байсан бөгөөд, уг нийгэмлэгээс “Ханьгыл” нэртэй сэтгүүл гаргаж, эх хэлээ хайрлаж хадгалахыг

чармайхын зэрэгцээ солонгос хэлний их тайлбар толь бичих гаргахаар төлөвлөж түүний бэлтгэл ажлын хүрээнд зөв бичих дүрмийг шинэчлэх, төв аялгууг цэвэр тунгалаг байлгах, гадаад үгийн галигийг нэг мөр болгон цэгцлэх зэргээр асар их бүтээл туурвиж солонгос хэлний судлалд их гавъяа байгуулжээ. Мөн “ханьгыл” үсгийг зохиосон өдрийг “Ханьгыл үсгийн өдөр” болгон жил бүр тэмдэглэх зэргээр үндэсний соёлоо ард иргэддээ таниулж сурталчлах талаар ч их зүйл хийжээ.

한성조보, 漢城周報, **Ханьсөн жобо** сонин – Хөх бичин жилийн төрийн эргэлт хийх оролдлогыг дарсны дараа Кожон ван болон Минъ хатны талынхан аажуу тайван шинэчлэлт хийх хуучин бодлогоо үргэлжлүүлжээ. Кожон ван боловсрол, хэвлэл мэдээлэл болон бусад салбаруудад гэгээрүүлэх бодлогоо хэрэгжүүлжээ. 1883 онд анх хэвлүүлж эхэлсэн “Ханьсөн сүнъбо (한성순보)” сониныг 1886 оноос “Ханьсөн жобо (한성조보)” нэртэйгээр долоо хоног тутмын сонин болгож өөрчилжээ. Энэхүү сонин нь шинэ үеийн үзэл суртал дэлгэрүүлэх, дэлхийн олон орны байдлыг танилцуулах зорилготой байжээ.

한성회의소, 漢城商業會議所, **Ханьсөн-ий худалдааны ордон**: Орос Японы дайн дэгдмэгц, Японы халдан түрэмгийлэл идэвхжсэн болон санхүүгийн зөвлөх Мекада-гийн явуулсан мөнгөний шинэчлэлтийн улмаас Хань улсын худалдааны салбар хүнд хямралд орсон тухайн үед Сөүл хотын худалдаачид хүндрэл бэрхшээлээс гарах арга зам эрж хайх, эрх ашгаа хамгаалахын тулд 1905 онд Ханьсөн-ий худалдааны ордонг байгуулжээ. Гэвч Японы колончлолд орсны дараа Ханьсөний худалдааны ордоны үйл ажиллагаа зогсож, солонгос худалдаачид япон хүний удирдлаган дахь (경성회의소)- д нэгдэн орохоос өөр замгүй болсон ажээ.

한양, 漢陽, **Хань-йан** хот бол Чосөнъ улсын нийслэл бөгөөд одоогийн Сөүл хотын хуучин нэр ажээ. Чосөнъ улс байгуулагдаад 3 дахь жилдээ буюу 1394 онд нийслэлээ Хань-йөн хот руу шилжүүлсэн нь шинэ улс өөрийн улсыг захирах үзэл санаагаа бахархан харуулах төлөвлөгөөтэй энэ газар хотоо босгосон гэдэг ажээ. Тухайн үеийн газарзүйн талаарх үзэл санааныхаа дагуу олон уулсаар

хүрээлэгдсэн Хан мөрний хойно байрлах уудам зайд 18 км орчим цайз хэрэм хүрээлүүлэн босгож, түүний дотор хааны амьдрах том хэмжээний ордон, түшмэлүүд ажиллах албан газруудын хороолол, зуун мянган орчим хүн амьдрах ардуудын суурьших бүс болон захуудыг байгуулжээ. Энэ үеэс эхлэн Сөүл хот одоог хүртэл 600 жилийн турш Солонгос улсын нийслэл хэвээр байсаар иржээ.

한일협약, 韓日協約, Солонгос, Японы гэрээ гэдэг нь 1904 онд байгуулсан, Хань улсад гадаад харилцаа, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхээр Японы засгийн газраас томилсон гадаад эсвэл япон хүнийг зөвлөхөөр томилох, Япон улсын зөвшөөрөлгүй өөр бусад гадаад улс оронтой гэрээ хэлэлцээр хийхгүй байхыг заах зэрэг Япон улсаас Солонгос улсын гадаад харилцаа, эдийн засгийн эрхийг хөндсөн агуулга бүхий гэрээ ажээ.

한일협정서, 次韓日協約, Хань, Японы зөвшилцлийн баримт бичиг: Япон улс Хань улсын төрийн хэрэгт оролцох зорилготойгоор 1904 оны 8-р сард энэхүү баримт бичигт гарын үсэг зурснаар биелэлээ олжээ. Ингээд Хань улс, Японоос санхүүгийн зөвлөх япон хүн урьж, улсын санхүүтэй холбоотой бүх асуудлыг түүнтэй зөвлөж хэлэлцсэний дараа хэрэгжүүлэх, бас Японы санал болгосон гадаадын нэг хүнийг гадаад бодлогын зөвлөхөөр урьж, гадаад улстай гэрээ хэлцэл хийх зэрэг чухал асуудлыг хамтран шийдвэрлэж байхаар болжээ.

향약, 鄉約, Хяняг буюу тосгоны журам гэдэг нь сарим сэхээтнүүд хөдөө тосгонд хүч нөлөөгөө нэмж, хүнзийн суртлыг түгээхийн тулд байгуулсан журам юм. Газар бүр өөр боловч “сайныг дэмжих, муугаас салах” хэмээх хүнзийн суртлын ёс заншлыг нарийн чанд биелүүлэн хэцүү бэрхийг хамтран даван туулна гэсэн утга агуулсан журам юм. Хяняг журам нь үндсэн уламжлал бүхий тосгоны бүтэц, зөв ёс журмын 3 дүрэм, 5 ёсыг баримтлахаас гадна хүнзийн ёс суртахууныг нэгтгэсэн журам ажээ. Орон нутгийн хүмүүс хяняг журмыг эхлээд күнь, хйөнъ, тосгодуудад байгуулан хэрэгжүүлж байсан бөгөөд, аажмаар улс даяар түгэн дэлгэрчээ. Хяняг журам нь ёс заншлын шинэчлэл төдий бус, хөдөө тосгон дахь өөртөө засах эрх бүхий орон нутгийн

сарим сэхээтний байр суурийг бататгаж байсан бол нөгөөтэйгүүр зарим нутгийн хөрөнгө чинээтэй эрх мэдэлтнүүд хяняг журмаар дамжуулан тариачдыг айлган сүрдүүлэх, дээрэмдэх зэрэг сөрөг нөлөө ч гарч байжээ.

향약집성방, 鄉藥集成方, “**Ардын анагаах аргын түүвэр**” гэдэг нь Чосөн-ий үеийн 1433 онд Сэжон вангийн зарлигаар эмийн ургамал, эмчилгээний аргын тайлбар номуудыг үндэслэн гаргасан 85 боть 30 ном бүхий анагаахын ухааны ном бөгөөд уг номонд өвчний шинж тэмдэг, анагаах арга, зүү тавих арга, эмийн ургамлын төрөл зүйл, тэдгээрийг хэрэглэх аргыг дэлгэрэнгүй дурьджээ.

향청, 鄉廳, **хйанчөн нутгийн зөвлөл** – Чосөн-ий үеийн орон нутаг мужийн захиргаа хариуцсан байгууллага. →유향소(留鄉所)

허균, 許筠, **Хө Гйүнъ** (1569~1618) бол Чосөн-ий үеийн бичгийн түшмэл, зохиолч бөгөөд, тэрбээр цаг үеэсээ түрүүлж явсан шинэчлэгч байжээ.

허생전, 許生傳, **Хө Сайн-ы тухай үлгэр** гэдэг нь Чосөн-ий үед Паг Жи вөн-ий нанхиад үсгээр туурвисан богино хэмжээний үргэлжилсэн үгийн зохиол бөгөөд, ядуу билгүүн номч Хө Сайн-ы худалдаа наймаа хийж буй дүрслэлээр тухайн үеийн улс орны эдийн засгийн сул дорой байдал, янбань язгууртнуудын хоосон дүр төрхийг уг номонд шүүмжлэн дүрсэлжээ.

헌병경찰통치, 憲兵警察統治, **армийн цагдаагаар захирах** - Японы империализмын дарангуйллын нэг хэлбэр бөгөөд 1910 онд улсын эрхийг хүчээр булаан авсан Япон улс нь солонгос иргэдийг захирахын тулд энгийн албан тушаалтан бус цэргүүдийг дайчилжээ. Тухайлбал, Чосөн дахь Амбан сайдын ерөнхий газрын даргаар японы явган цэргийн жанжныг томилж байсан тул үнэн хэрэгтээ Солонгос улсыг цэргүүд удирдаж байжээ.

현량과, 賢良科, **мөс шалгаруулах түшмэдийн шалгалт** гэдэг нь Чосөн-ий 11 дэх их хаан Чүнжон вангийн үед Жо Гванжо нарын саналаар хэрэгжүүлэх болсон албат түшмэдийг томилох тогтолцоо ажээ. →기묘천과(己卯薦科)

호패, 號牌, **пайз** нь Чосөн-ий үед 16-с дээш насны эрэгтэй хүний нийгмийн байр суурийг илтгэх, биедээ авч явдаг пайз ажээ.

호패법, 號牌法, **Пайзын хууль** нь Чосөн-ий үед 16-с дээш насны эрэгтэй хүмүүсийг биедээ пайз авч явахыг шаардсан тогтолцоо ажээ. Пайзын тогтолцоо нь ажил мэргэжил, зэрэг дэвээр нь нийгмийн гарал үүслийг ялган тогтоож, цэргийн болон бусад алба гүйцэтгэгчийг зөв олж таних зорилготой байжээ.

환곡, 還穀, **зээлийн буудай** нь Чосөн-ий үед хөдөө тосгонд ургац тааруу жил ядуу ардад тариа буудайг зээлээр өгч, ургац авах үеэр эргүүлэн авдаг тогтолцоо, зээлээр өгөх буудайг нэрийдсэн үг ажээ. Чосөн-ий сүүл үед тариачдыг хамгийн их зовоож байсан зүйлсийн нэг нь зээлээр авсан буудайг эргүүлэн төлөх болон цэргийн хүнс бэлтгэх ажил байжээ. →환상(還上), 환자(還子), 환자미(還子米)

황국 신민화 정책, 皇國臣民化政策, **Эзэнт гүрний шинэ иргэн болгох бодлого** гэдэг нь Японы эзэн хаанд үнэнч зүтгэх түшмэл, ард түмнийг бий болгох бодлого юм. Японы империализм нь солонгосчуудыг дайн байлдаанд хүчээр дайчлах нь солонгосчуудыг устгах гэсэн бодлого байсан бөгөөд, “Солонгос” хэмээх үндэстний ард түмнийх нь эрхэм үзэл, мөн чанарыг үгүй хийхийн тулд “Япон, Солонгос бол нэг юм” гэсэн үзэл баримтлалыг сурталчилж, Японы эзэн хаант улсын харъяат болгох бодлого явуулжээ. Ингэхдээ Японы хаан, өвөг дээдэс, алдар гавъяа бүхий хүмүүсийг оршуулсан бунхан болох Жинжа сүм (신사)-д солонгосчуудыг мөргөхийг шаардаж улмаар албадан мөргүүлэх, сүсэглэхийг шаардаж, Японы эзэн хаанд үнэнч зүтгэхээ амласан тангараг цээжлүүлэх гэж оролдож байжээ. Мөн сургууль, төрийн байгууллагад солонгос хэлээр ярьж, бичихийг хориглон хүний овог нэрийг ч япон болгон солихыг тулгаж байжээ.

훈련도감, **нийслэлийг хамгаалах цэргийн анги** – Чосөн-ий үеийн таван цэргийн ангийн нэг бөгөөд нийслэл хотыг хамгаалах бууч, жадчин, харваач гэсэн гурван чиглэлээр бэлтгэгддэг байжээ. →도감(都監), 훈국(訓局)

훈민정음, 訓民正音, **Хүнминьжөным** гэдэг нь 1443 онд Чосөн улсын 4-р ван болох Сэжон ван, Мэргэдийн өргөө (집현전)-ийн эрдэмтдийн хамт бүтээсэн

солонгос бичиг үсэг бөгөөд, 17 гийгүүлэгч, 11 эгшиг бүхий нийт 28 үсэгтэй. Солонгосчууд эрт үеэс ханз үсгийг хэрэглэж ирсэн боловч ханзаар солонгос хэлийг илэрхийлэхэд их төвөгтэй байсан учир Сэжон ван Мэргэдийн өргөөний эрдэмтдээр авиалбарыг судлуулж, өөрсдийн хэл ярианд тохирсон үсэгтэй байх ёстой гэсэн түүний болон эрдэмтдийн хүчин зүтгэлээр Хүнминьжөным (훈민정음) үсэг бүтжээ. Чосөнъ улсын Сэжон вангийн 28-р он (1446)-д хүнминьжөным-ийг хэвлэн гаргаж, нийтэд тунхаглажээ. Хүнминьжөным нь шинжлэх ухааны үүднээс маш нарийн судалж зохиогдсон төдийгүй сурахад тун хялбар байсан тул ханз мэдэхгүй эгэл ардууд уншиж, бичих боломжтой болжээ. Мөн хэл яриагаа ч бичгээр илэрхийлэх боломжтой болсноор хэл бичиг, уран зохиолын хөгжилд онцгой амжилт олжээ. Мөн хүнминьжөным-ийг зохиосон цагаас эхлэн идэвхтэй хэрэглэж хэвшүүлэх тал дээр ихэд анхаарлаа хандуулж, “Тэнгэрт халих лууны дуу (용비어천가)”, “Мянган голын усан дахь сарны тусгалын дуу (월인천강지곡)” зэрэг бүтээлийг ханьгыл үсгээр хэвлэсэн бөгөөд, гүйцэтгэх захиргааны албыг хариуцсан доод албан хаагчдад энэхүү бичгийг зааж сурган, төрийн ажил хэрэг, бодлогыг ард иргэдэд танилцуулахад ашиглаж байжээ.

휴전협정, 休戰協定, **Дайны гал түр зогсоох гэрээ** нь дайтаж буй улс орнуудын хооронд байгуулах дайныг түр зогсоох агуулга бүхий гэрээ хэлэлцээр бөгөөд гурван жилийн хугацаанд үргэлжилсэн хоёр Солонгосын дайныг түр зогсоосон гэрээ үүний нэг жишээ болно. 1953 оны 7 дугаар сарын 27-ны өдөр хоёр улсын төлөөлөгч “Дайны гал түр зогсоох гэрээ”-нд гарын үсэг зурж Солонгосын дайн түр зогссон ажээ.